

МОНГОЛ ОРНЫ ЗЭРЛЭГ АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



МОНГОЛ ОРНЫ ЗЭРЛЭГ АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
И СИ ӨҮ-ЛЕГАСИ ХХК

ГАРЧИГ

1. УДИРТГАЛ.	3
2. МОНГОЛ УЛСЫН ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ҮНДСЭН ТОЙМ	6
2.1. Эрчим хүчний.6
2.2. Зам тээвэр7
2.3. Зэрлэг амьтны тархац байршил, нүүдлийн зам.8
3. ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БАЙГУУЛАМЖИЙН АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ХОЛБОГДОЛ.	11
3.1. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын шувуудад үзүүлэх сөрөг нөлөө	11
3.2. Төмөр замын болон авто замын дэд бүтцийн ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөө	19
4. ШУГАМАН ДЭД БҮТЦЭЭС ЗЭРЛЭГ АМЬТНЫГ ХАМГААЛАХ, ХАМГААЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ /Монгол Улсын шугаман дэд бүтцийн зэрлэг амьтанд үзүүлэх нөлөөлөл хамгаалалтыг үнэлж, тодорхойлох, зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийг байгуулахад төрийн байгууллагуудын чадавх дахь дутагдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилтыг хангах/.	25
4.1. Эрчим хүчний шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын өнөөгийн нөхцөл	26
4.2. Зам тээврийн шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын өнөөгийн нөхцөл	35
4.3. Дүгнэлт	44
4.4. Зөвлөмж	45
5. ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ .50	50
5.1. Монгол орны амьтны аймгийн хууль эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл	50
5.2. Эрчим хүчний хууль зүй эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл	51
5.3. Зам тээврийн хууль эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл.	55
6. ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН СУДАЛГАА	56
7. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.	109
8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.	116

НЭГ

УДИРТГАЛ

Дэд бүтцийн байгууламж бол аливаа улс орны хөгжлийн үндсэн суурь нь болж өгдөг. Тэр ч утгаараа дэлхийн өрсөлдөх чадварын тайланд улс орнуудын өрсөлдөх чадварыг 4 үндсэн хэсгээр хэмждэгийн нэг нь дэд бүтэц юм. Дэд бүтцийн цөм хэсгийг шугаман дэд бүтэц бүрдүүлдэг.

Шугаман дэд бүтэц хэмээх ойлголтод нэн тэргүүнд цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ), төмөр зам болон авто замыг хамруулдаг.

Манай оронд 100 шахам жилийн тэртээгээс шугаман дэд бүтцийн эхлэл тавигдсан бөгөөд 1950-1960-аад оноос хөгжил нь хурдсан, цар хүрээ нь өргөжин тэлснээр, улс орны хөгжил дэвшил, эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Ялангуяа чөлөөт эдийн засагт шилжсэн сүүлийн 30 гаруй жилд манай оронд шугаман дэд бүтцийн байгууламж нэн хурдацтай өргөжин тэлж, тус улсын бүх хот, сууриныг хамарсан эрчим хүчний нэгдсэн тогтолцоо, аймгийн төв, томоохон хотууд болон нийт сумдын бараг 1/3-ийг холбосон хатуу хучилттай авто зам, стратегийн ач холбогдолтой зарим бүс нутгийг хамарсан төмөр замын сүлжээнүүд бүрэлдэн бий болжээ.

Энэхүү шугаман дэд бүтэц нь нэг талаас улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд чухал хөшүүрэг болох хэдийн боловч нөгөө талаас хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх тэр дундаа зэрлэг амьтанд ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Уг нөлөөллийг бууруулахад олон улсын эрх зүйн эх сурвалж, дотоодын хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэр, стандарт болон эдгээр эрх зүйн орчныг хэрэгжүүлэх боловсон хүчний чадавх нь шугаман дэд бүтцээс хүрээлэн буй орчин тэр дундаа зэрлэг амьтанд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүжилт, захиалгаар **“МОНГОЛ ОРНЫ ЗЭРЛЭГ АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ”** хийх ажлыг байгаль орчны хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээ, судалгааны “И Си ӨҮ-Легаси” ХХК хийж гүйцэтгэн энэхүү тайланг боловсруулав.

Уг судалгааны ажлыг гүйцэтгэхэд судалгааны багт Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны ахлах шинжээч Гэрэлт-Од, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Н.Жамъянхүү, Х.Тэрбиш МУИС-ын Шинжлэх ухааны сургуулийн багш, судлаач, доктор профессор нар судалгааг гүйцэтгэхэд мэдээллээр хангаж оролцов.

Судалгааны ажлын зорилго

Монгол орны зэрлэг ан, амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн хууль, эрх зүйн орчныг үнэлж, байгальд ээлтэй шугаман дэд бүтцийн хамгаалалтыг хангах зөвлөмжийг хүргүүлэх үндсэн зорилтын хүрээнд “Байгаль хамгаалах тухай хууль”, “Амьтны тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”, “Эрчим хүчний тухай хууль” болон бусад хууль тогтоомжийн актуудад хэрэгжилтийн үр нөлөөний шинжилгээ хийж, санал зөвлөмж дэвшүүлэх, тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулахад ажлын зорилго оршино.

Түүнчлэн Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудад тус зохицуулалтууд туссан эсэх, хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид хэрэгжилтийг хангуулахын тулд авах арга хэмжээний зөвлөмж боловсруулахад тус ажлын зорилго оршино.

Судалгааны хамрах хүрээ

“МОНГОЛ ОРНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ” хийх судалгааг хийх ажлын хүрээнд дээрх компанийн судалгааны баг нь дөрвөн үндсэн бүлгийн хүрээнд судалгааг хийж тайланг боловсруулсан.

Үүнд:

1. Монгол Улсын шугаман дэд бүтэц, тэдгээрийн эрх зүйн орчны тойм судалгаа,
2. Шугаман дэд бүтцийн байгууламжийн амьтны аймагт үзүүлэх нөлөө, холбогдол,
3. Шугаман дэд бүтцийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, / Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаанд үндэслэн зэрлэг ан, амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн хууль, эрх зүйн орчныг үнэлэхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн тодорхой зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, нэмэлт өөрчлөлт оруулах, зөвлөмж боловсруулах, холбогдох стандартуудад хэрэгжилтийн үр дагаврын судалгаа шинжилгээ хийх/
4. Шугаман дэд бүтцийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боловсон хүчний чадавхын үнэлгээ зэрэг болно.

Судалгааны зүйл

Захиалагч талаас буюу Хөтөлбөрийн газрын нэрийн өмнөөс Хавсралт 1-д заасан ажлын удирдамжийн дагуу Монгол улсын шугаман дэд бүтцийн байгалийн нөөцийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр ан амьтдад ээлтэй байгаа эсэхийг холбогдох хууль тогтоомжид үндэслэн шугаман дэд бүтцийн эрх зүйн орчны үнэлгээ хийх, судалгаа, зөвлөмж боловсруулах даалгаврыг гүйцэтгүүлэхээр 2022 оны 11-р сарын 19-ний өдөр эцсийн хувилбарыг ирүүлсэн бөгөөд “Үр нөлөөний шинжилгээ”-ний тайлан, нэмэлт өөрчлөлт оруулах санал, зөвлөмж, судалгааг энэхүү Хавсралт 1-д заасан ажлын удирдамжид үндэслэн гаргаж, нэгдсэн тайланг бэлтгэлээ.

Судалгааны арга зүй, аргачлал

Түүнчлэн судалгааны баг нь судалгааг хийхдээ захиалагч байгууллагаас ирүүлсэн ажлын даалгаврын хүрээнд “Аргачлал батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр

дагаврын үнэлгээ хийх аргачлал”, баримт бичгийн дүн шинжилгээний арга, социологийн арга зэргийг хэрэглэн холбогдох баримт бичиг, судалгааны тайлангийн хүрээнд лабораторийн судалгааг хийсэн болно. Асуулгын, ярилцлагын аргыг хэрэглэхдээ тухайн төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, судлаач нартай уулзалтыг хийж, сэдвийн талаарх ойлголт, тухайн асуудал нь байгууллага, нэгжийн чиг үүрэг, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод орсон эсэх, тухайн хамаарах асуудлыг давхар гүйцэтгэж байгаа эсэх, хяналтын ажлыг хэрэгжүүлж байгаа эсэх, түүнчлэн сэдвийн ач холбогдол болон санал болгож буй асуудлын талаар ярилцлагыг хийж, санал солилцсон болно.

Мөн сэдвийн хүрээнд хамаарал бүхий төрийн байгууллагын стратеги бүтцийг судлан тухайн байгууллагын чиг үүрэгт шугаман дэд бүтцийн зэрлэг амьтанд үзүүлэх нөлөөлөл хамгаалалтыг үнэлж, тодорхойлох, зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийг байгуулах талаар чиг үүрэг байгаа эсэх, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх орон тоо байгаа эсэх талаарх судалгааг хийлээ.

Монгол Улсын шугаман дэд бүтцийн эрх зүйн орчныг үнэлж, зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн хамгаалалтыг хангах зөвлөмжийг гаргах лабораторийн судалгааг хийж, тайлан боловсруулахад тухайн судалгааны багт дараах хүндрэлтэй асуудал тулгарч байсан. Тухайлбал:

- Судалгааг хийх явцад хууль тогтоомжийн өөрчлөлт гарсан. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 6 дугаар сарын 17-ны өрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан бөгөөд уг хуультай уялдуулан 200 гаруй хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр батлагдан 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн орж эхэлсэн. Энэхүү өөрчлөлтөд Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай гэх мэт судалгааны объект болж байгаа хууль орсон,
- Төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт гарсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр нь өөрчлөгдөж 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын тогтоолоор байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн.
- Хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж, чиг үүргийг холбогдох яамнууд авсан өөрчлөлт хийгдсэн.

Дээрх хууль тогтоомж, баримт бичгийн өөрчлөлттэй холбоотойгоор асуулга, ярилцлагад оролцох албан тушаалтан нарын ажлын байр өөрчлөгдөх, чиг үүрэг өөрчлөгдөх, өөр газар, албан тушаалд шилжих, судалгааны объект буюу хууль тогтоомжид тулгуурлан хийсэн судалгааны үр дүн, өөрчлөгдөх, судалгааг дахин хийх, хугацаа алдах зэргээр хүндрэлтэй асуудал үүсэж байсан болно.

ХОЁР

МОНГОЛ УЛСЫН ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ҮНДСЭН ТОЙМ


2.1. Цахилгаан дамжуулах агаарын шугамын сүлжээ. Манай оронд өнгөрсөн зууны эхээр цахилгаан эрчим хүчийг ахуй амьдрал, үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад өргөн хэрэглэж эхлэв. Өнөөдөр цахилгаан эрчим хүч нь бидний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Цахилгаан станцад үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг хэрэглэгч рүү цахилгаан эрчим хүч дамжуулах агаарын шугамаар түгээдэг. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 киловольт (цаашид кВ гэнэ), 220кВ болон түгээх сүлжээний (6кВ, 10кВ, 15кВ, 35кВ) зориулалтаар байгуулдаг.

2022 оны байдлаар Монгол улсад 6-35 кВ-ын цахилгаан дамжуулах 28250 гаруй км урт агаарын шугам барьж байгуулжээ (1-р хүснэгт, 1-р зураг).


МОНГОЛ УЛСЫН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМЫН ХЭМЖЭЭ (ХҮЧИН ЧАДАЛ БА ЭЗЭМШЛЭЭР)

Хүснэгт 1

№	Цахилгаан дамжуулах агаарын шугамын үзүүлэлт	Төрийн эзэмшлийн шугамын урт /км/	Гадны буюу хувийн эзэмшлийн шугамын урт /км/	Нийт урт /км/
1	35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	9 418	973	10 391
2	15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	4006	509	4515
3	10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	7834	2530	10364
4	6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	2091	892	2983
5	Цахилгаан дамжуулах агаарын шугамын нийт урт	23349	4904	28253




Зураг 1. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээ
(Эх сурвалж: Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв. 2022.)



Зураг 2. Цахилгаан дамжуулах гол сүлжээ 2022 он


2.2. Төмөр замын сүлжээ. Төмөр зам бол Дэлхий дахинаа хүлээн зөвшөөрсөн, эх газрын тээвэрлэлтийн хамгийн хямд шийдэл болно. Монгол улсын нийт ачаа, бараа тээвэрлэлтийн 90% орчим нь төмөр замаар хийгддэг. Төмөр замын асуудлаар Монгол, ОХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээрийн дагуу Монгол улсын хойд хил Сүхбаатар өртөөнөөс урд хил Замын-Үүд өртөө хүртэлх 1120 орчим км төмөр замыг барьж 1955 онд ашиглалтад оруулсан байна. Энэхүү 1520мм-ийн өргөн царигтай, нэг урсгал бүхий үндсэн төмөр зам, түүнээс салбарласан бусад туслах болон салаа замуудыг нэмбэл нийтдээ 1500 гаруй км урттай сүлжээ болдог. Хойд, урд хилийг холбосон уг үндсэн төмөр замын дагуу 508 гүүр, 35 өртөө, 5 депо болон олон тосгон суурин байгуулжээ. Мөн Баянтүмэн-Эрэнцавын өргөн царигт, Хэрлэн-Тамсагбулагийн нарийн царигт 600 шахам км урттай төмөр замын барьж байгуулсан. (3-р зураг).



Зураг 3. Монгол улсын төмөр замын сүлжээний өнөөгийн байдал, ирээдүйн төлөв
(Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам. 2022)

2010 оны 06 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас төмөр замын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх зорилгоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Төрийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор “Шинэ төмөр замын төсөл”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд Тавантолгойн орд газраас урагш болон зүүн зүгт гэсэн замналаар БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч экспортын шинэ гарцуудыг бий болгоход чиглэсэн ойролцоогоор 3500 гаруй км урт төмөр замыг шинээр барьж сүлжээг өргөтгөхөөр төлөвлөжээ. Үүнд: Богдхан (145 км), Тавантолгой-Сайншанд (458 км), Сайншанд-Хөөт (433 км), Хөөт-Чойбалсан-Эрээнцав (365 км), Тавантолгой-Гашуун сухайт (267 км), Хөөт-Бичигт (230 км), Хөөт-Нөмрөг (380 км), Арцсуурь-Нарийн сухайт-Шивээхүрэн (1255) чиглэлийн төмөр замууд орж байгаа болно. Төмөр замын эдгээр төслийг 2030 онд багтаан бүрэн хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжсэнээр манай улсын төмөр замын сүлжээний нийт урт 5000 км хүрэх төлөвтэй байгаа юм (2-р зураг).

2.3. Авто замын сүлжээ. Монгол улсын үндэсний авто замын сүлжээний нийт урт 112000 орчим км (3 ба 4-р зураг). Үүнээс хатуу хучилттай авто замын сүлжээ жил бүр өргөжин тэлж, өдгөө бүх хот, аймгийн төв, 106 сум, хилийн таван боомтыг холбосон нийт 9000 гаруй км урт авто зам, гүүрний байгууламжаас бүрддэг байна (2-р хүснэгт).



Зураг 4. Монгол улсын авто замын сүлжээ


Монгол Улсын авто замын сүлжээ нь улсын чанартай 14,918.4 км, олон улсын чанартай 4.333,0 км, орон нутгийн чанартай 95.398,0 км, нийслэлийн 1.207,3 км, тусгай зориулалтын 1.057,6 км буюу нийт 112,893.8 км авто замтай байна. Олон улс, улсын чанартай авто замаас 7,551.5 км хатуу хучилттай зам эзэлж байна. Улсын хэмжээнд нийт 875 гүүрнүүд ашиглагдаж байгаа бөгөөд судалгааг доорх 1-3 дугаар хүснэгтээр үзүүлсэн болно.

Хүснэгт 2. Монгол улсын үндэсний авто замын сүлжээний урт, км-ээр (2022 оны жилийн эцсээр)

Авто замын төрөл	Улсын чанартай авто зам	Орон нутгийн чанартай авто зам	Тусгай зориулалтын авто зам
Ердийн хөрсөн зам	6603.1	93751.6	0
Сайжруулсан хөрсөн зам	304.7	393.0	0
Хайрган хучилттай зам	665.1	255.4	0
Хууу хучилттай зам	7345.8	1699.5	898.4
Бүгд	14918.7	96099.5	898.4



Зураг 5. Монгол улсын хатуу хучилттай авто замын сүлжээний өнөөгийн байдал, ирээдүйн төлөв (Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам, 2022)



Зураг 6. Монгол улсын авто замын сүлжээ
(Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яам. 2020 оны байдлаар)

Төрөл бүрийн ангиллын гүүрнүүд нь авто замын сүлжээний нэг үндсэн хэсэг болно. 2022 оны жилийн эцсийн байдлаар Монгол улс 386 ширхэг гүүртэй бөгөөд тэдгээрийн нийт урт 17.6 км. Үүнээс төмөр бетон гүүрний урт-16.2 км (331 ш), ган гүүр-0.3 (1 ш) км, модон гүүр-1.1 км (54 ш).

Хүснэгт 3

Гүүрийн төрөл	Тоо	Урт	Хувь
Нийт	875	37,849.5	
Төмөрбетон гүүр	513	27,697.3	57.7
Модон	353	8,484.7	39.7
Ган-төмөрбетон	10	1,655.6	1.1
Ган гүүр	1	12.0	0.1

Хүснэгт 4

Гүүрийн хэмжээ	Тоо	Хувь	Гүүрийн насжилт	Тоо	Хувь
≤ 10 м	233	26.6	1960 оноос өмнө	53	6.1
10 м -20 м	247	28.2	1960-1990 он	407	46.5
20-50 м	211	24.1	1991-2000 он	70	8.0
50 м - 100 м	87	9.9	2001-2010	166	19.0
100 м - 200 м	58	6.6	2011-2014 он	151	17.3
200 м ≤	38	4.3	2014 оноос хойш	29	3.3

ГУРАВ

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БАЙГУУЛАМЖИЙН АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ХОЛБОГДОЛ


3.1. Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын шувуудад үзүүлэх сөрөг нөлөө

3.1.1. Цахилгаан дамжуулах агаарын шугамын (ЦДАШ) улмаас шувуудад учрах эрсдэлийн үндсэн шалтгаан. Судалгааны мэдээ баримтаас үзвэл цахилгаан дамжуулах агаарын шугам нь зэрлэг ан амьтад ялангуяа шувуудад үлэмж хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг ажээ.

1. ЦДАШ-ын шонгууд нь махчин шувуудын үүрлэх төдийгүй нүүдлийн үедээ сууж амрах, идэш бологч амьтдаа алсаас ажиглах, өндрөөс ангуучлах, мөн бусад шувууд нүүдлийн үедээ сууж амрахад онцгой үүрэгтэй (Гомбобаатар, 2006; 2013; Kruger & Rooyen, 2000). Ийнхүү ЦДАШ-ын шонгууд нь хээрийн махчин шувуудын үүрлэхэд тохиромжтой биет мөн боловч бүтэц, хэлбэрийн боловсронгуй биш, тохиромжгүй байдал нь махчин болоод бусад шувуудын цахилгаан хүчдэлд цохиулж олноор эндэх шалтгаан болж, махчин шувуудын популяцид ноцтой аюул учруулдаг (Benson, 1981; Ferrer et al., 1991). Иймээс ихэнх улс орнууд энэхүү аюулаас сэргийлэх арга хэмжээг эрчимтэй эрэлхийлэн амжилттай хэрэгжүүлж байна.
2. Нүүдлийн болон махчин шувууд хавар, намрын нүүдэл болон үржлийн үедээ ЦДАШ-ын утас мөргөж эндэх явдал түгээмэл тохиолддог. Нисэх чадвартай бүх зүйлийн шувууд өндөр хүчдэлийн агаарын шугамын утас мөргөж энддэг. Ялангуяа үдшийн бүрэнхий, шөнө нисдэг, том биетэй, богино зайд нисэх чиглэл, хурдаа саах чадвар (маневрлах) муутай шувуудад эрсдэл их. АНУ-д ЦДАШ мөргөсний улмаас жил бүр 500,000-аас 1 тэрбум хүртэл тооны шувуу үхдэг байна (Hunting, 2002). Манай орны хувьд шувууд ЦДАШ мөргөж энддэг талаар судалгааны зарим бүтээл нийтлэгджээ (Болд, Тулгат, 2005; Harness et al., 2008; Нямбаяр нар, 2016; Nyambayar et al. 2020).
3. Өндөр хүчдэлийн цахилгаан шугамын ажилчид жил бүрийн 4-5-р сард өндөр хүчдэлийн мод, төмөр болон цементэн шон дээр үүрлэсэн идлэг шонхор, хон хэрээ, шилийн сарын өндөг, ангаахайтай үүрийг буулгаж хаядаг. Шон дээр үүрлэсэн шонхрын өндөгний эрсдэл их бөгөөд жил бүр олноор устгагдах ба нийт эндэгдлийн дотор 10.9% (min. 2, max. 12) байна. Энэхүү хүчин зүйлээс хамаарсан ангаахайн эндэгдэл нийт хорогдлын дотор харьцангуй өндөр буюу 24% (мин. 13, max. 17) байна. Энэ хүчин зүйлсийн нөлөөгөөр эндсэн бүх ангаахайн хорогдол зөвхөн байгалийн бус биет дээр үүрлэсэн хосуудын хувьд тохиолдоно (Гомбобаатар, 2013).

3.1.2. ЦДАШ-ын нөлөөнд өртөж эндсэн шувуудын зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн хамгааллын статус. Манай оронд ЦДАШ-ын шувууны аймагт үзүүлж буй нөлөө, үр дагаврыг нягтлан шалгах, хянах судалгааг 2000-аад оны эхэн үеэс нэлээд өргөн хүрээнд явуулснаар үлэмж хэмжээний мэдээ баримт хуримтлагдсан байна.

Тухайлбал, өндөр хүчдэлийн шугамыг шалгах, хянах судалгааг Монгол орны төвийн бүсэнд хамаарах Төв, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутагт өндөр хүчдэлийн дамжуулах сүлжээний 110, 220кВ, түгээх сүлжээний 6, 10, 15, 35кВ-ын шугамыг хамруулан 2007-2009 онд зохион байгуулжээ (Гомбобаатар, нар, 2012; 5-р зураг).



Зураг 7. Судалгааны талбайн нэр ба байршил (Гомбобаатар нар, 2012)

Газрын зургийн тайлбар: Судалгааны талбайн хар өнгө 220 кВ, хөх өнгө 110 кВ, ягаан өнгө 35 кВ, улаан өнгө 15 кВ, ногоон өнгө 10,6 кВ-ын өндөр хүчдэлийн шугам.

Судлаач Harness нар (2008) судалгааны талбай дахь шувуудын үхлийн эрчмийг өндөр хүчдэлийн шугамын нэг км тутамд эндэх шувуудын тоогоор тооцоолсон байна (шувуу/км). Өндөр хүчдэлийн түгээх сүлжээний 6, 10, 15, 35 кВ-ын нэг хэлхээт, өндөр хүчдэлийн дамжуулах сүлжээ буюу систем үүсгэгч сүлжээний 110 кВ-ын нэг хэлхээт ба 220 кВ-ын хоёр хэлхээт, нийт 1059 км үргэлжлэх шугамын дагуу хийсэн судалгаагаар, хүчдэлд цохиулж болон утас мөргөж эндсэн нийт 54 зүйлд хамаарах 948 бодгалийг илрүүлсэн байна (3-р хүснэгт).

3.1.3. Өндөр хүчдэлд цохиулж эрсэдсэн шувууд. Өндөр хүчдэлд цохиулж эндсэн нийт 24 зүйлийн 388 бодгалиас 13 зүйлийн 227 бодгаль нь өдөр болон шөнийн махчин шувууд байжээ. Эдгээр нь бүгд Нүүдлийн зүйлийн тухай конвенци (CMS), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (CITES)-ийн нэг (*Falco naumanni*) ба хоёрдугаар хавсралт (бусад зүйл)-д багтжээ. Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан дансны ховордлын үнэлгээгээр *Falco naumanni*

нь эмзэг (VU), *Falco cherrug* нь устаж болзошгүй (EN), *Aegyptius monachus* ховордож болзошгүй (NT) ангилалд багтана.

Хүчдэлд цохиулж эндсэн шувуудын дотор махчин шувуу 227 бодгаль (64.1%) (n=227, min.1, max. 66), харин бусад шувуу 161 бодгаль (35.9%) (n=160, min.1, max. 113) байна. Олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар ховор зүйлүүд нийт махчин шувуудын дотор 33% хүрч буйгаас үзвэл өндөр хүчдэлийн шугам нь ховор, ховордож буй махчин шувуудад сөрөг нөлөө ихтэй ажээ.

Судалгаанд хамрагдсан өндөр хүчдэлийн шугамын нийт уртыг шувууны хорогдолд харьцуулан үзэхэд, хамгийн бага утгаар хүчдэлд цохиулж болон утас мөргөж эндсэн шувууд 0.54 шувуу/км, харин зөвхөн хүчдэлд цохиулж эндсэн шувууд 0.38 шувуу/км, зөвхөн хүчдэлд цохиулж эндсэн махчин шувууд 0.21 шувуу/км тус байна.

Өндөр хүчдэлийн шугам дагуу хүчдэлд цохиулж болон утас мөргөж эндсэн 948 бодгаль шувууд нь 54 зүйлд хамаарч байгаа бөгөөд энэ нь Монгол орны шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 10 орчим хувийг эзэлнэ.

3.1.4. Шувуудын өндөр хүчдэлд цохиулах шалтгаан

А. Өндөр хүчдэлийн 6 ба 10КВ-ын шугам

Модон тулгуур, модон болон төмөр хөндлөвч, шаазан тусгаарлагч, аянга зайлуулагч, цахилгаан гүйдэл дамжуулагч төмөр утастай 6, 10 кВ-ын шугамын шонд шувууд нүүдлийн үедээ сууж амрах, өндрөөс ангуучлах, үүр засах үедээ хүчдэлд цохиулж үхэх нь дараах шалтгаантай. Үүнд:

1. Анкер болон салаалагч шонгийн оройн шаазан тусгаарлагчийг суурилуулдаг газардуулагчтай холбогдсон төмөр тавиур ба цахилгаан гүйдэлтэй утас хоёрыг шувуу холбож, "Гүйдэл дамжуулагч" болсноор хүчдэлд цохиулна (phase to ground) (8-р зургийн 1).
2. Шувууд завсрын, анкер, салаалагч шонгийн оройн хүчдэлтэй хоёр утсыг далавчаараа холбосны улмаас хүчдэлд цохиулж эндэнэ (phase to phase). Энэ үзэгдэл салаалагч болон анкер шонд харьцангуй илүү тохиолдох үзэгдэл бөгөөд энэ тохиолдолд шувууны бие ихээр түлэгдэнэ (8-р зургийн 2).



Зураг 8. 6 ба 10КВ-ын шонгийн бүтэц (1-phase to ground), (2-phase to phase)

3. Өндөр хүчдэлийн 15 кВ-ын шугам

Бетон тулгуур, төмөр хөндлөвч, шаазан тусгаарлагч, аянга хамгаалагч төмөр утас, цахилгаан гүйдэл бүхий 3 утастай 15 кВ-ын шугамын шонд шувууд нүүдлийн үедээ сууж амрах, өндрөөс ангуучлах, үүр засах үедээ хүчдэлд цохиулж үхэх нь дараах шалтгаантай.

Үүнд:

1. 8-р зургийн 1-т үзүүлсэн цэгүүд нь цахилгаан гүйдэлтэй холбогч утас (jumper) ба газардуулагчтай холбогдсон цемент тулгуурын доторх төмрийг шувуу холбосноор “Гүйдэл дамжуулагч” болон хүчдэлд цохиулдаг (phase to ground) болохыг харуулав.
2. Цахилгаан гүйдэлтэй утас ба газардуулагчтай холбогдсон төмөр хөндлөвч хоёрыг шувуу холбож, “Гүйдэл дамжуулагч” болсноор хүчдэлд цохиулна (phase to ground) (8-р зургийн 2).
3. Тас, бүргэд мэт том биетэй шувууд нь 8-р зургийн 3-т үзүүлсэнчлэн хүчдэлтэй хоёр утсыг далавчаараа холбосны улмаас хүчдэлд цохиулж эндэнэ (phase to phase). Гэхдээ энэ нь 15кВ-ын шугамд харьцангуй ховор тохиолдох үзэгдэл бөгөөд энэ тохиолдолд шувууны бие ихээр түлэгдэнэ.



Зураг 9. 15кВ-ын шонгийн бүтэц (1, 2-phase to ground), (3-phase to phase)

3.1.5. Өндөр хүчдэлийн шугамын утас мөргөж үхсэн шувуудын хорогдол. 2007-2009 оны судалгаагаар илэрсэн өндөр хүчдэлийн утас мөргөж эндсэн нийт 43 зүйлд хамаарах 561 бодгалийн дотор Монгол ногтруу (*Syrrhaptis paradoxus*) дангаар 407 бодгаль буюу 72.5% эзэлж байжээ.

Судалгаагаар өндөр хүчдэлийн 6 кВ-ын шугамд үхэл илрээгүй бөгөөд бусад шугамд утас мөргөж эндсэн шувуудын бодгалийн тоо ялгаатай хүчдэл бүхий шугам бүрд харилцан адилгүй байжээ. Үүнийг монгол ногтрууны 2008 оны намрын улирлын ер бусын нүүдэлтэй холбоотой хэдий ч, бусад зүйл шувуудын хувьд өндөр хүчдэлийн шугамын бүтэц (цахилгаан дамжуулах утасны тоо, утаснаас газар хүртэлх зай, шонгийн өндөр, шонгийн хоорондох зай, шонгийн хэлбэр), амьдрах орчны ялгаатай байдлаас тус тус шалтгаална хэмээн судлаачид үзсэн байна.

3.1.6. Өндөр хүчдэлийн 10 кВ-ын шугам. Дээр дурдсан судалгааны талбайд 2008-2009 онд 525 км замналаар нийт 418 км үргэлжлэх шугам дагуу судалгааг гүйцэтгэж өндөр хүчдэлийн шугамаас шалтгаалан эндсэн 9 зүйлийн 55 бодгаль илрүүлсэн байна. Эндсэн бодгалийн 92.7% 2008 он, 7.3% 2009 оны судалгаанд хамаарах бөгөөд монгол ногтруу дангаар 80% эзэлнэ.

3.1.7. Өндөр хүчдэлийн 15 кВ-ын шугам. Судалгааны талбай дахь энэ ангиллын 161 км үргэлжлэх цахилгааны шугамд 2007-2009 онд 16 зүйлд хамаарах 206 бодгаль утас мөргөж энджээ. Нийт эндсэн бодгалийн 80.1%-ийг монгол ногтруу дангаар эзэлсэн байна.

3.1.8. Өндөр хүчдэлийн 35 ба 110 кВ-ын шугам. Дээрх судлаачид 2008-2009 онд талбайд 548 км замналаар 245 км үргэлжлэх шугам дагуу утас мөргөж эндсэн 20 зүйлд хамаарах 270 бодгаль илрүүлжээ. Нийт эндсэн бодгалийн дотор говийн ногтруу 72.6% (2008 онд 168, 2009 онд 28) бол бусад зүйл 27.4% (2008 онд 24, 2009 онд 50) эзэлж байна.

Өндөр хүчдэлийн шугамын шонгоос 1.5-60 м хүртэлх зайд үхэл хорогдлын хувь (62.2%) их байгаа нь уг шон бусад бага хүчдэлийн шугамын шонгуудаас харьцангуй өндөр байдгаас шалтгаалах ба мөн шувууд нисэхдээ хээр орших өндөрлөг биетийг баримжаалан нисдэг гэж үзвэл хоорондоо 300 метрийн зайтай байрлах харьцангуй өндөр (13-14 м өндөртэй) шонгуудын нэгийг баримжаалан нисэж, шонгийн ойр орчимд илүү их утас мөргөж энддэг байх магадлалтай хэмээн үзжээ

3.1.9. Өндөр хүчдэлийн 220 кВ-ын шугам. Судалгааны талбайд 2008-2009 онд 180 км замналаар судалгааг гүйцэтгэж, утас мөргөж эндсэн 13 зүйлд хамаарах 20 бодгаль илрүүлсэн байна. Нийт эндсэн бодгалийн дотор өвөгт тогоруу 30%, (6 бодгаль)-ийг эзэлнэ.

3.1.10. ЦДАШ-тай холбоотойгоор эндсэн шувуудын эдийн засгийн үнэлгээ

Хээрийн судалгаагаар 2007, 2008 ба 2009 онд шалгасан 6, 10 кВ-ын 525 км шугамын хүчдэлд цохиулж үхсэн шувуудын дундаж тоог тухайн үед манай оронд баригдаад байсан нийт 4946 км урттай шугамд шилжүүлэн тооцоолбол нэг жилд дунджаар 247 бодгаль, 15 кВ-ын 281 км шугамын хүчдэлд цохиулж үхсэн шувуудын дундаж тоог тухайн үед баригдаад буй 2414 км урттай шугамд шилжүүлэн тооцоолбол нэг жилд дунджаар 783 бодгаль тус тус эндэж байна. Үүний дотор шилийн сар, идлэг шонхор, начин шонхор зэрэг олон улсын хэмжээнд ховордож, олон улсын конвенцийн жагсаалтад орсон шувууд олноор үхэж байгаа нь анхаарал татна.


Зөвхөн 15 кВ-ын өндөр хүчдэлийн шугамын хүчдэлд цохиулж 2007, 2008, 2009 онд эндсэн нийт шувуудыг Монгол улсын засгийн газрын 2005 оны 248-р тогтоолд заасан ан, амьтны экологи, эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан үнэлбэл дээрх хугацаанд хамгийн багаар 278,568,500 төгрөгөөр хэмжигдэх хохирол байгалийн баялагт учирчээ.

Хээрийн судалгааны 2007-2009 оны дүнд үндэслэн хүчдэлд цохиулж эндсэн махчин шувуудын дундаж тоог 2013 оны байдлаар баригдаад байгаа 6 болон 10кВ-ын 4946 км шугам, мөн 15кВ-ын 2414 км шугамуудаар тооцвол хамгийн багаар бодоход жил тутамд 510,168,870 төгрөгөөр үнэлэгдэх шувуудыг хөнөөж байна (Гомбобаатар нар, 2012).



Нөгөө талаас ЦДАШ-ын тасралтаас цахилгаан эрчим хүчний хэрэглэгч буюу иргэн, аж ахуйн нэгжид их хэмжээний хохирол учрахаар байна. “БЗӨБЦТС” ТӨХК-ийн хариуцдаг 15кВ-ын нийт 14 нэр бүхий 878.8 км ЦДАШ-ын тасралтын мэдээллээс үзэхэд 2010-2014 оны хооронд 371 удаагийн тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 84.4 хувь нь 5-10 сард болсон байна. Нийт тасралтын 63.5 хувь нь шувуунаас хамааралтай тасралт болсон байна. (ЦДАШ, дэд станцын төслүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн тайлан 2022 он)

Цахилгаан дамжуулах агаарын 10-15 кВ-ын шугамд шувуудад эрсдэлгүй ээлтэй байх, үхэж хорогдохоос сэргийлэх зорилгоор тулгуурын орой дээр шувуу суух боломжийг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурилуулах, мөн дүүжин хэлбэрийн ПС-70 маркийн тусгаарлагч суурилуулахад тавих техникийн шаардлагуудыг “MNS 6518:2015 “0.4 кВ-аас 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам барьж байгуулахад тавих шаардлага” стандартад мэргэжлийн байгууллага болон холбогдох эрдэмтэн судлаачдын саналыг үндэслэн 2021 оны 05 дугаар сарын 24-нд Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас тус стандартад нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан байна.


Энэ нь Монгол Улсад анх удаа эрчим хүчийг шувуудад ээлтэй байлгахад чиглэсэн сөрөг нөлөөллийг бууруулах Монгол Улсын хэмжээнд мөрдөх стандартын баримт бичиг болж байгаа юм. Ингэснээр цаашид цахилгаан дамжуулах агаарын шугам барихдаа энэхүү стандартад оруулсан нэмэлт өөрчлөлт болох D хавсралтын “Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлага”-ын дагуу барьж байгуулах юм. Монгол Улсын MNS 6518:2015 стандартын нэмэлт өөрчлөлтөд орсон “D” хавсралтад Завсрын болон анкер тулгуурын бүтцийг шувуудад ээлтэй байлгахад дараах зураг 2.2-2.4-д үзүүлсэн шаардлагуудыг тавьсан байна.



Зураг 10. Тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой болон цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурилуулж, II болон III фазад дүүжин тусгаарлагч ашигласан байдал



Зураг 11. Тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурилуулж, хөндлөвчийг цахилгаан дамжуулдаггүй материалаар бүрсэн байдал



Зураг 12. Анкер тулгуурын оройд шувуу суухыг хязгаарласан толгой, эсвэл цахилгаан дамжуулдаггүй тусгаарлагч бүрхүүл суурилуулж, дамжуулагч утасны холболтуудыг бүрээстэй кабелиар холбож, II болон III фазын холболтыг хөндлөвчийн доогуур байрлуулсан байдал

ЦДАШ-ыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагаар тусгаарлах материал нь -500C-аас +700C-ын температур болон 6, 10, 15 кВ-ын хүчдэлийг тэсвэрлэх чадвартай, 25-35 жилийн ашиглалтын хугацаатай, 40 м/с хүртэл салхинд тэсвэртэй, хөнгөн байх шаардлага тавигдсан байна.

Гэвч эрчим хүчний салбарын зарим цахилгаан түгээх дамжуулах төрийн өмчит үйлдвэрийн газруудад байгаль орчны буюу шувуу хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтны орон тоогүй, эрчим хүчний мэргэжлийн албан тушаалтан хавсарга байдлаар хариуцаж ажиллаж байна.

Тус албан хаагч нь шугамын тасралт, тусгаарлагч элемент бохирдуулах зэргээс хамгаалах чиглэлээр түлхүү ажиллаж, шувууг хамгаалах талаас чиг үүрэг хүлээж хэрэгжүүлэхгүй байгаа дутагдалтай байна.

Мөнсалбарын төрийн өмчит ажахуйн нэгж байгууллагууд болон хувийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын хууль биелүүлэх, байгаль орчны нөлөөллийг бууруулах ажил хийсэн байдал харилцан адилгүй байгаа нь анхаарах асуудал болсон байна.

Харин эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалттай түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч болох “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь 110/35/10кВ-ын Баруунхараа дэд станцын Яч№17 10кВ-н Сүмбэр АШ-ын тулгуур №1-240-н хооронд Р-15 тусгаарлагчид 672 ширхэг тусгаарлагчтай бүрхүүл, АС дамжуулагч утсанд 403 метр шувуу хамгаалах дамжуулагч утасны тусгаарлагчийг суурилуулсан байна.



Зураг 13. Шувуу тогонд цохиулахаас хамгаалсан бүрээс

Шувуу хамгаалагч хязгаарлагч толгой, дамжуулагчийн тусгаарлагчийг суурилуулснаар цахилгаан дамжуулах агаарын шугамд дараах давуу талууд бий болсон. Үүнд:

1. Хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын нөлөөллийн бүсэд шувууд өртөхгүй.
2. Цахилгаан дамжуулах агаарын шугамд шувуутай холбоотой тасралт гарахгүй.
3. Байгаль орчинд ээлтэй, шувууд үхэхгүй байх нөхцөл бүрдсэн

Иймд салбарын хувийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд нь хуулийн хэрэгжилт, байгаль орчин, шувуудад нөлөөлөх нөлөөллийг багасгах чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн уул уурхайн салбарын томоохон аж ахуйн нэгж байгууллага болох Оюу толгой ХХК нь байгаль орчин, шувуудад аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлж дэд станцын тоноглолууд болон ачаалал таслагч болон хуурай салгууруудтай тулгууруудад байршуулсан шувуу үргээгч байрлуулсан байна.

Шувуу үргээгчийг суурилуулснаар цахилгаан шугам сүлжээг шувуудад аюулгүй болгох, түүнтэй хамааралтай тасралт гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь судалгаа, мэдээллээр батлагдсан байна.

Хүснэгт 5. Шувуунаас хамааралтай цахилгаан шугам сүлжээний тасралтын давтамж

Огноо	2016	2017	2018	2019 5-р сар
Шувуунаас хамааралтай цахилгаан шугам сүлжээний тасралтын давтамж	11	6	4	0



Зураг 14. Дэд станцууд болон тулгууруудын 35кВ-ын хуурай салгууруудын хөдлөх болон үл хөдлөх контактуудад “Cover” хийсэн байдал.



Зураг 14. Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгууруудын буултын кабелиудад шувуу үргээгч өргөс суурилуулсан байдал



Зураг 15. Дэд станцуудын хөндлөвчүүд болон тулгууруудад дуут шувуу үргээгч байршуулсан байдал



Зураг 16. Дэд станцуудын хөндлөв хэсгүүдэд тольтой шувуу үргээгч суурилуулсан байдал

Дээрх шувуу үргээх тоноглол нь гэрлээр үргээх /хурц тод гэрлээр шувууг үргээх/, хэт авиагаар үргээх /дөрвөн чиглэлд хэт авиа үүсгэх/, буун болон бүргэдийн дуугаар үргээх гэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Эдгээр цахилгаан дамжуулах агаарын шугамын байгууламж дээр шувуу суухаас сэргийлэх, суусан шувуу тогонд цохиулахаас сэргийлэх стандартад заасан арга хэмжээг хэрэгжүүлснээр энэ бүлэгт дурдсан цахилгаан дамжуулах агаарын шугамаас шувуудад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах юм. Иймд цаашид шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын байгууламжийн зураг төслийг боловсруулах, хянан магадалгаа хийх, барилга байгууламжийг барих энэхүү стандартыг барих, мөн одоо хэрэглэж байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинээр батлагдсан стандартад нийцүүлэн засварлах ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна.

3.2. Төмөр замын болон авто замын дэд бүтцийн ан амьтад үзүүлэх сөрөг нөлөө


Төмөр зам, авто замын дэд бүтэц барьж байгуулсан болон шинээр байгуулахаар төлөвлөж буй нутгуудад Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенц (Convention on Conservation of the Migratory species of Wild Animals, CMS), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), Монгол улсын амьтны аймгийн тухай хуульд нэн ховор, ховор ангиллаар тус тус бүртгэсэн олон зүйлийн амьтад идээшин нутагшдаг байна. Тухайлбал, цоохор ирвэс (*Uncia uncia*), шилүүс (*Lynx lynx*), хүрэн баавгай (*Ursus arctos*), баданга хүдэр (*Moschus moschiferus*), цагаан зээр (*Procapra gutturosa*), хар сүүлт (*Gazella subgutturosa*), хулан (*Equus hemionus*) аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямаа (*Capra sibirica*), халиун буга (*Cervus elaphus*) зэрэг амьтад байршдаг.

Монгол Улс нь нүүдлийн зүйл амьтдын шилжилт хөдөлгөөн, нүүдэлд саад тотгор болохуйц аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ авах үүргийг олон улсын өмнө хүлээсэн. Ийнхүү олон улсын өмнө хүлээсэн үүргээ ханган, барьж байгуулсан авто болон төмөр зам, шинээр байгуулах төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх явцад нүүдлийн зэрлэг амьтад аль болох ээлтэй байх шийдэл, гарцыг олж хэрэгжүүлэх учиртай.

Авто болон төмөр зам зэрэг хуурай газрын тээврийн дэд бүтэц нь амьтны аймагт дараах гол хэдэн чиглэлээр сөрөг нөлөө үзүүлдэг байна.

3.2.1. Амьтдын тархац нутаг, амьдрах орчны хуваагдал. Монгол Улсын хойд хил Сүхбаатар өртөөнөөс Улаанбаатар-Замын-Үүд урд хил хүртэл нийт 1115 км төмөр замыг 1955-аад онд барьж, бүрэн хэмжээгээр ашиглалтад оруулснаар Ази-Европыг холбосон олон улсын төмөр замын тээврийн гол коридор, ачаа тээврээр Монгол Улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой салбар хэдий ч хамгаалалтын хориг хашаа нь Монгол Улсын босоо чиглэлд биологийн төрөл зүйлийн амьдрах орчны хувьд тасархайтуулж 2 хэсэгт хуваан тал хээрийн тууртан амьтад ялангуяа цагаан зээр хулан адуу, аргаль хонь, хар сүүлтийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлан, үхэл хорогдолд нөлөөлж байгааг судлаачдын 2013-2018 оны судалгаа, мониторингийн дүн харуулдаг. Энэ нь Монгол дахь цагаан зээрийн тоо толгой буурах үндсэн шалтгааны нэг болсон (Сосорбарам, 1966; Хрусталева нар, 1978; Schaller et al., 1999) гэж үздэг.

Энэ байдалд авто замын бүтээн байгуулалт тэр дундаа босоо тэнхлэгийн авто замын сүлжээ ч бас нэгэн адил нөлөө үзүүлсэн хэмээн үзэж болно.




Зураг 17. Сүхбаатар өртөө-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын зураг болон хулан, хар сүүлтий, цагаан зээрийн байршил

ШУА-ийн Биологийн хүрээлэн Японы эрдэмтэдтэй хамтран хэрэгжүүлсэн цагаан зээрийн урт хугацааны нүүдлийн судалгааны хүрээнд 2002-2012 оны хооронд Улаанбаатар-Замын-Үүдийг холбосон төмөр замын баруун болон зүүн талаас нийт 24 толгой цагаан зээр барьж байршлын мэдээлэл дамжуулагч хүзүүвч зүүж судалгаа хийсэн. Уг судалгааны үр дүнгээс үзэхэд хүзүүвчтэй амьтад улирлаас хамааран төмөр зам гарах оролдлого хийж байсан хэдий ч нэг нь ч төмөр замыг хөндлөн гарч чадаагүй байна. Үүнээс үзэхэд төмөр зам, түүний хамгаалалтын өргөст тор нь нүүдэллэдэг амьтад, цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарладаг байна (Лхагвасүрэн, 2021).

Хулангийн дэлхийд үлдсэн цөм популяцийн тархац нутаг одоогийн байдлаар дорнод этгээдэд Улаанбаатар-Замын-Үүд-Бээжин чиглэлийн төмөр замын өргөст торон хашаа нь энэ зүйл амьтны хамгийн том хуваагдалгүй үлдсэн сүүлчийн тархац амьдрах орчныг тасалж, хуваах уршигт хүргэсэн (Kaczensky et al., 2011) байна. Улаанбаатар-Замын-Үүд-

Бээжин чиглэлийн төмөр зам, замын хоёр талаар баригдсан өргөст тор нь хулангийн шилжилт, хөдөлгөөнд хамгийн том саад болж (Kaczynsky et al., 2011; Lkhagvasuren et al., 2011; Olson, 2012) байгааг дохиолол бүхий амьтдын шилжилт хөдөлгөөнд тулгуурлан тэмдэглэсэн байдаг.


Монгол орны тууртан амьтны тархац нутгийн ерөнхий байршил.



Зураг 18. Хулан, хар сүүлтий, цагаан зээр, аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг Монгол орны тууртан амьтны тархац нутгийн байршил (Байгаль орчин мэдээллийн сан www.eic.mn 2023 он)

Дээрх байршил зурагт цагаан зээр, хар сүүлтий, халиун буга, бөхөн зэрэг нэн ховор, ховор, элбэг амьтны тархац нутаг, нүүдлийн зам орсон болно. Тухайлбал, халиун буга, цагаан зээр, хулангийн тархац нутгаар Монгол Улсын авто замын босоо тэнхлэгийн авто болон төмөр зам дайран өнгөрдөг байна. Түүнчлэн 2022 онд баригдаад байгаа Тавантолгой-Гашуун сухайтын чиглэлийн төмөр замын маршрут нь хулан адуу, хар сүүлтийн тархац нутгийг голлон хуваан байгуулагдсан.

Цагаан зээр, хулан, халиун бугын тархац нутаг.




■ Халиун бугын тархац нутаг
■ Цагаан зээрийн тархац нутаг
■ Хулангийн тархац нутаг

Зураг 19. Хулан, халиун буга, цагаан зээрийн тархац нутаг (Байгаль орчин мэдээллийн сан www.eic.mn 2023 он)

Монгол Улсын хэмжээнд одоо байгаа болон 2025 он хүртэлх хугацаанд төлөвлөж буй төмөр замаас зэрлэг амьтдын байршил, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлсэн ажлын тайланд (Lkhagvasuren, et al, 2011.) дурдсанаар Цагаан зээрийн сүрэг 9 жижиг хэсэгт, Хулангийн сүрэг 5 жижиг хэсэгт, Хар сүүлтийн сүрэг 7 жижиг хэсэгт, Монгол бөхөнгийн сүрэг 2 жижиг хэсэгт тус тус таслагдан, хуваагдах эрсдэл үүсэж байгааг цохон тэмдэглэжээ. Иймд зэрлэг амьтдын нүүдэл, шилжилтийг чөлөөтэй нэвтрүүлэх гарц, гармын оновчтой төлөвлөлт, шийдэл гаргах зайлшгүй шаардлага гардаг.

Энэ саад тотгорыг арилгах хамгийн хялбар шийдлийн нэг нь одоо байгаа төмөр замын аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр төмөр замын өргөст торыг хэсэгчлэн чөлөөлөх, загвар, хийцийг өөрчлөх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа хулангийн тархац нутгийн хүрээнд төмөр замын торыг хэсэгчилсэн байдлаар (сумын төвөөс зайдуу, малчид цөөн нутагладаг эзлүүд газарт) буулгах явдал юм (Монгол орны байгаль орчин. 2017).

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын хамтарсан 2013 оны А192/145, 2016 оны А/93-74 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Улаанбаатар-Замын-Үүд хүртэлх төмөр замын дагуух хамгаалалтын өргөст торыг хэсэгчлэн авч, зэрлэг амьтны төмөр замыг аюулгүй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлж, холбоос нутаг бий болгохоор ажиллаж 2019 болон 2022 онуудад Дорноговь аймгийн Даланжаргалан, Алтанширээ, Өргөн сумын нутагт 3 байршилд 1500 метр хамгаалалтын хашааг авч, камерын мониторинг хийсэн байдаг. Мөн Дорноговь аймгийн Айраг, Өргөн сумын иргэдийн малд байршил тогтоогч зүүж, судалгаа хийхэд мөн торгүй хэсгээр төмөр зам гарсан байна.



Зураг 20. Ажлын хэсгийн хүрээнд тор авсан цэгийн байршил

Энэхүү мониторингийн мэдээгээр зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөн гарснаас гадна иргэдийн мал төмөр замын торгуй хэсгээр гарсан мэдээ байдаг. Хэдийгээр зэрлэг амьтны зэрлэг амьтны төмөр замыг аюулгүй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлж, холбоос нутаг бий болгож байгаа боловч малын шилжилт хөдөлгөөн зарим газар их байгаагаас хөдөлгөөний аюулгүй байдал (Зам тээврийн хөгжлийн яамны тайлан, мэдээ 2022 он)

3.2.2. Хамгаалалтын торноос үүдэлтэй амьтдын үхэл, хорогдол. Төмөр замын хамгаалалтын өргөст торон хашаа нь цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарладаг төдийгүй үхэл хорогдолд нөлөөлдөг маш том хүчин зүйл болох нь олон судалгааны дүнгээр батлагдсан байна (Лхагвасүрэн, 2000; Kaczensky et al., 2011; Ito et al., 2005; Olson, 2012; Buuveibaatar et al., 2016). Тухайлбал, 2005 оны 6-р сард хийсэн судалгаагаар Багахангайгаас Замын-Үүд хүртэлх төмөр замын өргөст торонд өлгөгдөж болон орооцолдож үхсэн нийт 241 цагаан зээрийн сэг зэмийг бүртгэсэн. 2016 оны 1,2-р сард ихэнх нутгаар их хэмжээний цас орсны улмаас зүүн аймгуудаас цагаан зээр баруун тийш нүүдэллэн төмөр замын торонд тулж улмаар 5000 гаруй зээр торонд өлгөгдөн, эсвэл ороогдон үхсэн байсныг хээрийн судалгаагаар тогтоосон (Лхагвасүрэн, 2021) байна. Энэ нь цагаан зээрийн улирлын нүүдэл шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, жил бүр олон тооны бодгалиуд төмөр замын өргөст торонд хашигдан үхэж хорогддогийн нэг баталгаа мөн.

3.2.3. Зэрлэг амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй хангахад чиглэсэн зөвлөмжийн үндсэн агуулга. Монгол Улсын хэмжээнд авто болон төмөр замын төлөвлөлтийн норм, стандартад зэрлэг амьтны нүүдэл, шилжилтийг чөлөөтэй нэвтрүүлэх бодлого байхгүйн улмаас шинээр баригдах авто болон төмөр замд зэрлэг амьтанд зориулсан гарцыг тооцож, төлөвлөх нь учир дутагдалтай байсан. Ийм учраас Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Зам, тээврийн сайдын хамтарсан тушаалаар зам, тээврийн салбараас байгаль орчин, амьтан тэдгээрийн амьдрах орчин, нүүдлийн замд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулж ажилласан байна. Ажлын хэсэг 2015 онд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515: 2015, 2018 онд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735: 2018 стандартуудыг боловсруулан батлуулсан нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчинтой уялдуулах чухал алхам болсон билээ.

УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд барьж байгуулахаар төлөвлөж буй шинэ төмөр замуудаас зэрлэг амьтны байршил, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд үүсэх сөрөг нөлөөг бууруулах боломжит хувилбарыг боловсруулах, зөвлөх үүднээс байгаль хамгааллын чиглэлээр Монгол Улсад тэргүүлэх байр суурьтай ажиллаж буй ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Дэ Нэйчэ Консерванси (TNC)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар хамтран судалгааны үндсэн дээр 4 зөвлөмж боловсруулан холбогдох яаманд хүргүүлсэн байдаг. Тэдгээр зөвлөмжид дараах үндсэн санааг тусгажээ. Үүнд:

1. Шинэ төмөр замуудыг хамгаалалтын торгуй барих.
2. Зайлшгүй хэмээн үзсэн тохиолдолд зөвхөн суурин, өртөө, зөрлөг орчимд төмөр замын хамгаалалтын тор татах.
3. Зэрлэг амьтан нэвтрэхэд зориулсан гарцыг 10 км тутамд төлөвлөн барих.
4. Зэрлэг амьтад хамгийн ихээр байршдаг буюу гарц, гарам байгуулах боломжит цэгүүдийг амьтан судлаач болон төмөр замын холбогдох хүмүүс хамтран трассын дагуу явж газар дээр нь нарийвчлан тогтоох.

5. “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515: 2015, “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018 стандартуудын дагуу тухайн бүс нутгийн газар зүйн байршил, газар нутгийн онцлогт тохируулан гүүрэн гарц, нүхэн гарч, нэг түвшний гарцыг стандарт хэмжээсний дагуу байгуулах ажлыг шаардлагын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх.

Тусгай зориулалтын авто зам, төмөр замын зураг төслийг боловсруулах явцад “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартын хэрэгжилтийг хангуулах, зэрлэг амьтадын байршил, нүүдлийн маршрут ихээхэн өөрчлөгдсөн, шинэ газар нутгуудад тэмдэглэгдэх болсон байгаа тул байршлыг шинэчлэн тогтоох, хамгаалах болон үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад онцгой анхаарч ажиллах.

Эдгээр санал зөвлөмжийг хэрэгжүүлснээр нүүдлийн зүйл амьтдыг бэлчээр, идэш тэжээл, ундны усны хомсдолд орохгүй байх, эсвэл ороо хөөцөлдөөн, үржил төлжил явагддаг нутагтаа чөлөөтэй шилжин очих, тэдний нүүдэлд саад тотгор болохуйц сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, арилгах, шилжилт, байршлыг алдагдуулахгүй байх, зэрлэг амьтад нэгээс нөгөөд чөлөөтэй шилжин бэлчээрлэх боломжоор хангагдах учиртай.

ДӨРӨВ

ШУГАМАН ДЭД БҮТЦЭЭС ЗЭРЛЭГ АМЬТНЫГ ХАМГААЛАХ, ХАМГААЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын шугаман дэд бүтцийн зэрлэг амьтанд үзүүлэх нөлөөлөл хамгаалалтыг үнэлж, тодорхойлох, зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийг байгуулахад төрийн байгууллагуудын чадавх дахь дутагдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилтыг хангах

4.1. Чадавхын үнэлгээ. Шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагын чадавхын үнэлгээг хийхдээ дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд асуулга, ярилцлага, баримт бичиг судалж анализ хийх аргыг ашиглан Эрчим хүчний яам, Зам тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төв, Авто тээврийн үндэсний төв, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ компани, Монгол Улсын Их сургууль зэрэг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн холбогдох байгууллагуудын нийт 60 гаруй албан хаагчтай хийлээ. Үүнд:

- Тухайлсан чиг үүрэгтэй,
- Албан тушаалтанд олгогдсон чиг үүрэгтэй
- Орон тоотой,
- Мэдлэг, мэдээлэлтэй,
- Эрх зүй орчин,
- Бичиг баримтын боловсруулалт,
- Хамтын ажиллагаа.

Хүснэгт 6. Чадавхын үнэлгээний оноо

	Шалгуур	Сул	Дунд	Сайн	Оноо
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	1	3	5	1-5 оноо
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй	1	3	5	1-5 оноо
3	Тухайлсан орон тоотой,	1	3	5	1-5 оноо
4	Мэдлэг, мэдээлэлтэй	1	3	5	1-5 оноо
5	Эрх зүйн орчин	1	3	5	1-5 оноо
6	Бичиг баримтын боловсруулалт	1	3	5	1-5 оноо
7	Хамтын ажиллагаа	1	3	5	1-5 оноо

Чадавхын онооны нийлбэр:

- o 0-10 оноо сул
- o 11-25 оноо дунд
- o 26-35 оноо сайн

4.2. Эрчим хүчний шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгааллыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын өнөөгийн нөхцөл

Монгол Улсад батлагдаж буй цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийг магадлал хийж баталгаажуулж буй төрийн өмчийн эрх бүхий 2 байгууллага, эрчим хүчний бодлогыг тодорхойлогч төрийн захиргааны төв байгууллага, эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлэгч 1 төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага байна. Үүнд:

1. Эрчим хүчний хөгжлийн төв,
2. Барилгын хөгжлийн төв,
3. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
4. Цахилгаан дамжуулах сүлжээ компани.

1. Эрчим хүчний хөгжлийн төв нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор байгуулагдсан ба үндсэн чиг үүрэг нь **эрчим хүчний зураг төсөлд магадлал хийх**, салбарын хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, техникийн хяналтыг гүйцэтгэх, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх үндсэн зорилтуудын хүрээнд байгуулагдсан байна. Мөн тус төвийг 2022 оны 318 дугаар тогтоолоор «Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв»-тэй нэгтгэн «Эрчим хүчний үндэсний төв» болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Эрчим хүчний үндэсний төв нь эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих **төсөл, хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийг барих ажлын зураг, төсөвт магадлал хийх**, шүүмж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, салбарын сургалтын хөтөлбөр, мэргэшлийн зэргийн аттестатчиллыг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, дулаанжуулалтын болон цахилгаан тоноглолд хяналт шинжилгээ хийх, сэргээгдэх эрчим хүчний зураг төсөл боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэдгээртэй холбоотой судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, засвар үйлчилгээ үзүүлэх, нарны зайн үйлдвэрлэл, угсралт, тохируулга хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Тус төв нь цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийн магадлалыг хийж гүйцэтгэхдээ Эрчим хүчний сайдын 2015 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам”-ын дагуу хийж гүйцэтгэж байна. Тус байгууллагын чиг үүрэгт тухайлбал байгаль орчны мэргэжилтэн, эсхүл энэ чиглэлд боловсон хүчин, ажиллах орон тоо, албан тушаал байхгүй байна. Гэвч тус байгууллагын чиг үүргээс үзэхэд цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга байгууламжийг шувуудад ээлтэй стандартын дагуу барьж байгуулах зураг төслийг хянан магадлалгааг хийх, стандартын шаардлага хангасан эсэхэд техникийн хяналтыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтыг хийх зэрэг голлох чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн дээрх байгууллагын чиг үүрэгт салбарын боловсон хүчний сургалтыг хийх, аттестачлал хийх зэрэг чиг үүрэг орсон байгаа нь тухайн байгууллагын боловсон хүчинд байгаль орчны


хууль тогтоомжийн сургалтыг хийх, стандартын шаардлагад нийцсэн зураг төслийг боловсруулах зэргээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд өндөр ач холбогдолтой байгууллага байна.

2. Барилгын хөгжлийн төв нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор байгуулагдсан ба Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөлд магадлал хийж, баталгаажуулж байна.

Барилгын хөгжлийн төвийн бүтэц орон тоог 2022 оны Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 309 дүгээр тогтоолоор үндсэн 177 ажилтан, гэрээт 10 буюу нийт 187 ажилтан албан хаагчтай байхаар баталсан байна.

Тус төв нь захиргаа удирдлага, санхүү, төсөл хөтөлбөр, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, барилга байгууламжийн захиалагч, нийтийн аж ахуйн, **сургалт, судалгаа мэдээлэл**, барилга байгууламжийн зураг төсөл магадлал, бүс нутаг, хот суурины төлөвлөлт, зураг төслийн хяналт, норм, норматив, барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори гэсэн нийт 12 бүтэц нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус төв нь Эрчим хүчний хөгжлийн төвтэй нэгэн адил чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал барилга байгууламжийн зураг төсөлд хянан магадлал хийх, салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг хийх зэрэг байна.

3. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компани.



Зураг 21. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн бүтэц.

Тус байгууллага нь цахилгаан эрчим хүч дамжуулах, 0,4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулгын ажил гүйцэтгэх, 0,4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, цахилгаан эрчим хүчний импорт (ОХУ, БНХАУ-аас),

мэргэжлийн сургалт явуулах, химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 10 хэлтэс, 1 төсөл хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар, Төвийн бүс, Хангайн бүс, Зүүн-Өмнөд бүс, Говийн бүс гэсэн орон нутгийн 5 салбартай үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани нь 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцаар Монгол улсын цахилгаан эрчим хүчний 80 орчим хувийг ханган ажилладаг.

Дээрх 3 байгууллага нь цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийг боловсруулах, баталгаажуулах явцад байгаль орчин тэр дундаа шувуудыг тогонд цохиулахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ямар нэгэн шийдэл, түүнийг магадлан баталгаажуулах асуудал орхигдож байна. Энэхүү орхигдож байгаа шалтгааныг судалгааны баг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Зураг төсөл боловсруулахдаа тэр бүр сонгох Монгол Улсын стандартыг зураг төсөлдөө тусгаж өгдөггүй. Холбогдох Монгол Улсын стандартын хувьд цахилгаан дамжуулах агаарын шугамаас шувуудад аюулгүй байлгах нөхцөл бүрдүүлэхтэй холбоотой тусгайлсан стандарт байхгүй бөгөөд харин "MNS 6518:2015 "0.4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах сүлжээний дэд өртөө, барьж байгуулахад тавигдах үндсэн шаардлага"-ын хавсралт D хэсэгт шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагыг сонгон хэрэглэж байна. Энэ стандарт нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар сонгон хэрэглэх стандарт бөгөөд өндөр хүчдэлийн байгууламжийг барьж байгуулахдаа дээрх стандартаас өөр стандартыг сонгон хэрэглэж болохоос гадна өндөр хүчдэлийн шугамын байгууламжийн зураг төслийг боловсруулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь байгаль орчны чиглэлийн ялангуяа шувуудыг өндөр хүчдэлийн шугамын аюулаас хамгаалах талаарх мэдлэг, мэдээлэл бага байдаг байна. Түүнчлэн мэдлэг мэдээллээ нөхөх боломжтой зөвлөх байгаль орчны мэргэжилтэн авч ажиллуулдаггүй, энэ чиглэлийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран ажилладаггүй байна. Иймд тухайн зураг төсөл боловсруулдаг хуулийн этгээдээс ирүүлдэг зураг төсөл нь дээрх стандартын хавсралтын D хэсгийн шувуудад ээлтэй байх техникийн шаардлагыг тусгаж ирүүлдэггүй байна.
- Хийгдсэн зураг төслийг хянах, баталгаажуулахдаа шувуудыг хамгаалах чиглэлээр анхаардаггүй байна. Дээрх 2 байгууллагын бүтцэд ажиллаж байгаа алба хаагч нарын зарим нь тэр бүр цахилгаан дамжуулах шугамд шувууд тогонд цохиулах аюулыг бууруулах чиглэлийн болон MNS 6518:2015 "0.4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах сүлжээний дэд өртөө, барьж байгуулахад тавигдах үндсэн шаардлагын хавсралтын D хэсгийн талаарх нарийвчилсан мэдлэг, мэдээлэл дутмаг байна. Нөгөө талаас дээрх стандартыг мэддэг боловч тэр бүр шувуудад ээлтэй байдлаар зураг зурагдсан эсэхийг магадлаад байдаггүй, зөвхөн үндсэн стандартын дагуу зурагдсан эсэхийг илүү анхаарч магадлалдаг байна.
- Эрчим хүчний хөгжлийн төвийн холбогдох албан хаагч нар нь зураг төсөлд магадлал хийхдээ дээрх стандартыг мэдэх бөгөөд магадлалдаа хэрэглэдэг боловч Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хуулийн талаар тэр бүр мэдэхгүй байна. Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн талаар ойлголт байгаа бөгөөд эрчим хүчний барилга байгууламж,

ялангуяа цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулахын өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх талаар мэдээлэлтэй байна. Гэвч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний ялгааг гаргаж, уг үнэлгээний алийг, хэзээ, хэн хийх талаар мэдэхгүй байсан. Энэ нь агаарын цахилгаан дамжуулах шугамын барилга байгууламжаас шувуудад нөлөөлөх нөлөөллийг ихэсгэж байгаа болно.

- Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв нь салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд сургалт, судалгааны ажлыг хийх хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлдэг боловч голлон эрчим хүч, барилгын салбарын хууль эрх зүйн орчны болон холбогдох бусад эрчим хүчний, барилга байгууламжийн чиглэлийн сургалтыг зохион байгуулан явуулдаг байна. Харин Барилгын хөгжлийн төв нь байгаль орчны үнэлгээний хууль эрх зүйн орчин, байгаль орчны үнэлгээний ойлголт, барилга байгууламжийн төсөлд хийгдэх байгаль орчны үнэлгээнд анхаарах асуудлын талаарх сургалтыг улиралд зарим үед тухай бүрд хийдэг сайн талтай байна. Энэ хүрээнд тухайн байгууллагын зарим албан хаагчийн энэ талаарх мэдлэг бусад байгууллагаас илүү байна. Энэ нь тухайн байгууллага нь нэгдүгээрт өөрсдийн боловсон хүчний байгаль орчны хууль тогтоомжийн чиглэлээр чадавхжуулах, хоёрдугаарт чадавхжуулах сургалтыг салбарын боловсон хүчний дунд тогтмол зохион байгуулж байх шаардлагатай байгааг харуулж байна.
- Зураг төсөлд магадлал хийхэд байгаль орчны хууль тогтоомж, ялангуяа шувуудад ээлтэй стандартын шаардлагыг хангасан өндөр хүчдэлийн байгууламжийн зураг төсөл байна уу гэдгийг зөвлөх, хянах чиг үүрэг бүхий хариуцсан мэргэжилтэнгүй, орон тоо байдаггүй байна.
- Эрчим хүчний сүлжээ компанийн албан хаагч ялангуяа хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагч нар нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон эдгээр хуультай уялдсан хариуцлагын механизмын талаар огт мэдэхгүй байна. Энэ нь нэг талаас цахилгаан дамжуулах агаарын шугамд байрласан шувууны үүрийг буулгах, устгах ажиллагааг явуулж байгаа нь байгаль орчинд үр дагаврыг үүсгэж байгаа, эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага хүлээх, экологид учирсан хохирол нөхөн төлөхөд хүрнэ гэдгийг мэдэхгүй байна. Тогтолцооны хувьд авч үзвэл анх зураг төслийг зохиох, хянан магадлалгааг хийх, барьж байгуулахдаа холбогдох стандартыг мөрдөж хийдэг бол энэхүү нөхцөл байдал үүсэх, цахилгаан тасалдах нөхцөл бүрдэхгүй гэдгийг ойлгохгүй байгаа нь энэ талын мэдлэг мэдээлэл сул байгаатай холбоотой байна.

Тиймээс цаашид цахилгаан дамжуулах агаарын шугамыг анхлан баригдах үе шатнаас буюу зураг төсөлд цахилгаан дамжуулах агаарын шугамд шувуудад нөлөөлөх сөрөг үр дагаврыг багасгах арга хэмжээг тусгах нь зүйтэй бөгөөд үүнийг тусгах, хянан магадлал хийхэд холбогдох байгууллагын боловсон хүчний мэдлэгийг дээшлүүлэх, түүнчлэн тусгайлсан орон тоог Эрчим хүчний үндэсний төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийг магадлал хийх нэгжид, мөн Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн зураг төсөл магадлал, эсхүл зураг төслийн хяналтын нэгжид байгаль орчны чиглэлийн орон тоог бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн энэхүү орон тооны дутагдалтай талыг энэ чиглэлийн судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, эсхүл хамтын ажиллагааны хүрээнд энэ чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгийн хүрээнд дутагдалтай талыг нөхөх боломжтой гэж үзэж байна.


Мөн эхний шатанд Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвийн алба хаагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн амьтныг хамгаалах хэлбэр, амьтныг хамгаалах иргэн, хуулийн этгээдийн үүрэг, хариуцлага, цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөллийн ерөнхий, нарийвчилсан үнэлгээ, төрөөс эрчим хүчний бодлогын баримт бичигт хийх стратегийн үнэлгээний ач холбогдол, анхаарах асуудал, зохицуулалтын талаар болон эрчим хүчний бодлого, цаашид баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын байршил зэрэгтэй уялдуулан шувуудын байршил, нүүдлийн зам, шилжилт хөдөлгөөний байршлын судалгаа мэдээллийг хүргэх нь зүйтэй байна.

Дараагийн ээлжид дээрх 2 байгууллагын салбарын боловсон хүчнийг сургах, чадавхжуулах чиг үүрэгтэй нь уялдуулан цахилгаан дамжуулах агаарын шугамаас шувуудад үзүүлэх нөлөөллийг бууруулах эрх зүйн орчин болон бусад дээрх нөхцөлийн талаар сургалтыг тогтмол хийж байх сургагч багш, холбогдох гарын авлагыг бэлтгэх шаардлагатай гэж судалгааны багаас тодорхойлж байна.

3. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд бүтэц орон тоог Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 94 дүгээр тогтоолоор батлагдсан байдаг.

Тус эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн дагуу 7 газартай байхаар тусгаж, 100 албан хаагчийн орон тоотой байхаар баталсан. Үүнд:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (сэргээгдэх эрчим хүчний хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);
2. Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (цахилгааны хэлтэс, дулааны хэлтэстэй);
3. Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
4. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэстэй);
5. Санхүү, хөрөнгө оруулалтын газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);
6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.
7. Салбарын хяналтын газар.



Зураг 22. Эрчим хүчний яамны бүтэц.

Мөн дээрх бүтэц зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтыг дараах байдлаар тусгасан байна.

Байгууллагын дээрх бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрөөс харахад Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах, төлөвлөлт хийх, хөгжүүлэх талаар тусгасан бөгөөд шинээр төлөвлөх, ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, сэргийлэх талаар зорилт, арга хэмжээг огт тусгаагүй байна. Гэсэн хэдий ч эрчим хүчний бодлого, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг зохицуулах, салбарын нэгдсэн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийх, аюулгүй байдлыг хангуулах стратегийн зорилтын хүрээнд эрчим хүчний байгууламжийн аюулгүй байдлыг хангуулах болон эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах, зохицуулах, эрчим хүчний салбарын бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, салбарын нэгдсэн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийж, зохицуулах, эрчим хүчний системийн найдвартай ажиллагаа, түүний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах, эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ, барилга байгууламжийн найдвартай ажиллагаа, түүний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах зэрэг зорилгыг хэрэгжүүлэх Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтэс байгаль орчны чиглэлийн мэргэжилтэн ажиллуулж, зорилт, зорилгыг хэрэгжүүлэх боломжтой юм.

Мөн цахилгаан дамжуулах агаарын шугамуудын ашиглалтын явцад зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын чадавхын үнэлгээг тодорхойлох, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл цуглуулах, тулгамдаж байгаа асуудлуудыг судлахаар 2022 оны 2 дугаар сарын 03-ны өдөр Эрчим хүчний яамны салбарын хяналтын газрын албан хаагч нартай уулзалтыг хийсэн.

Тус уулзалтаар цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын үйл ажиллагааг хариуцах төрийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудад тусгайлсан байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтан байдаггүй, мөн улсын хэмжээнд 22 кВт хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамуудад шувуу хамгаалах тоноглолтой эсэх, түүний ажиллагааны талаар тоон мэдээлэл судалгаа, мэдээллийн сан байдаггүй талаар төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчид мэдээлэл хийсэн.

Тодруулбал, эрчим хүчний салбарын цахилгаан түгээх дамжуулах төрийн өмчит үйлдвэрийн газруудад байгаль орчны буюу шувуу хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтны орон тоогүй, эрчим хүчний мэргэжлийн албан тушаалтан хавсарга байдлаар хариуцаж ажиллаж байна.

Тус албан хаагч нь шугамын тасралт, тусгаарлагч элемент бохирдуулах зэргээс хамгаалах чиглэлээр түлхүү ажиллаж, шувууг хамгаалах талаас чиг үүрэг хүлээж хэрэгжүүлэхгүй байгаа дутагдалтай байна.

Түүнчлэн төрийн захиргааны төв байгууллагын албан хаагч нар нь цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийх талаар, холбогдох стандартыг дагуу байгууламжийг барих, шувуу үргээгч, хамгаалагч байршуулах талаар мэдээлэлтэй байна. Харин Амьтны тухай хуульд заасан амьтныг хамгаалах хэлбэр, тэдгээрийн зохицуулалтын талаар огт мэдээлэлгүй байна.

Гаднын томоохон хөрөнгө оруулалтаар том чадлын агаарын шугам баригдахаас өмнө байгаль орчны нөлөөллийн судалгаа хийж, шувуу хамгаалах арга хэмжээг тусгадаг ба дотоодын улсын төсвөөр хийгдэж буй төсөл арга хэмжээний хувьд хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалан байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийдэггүй, зураг төсөлд тэр бүр хамгааллын арга хэмжээг оруулж өгдөггүй тухай дурдсан болно. Тухайлбал, салбарын төрийн өмчит аж ахуйн нэгжүүд тэр бүр хийдэггүй бол эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалттай түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч болох “Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь 110/35/10кВ-ын Баруунхараа дэд станцын Яч№17 10кВ-н Сүмбэр АШ-ын тулгуур №1-240-н хооронд Р-15 тусгаарлагчид 672 ширхэг тусгаарлагчтай бүрхүүл, АС дамжуулагч утсанд 403 метр шувуу хамгаалах дамжуулагч утасны тусгаарлагчийг зураг төсөл, суурилуулсан байна. Зураг 23



Зураг 23. Сайн туршлага. 110/35/10кВ-ын Баруунхараа дэд станцын Яч№17 10кВ-н Сүмбэр АШ-ын тулгуур №1-240-н хооронд Р-15 тусгаарлагчид 672 ширхэг тусгаарлагчтай бүрхүүл, АС дамжуулагч утсанд 403 метр шувуу хамгаалах дамжуулагч утасны тусгаарлагч

Эрчим хүчний салбарын дээрх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мэдээ, мэдээлэл үндэслэн төрийн байгууллагын чадавхын үнэлгээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Хүснэгт 7. Чадавхын үнэлгээний хүснэгт

	Шалгуур	Сул	Дунд	Сайн	Оноо
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	1			1 оноо
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй		3		3 оноо
3	Тухайлсан орон тоотой,	1			1 оноо
4	Мэдлэг, мэдээлэлтэй		3		3 оноо
5	Эрх зүйн орчин		3		3 оноо
6	Бичиг баримтын боловсруулалт	1			1 оноо
7	Хамтын ажиллагаа		3		3 оноо
“Дунд”					15 оноо

Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллага болон дээрх бусад байгууллагын бүтэц орон тооны хувьд байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах орон тоо болон чиг үүрэг байхгүй тул бага оноогоор үнэлэгдсэн. Хэдийгээр Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвд байгаль орчныг тэр тусмаа шувуудыг хамгаалах үндсэн чиг үүрэг байхгүй боловч цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга байгууламжийн зураг төслийг хянан магадлал хийх үндсэн чиг үүрэгтэйн хувьд шувуудад ээлтэй байгууламжийн стандартыг мөрдүүлэх хүрээнд зураг төсөлд хянан магадлал хийхдээ энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой тул “дунд» оноог өгсөн байна. Харин уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ шувуудад ээлтэй байх стандартыг бүрэн хэрэгжүүлэх талаарх анхаардаггүй тул дунд оноог өгсөн болно. Нөгөө талаас цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга байгууламжийг төрийн байгууллагаас барихдаа стандартын дагуу шувуудад хамгаалалт болох шаардлагыг мөрдөхгүй орхигдуулдаг бол хувийн компанийн зүгээс энэ стандартыг мөрдөж ажилласан байна. Эрх зүйн орчны хувьд уялдаа холбоо муутай, зарим зөрчил, хийдэл үүсгэдэг, талуудыг үүрэгжүүлсэн, хариуцлагажуулсан зохицуулалт хангалттай бус байгаагаас (Зургаадугаар бүлгээс үзнэ үү) гадна хэрэгжилт тэр бүр хангагдаад байдаггүй тул мөн дундаж оноогоор үнэлэгдсэн байна.

Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв зэрэг байгууллагын чиг үүрэгт салбарын боловсон хүчнийг давтан сургах, аттестачлал хийх талаар орсон байх тул салбарын боловсон хүчнийг байгаль орчныг хамгаалах холбогдох бодлого, Байгаль орчныг хамгаалах хууль, Амьтны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Зөрчлийн тухай хууль,

Иймд дараах сайжруулалт шаардлагатай байна. Үүнд:

Хүснэгт 7. Зөвлөмжийн хүснэгт

	Шалгуур	ЭХЯ	БХТ болон ЭХТ	ЦДСТӨК
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг нэмэх	Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх	Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй	Чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгах.	-	Чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгах.
3	Тухайлсан орон тоотой,	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх орон тоо бий болгох	Зураг төслийг магадлахдаа стандарт, техникийн зохицуулалтыг нягтлах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох	Зураг төслийг боловсруулахдаа стандарт, техникийн зохицуулалтыг анхаарч тусгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох
4	Мэдлэг, мэдээлэлтэй	Соён гэгээрүүлэх ажлыг хийх (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт)	Соён гэгээрүүлэх ажлыг хийх (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт)	Соён гэгээрүүлэх ажлыг хийх (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт)
5	Эрх зүйн орчин	Байгаль орчны бодлого, хууль тогтоомжтой уялдуулах, хэрэгжилтийг хангуулах	Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдүүлэх	Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдөн ажиллах
6	Бичиг баримтын боловсруулалт	Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Стандартын хэрэгжилтийг хангах, зураг төслийг хянан магадалгааг хийхдээ анхаарах	Стандартын хэрэгжилтийг хангах, зураг төслийн дагуу байгууламжийг барих, мониторинг хийх
7	Хамтын ажиллагаа	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх


4.2. Зам тээврийн шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын өнөөгийн нөхцөл

Монгол Улсад батлагдаж буй авто болон төмөр замын зураг төслийг магадлал хийж баталгаажуулж буй төрийн өмчийн эрх бүхий 1 байгууллага, зам, тээврийн бодлогыг тодорхойлогч төрийн захиргааны төв байгууллага, зам, тээврийн бодлогыг хэрэгжүүлэгч төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага байна. Үүнд:

1. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
2. Зам тээврийн хөгжлийн төв,
3. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж, байгууллага

1. Зам, тээврийн хөгжлийн яам дараах бүтэцтэй ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яаманд доорх бүтцийн зурагт үзүүлснээр нийт 8 газар, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Салбарын хяналтын газар нэмэгдэж, нийт 9 газартай үйл ажиллагааг явуулж байна. Эдгээр газруудаас Бодлого төлөвлөлтийн газар нь салбарын хөгжлийг дэмжсэн хууль тогтоомжийн төсөл бодлого, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оновчтой хуваарилах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төсөв төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын стандарт, норматив, техник, технологийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хэрэгжүүлдэг газар бөгөөд нийт 25 ажилтантай 4 хэлтэстэй ажилладаг.



Зураг 24. Зам тээврийн яамны бүтэц.

Энэ газарт Мэдээллийн технологи, стандартын хэлтэс салбарын стандарт, норм нормативыг боловсронгуй болгох үйл ажиллагааг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын шинжлэх ухаан, техник, технологийг хөгжүүлэх, боловсронгуй болгох, нутагшуулах үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах асуудлыг хариуцан ажилдаг бөгөөд 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тус хэлтсээс Зам, тээврийн үйл ажиллагаанаас байгаль орчин, амьтан, тэдгээрийн амьдрах орчин, нүүдлийн замд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн орчин, стандарт, норм, дүрэм журмыг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээний ажилд зөвлөмж, чиглэл өгч, бусад төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилдаг.

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, стандарт, норм, нормативыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулахад чиглэсэн ажлыг зохион байгуулж, 1 хэлтэс 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, төмөр замын тээврийн салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон төмөр замын тээврийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах чиг үүрэгтэй бөгөөд 18 хүний бүрэлдэхүүнтэй 2 хэлтэстэй ажиллаж байна.


Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолын дагуу мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжсэнтэй холбогдуулан тус яаманд зам, тээврийн салбарын хяналтын бодлого, зорилтыг тодорхойлж, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх Салбарын хяналтын газрыг 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус газарт авто зам, төмөр зам, усан зам болон автотээврийн чиглэлээр хяналтыг хэрэгжүүлж байна.

Зам, тээврийн хөгжлийн яаманд Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ажиллаж байгаа албан хаагчид тухай бүр хариуцсан чиглэлийн дагуу ажиллаж байгаа бөгөөд газрын асуудал хариуцсан мэргэжилтэн зэрлэг амьтдын амьдрах шилжилт, нүүдлийн асуудал давхар хариуцаж байна.

Харин авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тухайлан хариуцсан албан тушаалтан байхгүй байгаа бөгөөд зураг төсөл, төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэнд давхар хариуцуулсан байна.

3. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтэс 14, Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтэс 11, Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтэс 12, Эрдэм шинжилгээний алба 7, Авто замын итгэмжлэгдсэн лаборатори 15, Авто замын ашиглалтын хэлтэс 14, Барилга угсралтын хяналтын хэлтэс 5, төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс 9 үндсэн ажилтантай үйл ажиллагааг явуулж байна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ дараах бүтэцтэй ажиллаж байна.



Зураг 25. Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын бүтэц.

Тус төвийн Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтэс нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Авто зам, замын байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Авто замын салбарын стандарт, норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, стандарт, норм норматив боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах;
- Салбарын үнэ бүрдлийн тогтолцоог боловсронгуй болгож, авто зам, замын байгууламжийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Салбарын стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, зураг төслийн чанарыг сайжруулах, магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Салбарын шинжлэх ухаан, техникийн ололт, шинэ техник, технологи, инженерийн шийдэл бүхий асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтэс нь Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг нэгтгэн хөтлөх, нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглалтын түвшнийг тогтоох, иж бүрэн судалгаа хийх, ээлжит болон их засварын ажлын тоо хэмжээ хугацааг тодорхойлох, эрдэм шинжилгээ судалгаа, шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх, нутагшуулах, гадаад харилцааг бэхжүүлэх зорилготой ажилладаг байна.

Тус хэлтсээс Монгол Улсын авто замын орон зайн мэдээллийн сан боловсронгуй болгох, байнгын баяжилт хийдэг.

Түүнчлэн жилд 4 удаа олон улс, улсын чанартай авто замуудын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн судалгааг 58 цэгт авто зам хариуцагч компаниуд болон төлбөр авах цэгүүдийн хяналтын камерын бичлэгийг ашиглан гүйцэтгэж гарагдаг.

Хөдөлгөөний эрчим нь Авто замын сүлжээг хөгжүүлэх, Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, Замын нэвтрүүлэх чадварыг тодорхойлох, Замын байгууламжийн засварын ажлын дарааллыг тогтоох, Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд үндсэн өгөгдөл болдог.

Тус төвийн Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтэс нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

- Авто зам, замын байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Авто замын салбарын стандарт, норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, стандарт, норм норматив боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах;
- Салбарын үнэ бүрдлийн тогтолцоог боловсронгуй болгож, авто зам, замын байгууламжийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Салбарын стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, зураг төслийн чанарыг сайжруулах, магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Салбарын шинжлэх ухаан, техникийн ололт, шинэ техник, технологи, инженерийн шийдэл бүхий асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аас 2015 оноос нийт 1603 зураг төсөлд магадлал хийсэн бөгөөд 14 зураг төсөл, ТЭЗҮ-д зэрлэг ан амьтан гаргах гарц төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 8. Зэрлэг амьтан зориулсан гарц гарам байгуулсан авто замын зураг төсөл

№	Он	Магадлал хийсэн зураг төслийн тоо	Зэрлэг ан амьтан гаргах гарц төлөвлөсөн зураг төслийн тоо
1	2015	40	0
2	2016	71	3
3	2017	71	1
4	2018	151	0
5	2019	206	3
6	2020	262	2
7	2021	252	3
8	2022	506	1
9	2023	44	1
10	Дүн	1603	14

Тухайлбал:

- 2016 онд Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км, Дорнод аймгийн Хэрлэн сумаас Баянхошуу боомт чиглэлийн хатуу хучилттай 323 км, Дорнод аймгийн Ульхан боомт Хэрлэн сум чиглэлийн 233.4 км авто замын зураг төсөл,
- 2017 онд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын шинэчлэлтийн зураг төсөл,

- 2019 онд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажлын зураг төслийн өөрчлөлтийн 1-р үе шатны ажлын зураг төсөл,
- Өмнөговь аймаг, Ханхонгор сум, Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс Цагаандэл уул хилийн боомт хүртэлх 264.4 км авто замын төсөл,
- Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны ажил
- 2020 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлд хийсэн тодотголын ажлын тайлан, Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын зураг төсөл,
- 2021 онд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 112 дахь км орчмоос Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг, Загдал баг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай суурин, Дархан-Эрдэнэт чиглэлийн улсын чанартай авто замын Орхон сумын уулзвартай холбох 92.13 км авто замын зураг төсөл, Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн 487.73 км авто замын зураг төсөл, Хэнтий аймгийн Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн 145.73 км авто замын зураг төсөл,
- 2022 онд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн ажлын зураг төслийн 2-р үе шатны ажлын хүрээнд нэмэлтээр хийгдэх 3 цэгт туннелийн зураг төсөл,
- Өмнөговь аймаг, Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 144 км хатуу хучилттай авто замын зураг төсөл зэрэг хамрагдсан.

Дээрх судалгаа мэдээлэл нь нэг талаас суурин газар дотор зураг төслийн тоо мэдээ орсон боловч нөгөө талаас орон нутгийн замын зураг төсөл нь тодорхой хувийг эзэлж байгаа бөгөөд орон нутгийн замын төслийн зураг төсөлд зэрлэг амьтанд зориулсан нүхэн гарц, гармыг Монгол Улсын холбогдох стандартын дагуу тогтоож өгөх нь учир дутагдалтай гэж үзэхээр байна.

Түүнчлэн авто замын болон төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулахад байгаль орчны ерөнхий үнэлгээг зураг зохиогчийн зүгээс хийлгэдэг бөгөөд барилга угсралтын ажил эхлэхэд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж үйл ажиллагааг явуулж байгаа гэх боловч ихэнх тохиолдолд, ялангуяа улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх авто болон төмөр замын төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, дүгнэлтийг гаргадаг байна. Энэ нэг талаас хөрөнгийн асуудал байдаг боловч зарим тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх хуулийн зохицуулалтыг сайн мэддэггүйтэй холбоотой юм. Судалгааны явцад холбогдох албан тушаалтантай ярилцлага хийхэд авто болон төмөр замын зураг төслийг боловсруулах, төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх талаар мэдээлэлтэй байгаа боловч уг үнэлгээг төслийн аль үе шатад хийх, хуулийн ямар зохицуулалттай болох, үнэлгээ хийлгэсний ач холбогдол зэргийг мэдэхгүй байна. Харин авто болон төмөр замд зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөн, нүүдлийн замд зориулсан гарц, гармын байгууламжийн стандартын талаар шат шатны байгууллагын албан тушаалтан нар мэдээлэлтэй байхаас гадна судалгааны байгууллагаас тухайн авто болон төмөр замын төсөл хэрэгжих газрын зэрлэг амьтны тархац, шилжилт хөдөлгөөн, нүүдлийн замын байршлыг тодорхойлж өгвөл зураг төсөл боловсруулах явцад гарц, гармын байршлыг тусгах, баригдах явцад хяналтыг тавих боломжтой талаар мэдээлж байсан.

4.2.2. Хамтын ажиллагаа. Зам тээврийн хөгжлийн яамнаас төмөр зам, автозамд зэрлэг амьтны гарц, гармын стандартыг боловсруулах батлуулах, зураг төсөл боловсруулах, төмөр замын торон хашааг авах, мониторинг судалгааг хийх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэл дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар төмөр зам ХНН, Тавантолгой төмөр зам ХХК, Зүүнбаян төмөр зам ХХК МУИС, ШУА-ын Биологийн хүрээлэн болон төрийн бусад холбогдох байгууллага, төрийн бус байгууллага (Дэлхийн байгаль хамгаалах сан WWF, Байгаль, зэрлэг амьтадыг хамгаалах нийгэмлэг WCS) зэрэг байгууллагатай хамтран ажилладаг байна.

Тухайлбал, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, ШУА-ын Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сангийн монгол дахь хөтөлбөрийн газар гэх мэт байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээс 2015 онд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515: 2015, 2018 онд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735: 2018 стандартуудыг боловсруулан батлуулсан байдаг.

Түүнчлэн Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын хамтарсан 2013 оны А192/145, 2016 оны А/93-74 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Улаанбаатар-Замын-Үүд хүртэлх төмөр замын дагуух хамгаалалтын өргөст торыг хэсэгчлэн авч, зэрлэг амьтад төмөр замыг аюулгүй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлж, холбоос нутаг бий болгохоор 2019, 2022 онуудад ЗТХЯ, БОАЖЯ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Замын 4-р анги, мэргэжлийн байгууллагуудтай хамтран шилжилт хөдөлгөөний эрчимтэй цэгүүдийн судалгаанд үндэслэн төмөр замын торон хашааг тодорхой байршлуудад буулгах, мониторинг хийх ажил хийгдэж байна.

Зам, тээврийн салбарын дээрх төрийн байгууллагын мэдээ, мэдээлэл, ярилцлага, асуулгын мэдээлэлд үндэслэн төрийн байгууллагын чадавхын үнэлгээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Хүснэгт 9. Чадавхын үнэлгээний хүснэгт

Д/д	Шалгуур	Сул	Дунд	Сайн	Оноо
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	1			1 оноо
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй		3		3 оноо
3	Тухайлсан орон тоотой,	1			1 оноо
4	Мэдлэг, мэдээлэлтэй		3		3 оноо
5	Эрх зүйн орчин		3		3 оноо
6	Бичиг баримтын боловсруулалт	1			1 оноо
7	Хамтын ажиллагаа			5	5 оноо
“Дунд”					17 оноо


Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллага болон дээрх бусад байгууллагын бүтэц орон тооны хувьд байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах тусгайлсан орон тоо болон чиг үүрэг байхгүй боловч газрын асуудал хариуцсан мэргэжилтэн нь хавсран гүйцэтгэдэг тул байгууллагын чиг үүрэгт бага оноо, харин албан тушаалын чиг үүрэгт дунд оноогоор үнэлэгдсэн.

Хэдийгээр тусгайлсан чиг үүрэг байхгүй боловч эрчим хүчний салбарыг бодвол хариуцсан яаманд нэг албан хаагч нь байгаль орчны мэргэжилтний чиг үүргийг хавсран гүйцэтгэдэг давуу талтай байна. Түүнчлэн Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь авто болон төмөр замын барилга байгууламжийн зураг төслийг хянан магадлал хийх үндсэн чиг үүрэгтэйн хувьд зэрлэг амьтны гарц, гармыг холбогдох стандартыг мөрдүүлэх хүрээнд зураг төсөлд хянан магадлал хийхдээ энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой тул “дунд» оноог өгсөн байна. Харин уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ стандартыг бүрэн хэрэгжүүлэх талаарх анхаардаггүй нь авто замын зураг төсөлд гарц, гармын стандартын дагуу зураг төслийг боловсруулсан тоо мэдээллээс харагдаж байх тул дунд оноог өгсөн болно. Эрх зүйн орчны хувьд нийтлэгээр уялдаа холбоо муутай, зарим зөрчил, хийдэл үүсгэдэг, талуудыг үүрэгжүүлсэн, хариуцлагажуулсан зохицуулалт хангалттай бус байгаагаас (Зургаадугаар бүлгээс үзнэ үү) гадна хэрэгжилт тэр бүр хангагдаад байдаггүй тул мөн дундаж оноогоор үнэлэгдсэн байна. Харин Зам, тээврийн хөгжлийн төв нь өөртөө эрдэм шинжилгээний хүрээлэнтэй тул зэрлэг амьтанд зориулсан гарц гармын стандартыг боловсронгуй болгох, энэ стандартыг техникийн зохицуулалт болгон өөрчлөх, нүүдлийн зам, шилжилт хөдөлгөөнийг байршлыг тогтоох талаар судалгаа, мониторинг хийх бүрэн боломжтой гэж үзэж байна. Энэ чиглэлээр мөн холбогдох яам, агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах, өргөжүүлэх боломжтой байна. Иймд дараах сайжруулалт шаардлагатай байна. Үүнд:

Хүснэгт 11. Зөвлөмжийн хүснэгт

Д/д	Шалгуур	ЗТХЯ	ЦДСТӨК
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг нэмэх	Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй	Чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгах.	Чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгах.
3	Тухайлсан орон тоотой,	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх орон тоо бий болгох	Зураг төслийг боловсруулахдаа стандарт, техникийн зохицуулалтыг анхаарч тусгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох
4	Мэдлэг, мэдээлэлтэй	Соён гэгээрүүлэх ажлыг хийх (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт)	Соён гэгээрүүлэх ажлыг хийх (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт)
5	Эрх зүйн орчин	Байгаль орчны бодлого, хууль тогтоомжтой уялдуулах, хэрэгжилтийг хангуулах	Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдөн ажиллах
6	Бичиг баримтын боловсруулалт	Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Стандартын хэрэгжилтийг хангах, зураг төслийн дагуу байгууламжийг барих, мониторинг хийх
7	Хамтын ажиллагаа	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин аялал, жуулчлалын яам нь “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2020 оны 71 дүгээр тогтоолоор (Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор нэмэлт орсон) 8 газар, 4 хэлтэстэй, нийт 129 албан хаагч байхаар тогтоон үйл ажиллагаа явуулж байна.



Зураг 24. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтэц.

Тус яам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Ерөнхий чиг үүргийн яам” болсон бол 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр “чиг үүргийн яам” болон өөрчлөгдсөн байдаг. Тухайн яам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд зааснаар “Ерөнхий чиг үүргийн яам” байснаар байгаль орчны бодлого шийдвэрийг бусад яам, агентлаг дагаж мөрдөх, бусад салбарын бодлого, шийдвэрт байгаль орчны бодлого шийдвэрийг тусгах, уялдуулах зэрэг эрх хэмжээ, ач холбогдолтой байсан.

Тодруулбал, салбарын бодлого (Төрөөс авто замын талаар баримтлах бодлого, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого)-д байгаль орчны бодлогыг тусгуулах, бодлогыг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалтыг бий болгодог.

Харин Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь “чиг үүргийн яам” болсноор дээрх эрх хэмжээгээ алдсан болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн чиг үүрэгт байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах бодлогыг тодорхойлох, уг бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиг үүрэг нь Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газар, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын чиг үүрэгт орсон.

Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газарт амьтны аймгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглалтын бодлогыг төлөвлөх чиг үүрэг нь байгаль орчны бодлого төлөвлөлт хариуцсан албан тушаал дээр хавсарга байдлаар хийгддэг бол Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газарт амьтны аймгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглалтын бодлого зохицуулалт хариуцсан 2 албан хаагчийн орон тоотой ажиллаж байна.

Тус яам бусад яамд болон салбараас илүү чиг үүргийг дагасан орон тоо байгаа боловч байгаль орчныг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй яамны хувьд орон тооны талаас дутагдалтай байдаг. Хэдийгээр бодлогын асуудлыг тус яамны бодлогын газар хариуцахаар чиг үүргийг хуваарилсан боловч Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар бодлого болон бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг давхар хариуцан ажилладаг байна. Энэ нь чиг үүргийн зохимжтой харьцаа алдагдах, ачааллын хэт давамгайл байдлаас болж, зарим зохицуулалтын бодлого алдагдах хор уршигтай.

Дээр дурдсан мэдээ, мэдээлэл болон ярилцлагыг үндэслэн төрийн байгууллагын чадавхын үнэлгээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Хүснэгт 12. Чадавхын үнэлгээ

Д/д	Шалгуур	Сул	Дунд	Сайн	Оноо
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,		3		3 оноо
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй			5	5 оноо
3	Тухайлсан орон тоотой,		3		1 оноо
4	Мэдлэг, мэдээлэлтэй		3		3 оноо
5	Эрх зүйн орчин		3		3 оноо
6	Бичиг баримтын боловсруулалт		3		3 оноо
7	Хамтын ажиллагаа			5	5 оноо
	"Дунд"				23 оноо

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчныг ялангуяа зэрлэг амьтныг хамгаалах үндсэн чиг үүрэг нь тухайн байгууллага болон Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар, холбогдох албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгаж, Төрийн албаны зөвлөлөөр батлуулсан байна. Харин "ерөнхий чиг үүргийн" яамнаас "чиг үүргийн" яам болсноор бусад яамны бодлого шийдвэрт байгаль орчны бодлого шийдвэрийг тусгуулах чиг үүргийг алдсан тул бүрэн оноо өгөөгүй байна.

Мөн авто болон төмөр зам, эрчим хүчний барилга байгууламжийн стандартыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь дангаараа зэрлэг амьтанд ээлтэй болгож өөрчлөн боловсруулах боломжгүй болох бөгөөд зөвхөн хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгэх болно.

Иймд дараах сайжруулалт шаардлагатай байна. Үүнд:

Хүснэгт 13. Зөвлөмжийн хүснэгт

д/д	Шалгуур	БОАЖЯ
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,	Ерөнхий чиг үүргийн яам болгож өөрчлөх
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй	Чиг үүргийг хэвээр хадгалах
3	Тухайлсан орон тоотой,	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд анхаарах
4	Мэдлэг, мэдээлэлтэй	Соён гэгээрүүлэх ажлыг (байгаль орчны бодлого, хууль тогтоомж, стандарт) бусад хамтын ажиллагааны байгууллагад зохион байгуулан хийх жишээ нь ЭХЯам, ЗТХЯам
5	Эрх зүйн орчин	Байгаль орчны бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бусад салбарын хуульд тусгах
6	Бичиг баримтын боловсруулалт	Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх, БОННҮнэлгээг төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө хийлгүүлэх талаар хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
7	Хамтын ажиллагаа	Бусад төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх

4.3. Дүгнэлт

Судалгааны багаас шугаман дэд бүтцээс зэрлэг амьтныг хамгаалах, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагын чадавхын үнэлгээг хийхэд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн холбогдох байгууллагуудад хийлээ.

Судалгаанаас үзэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн чиг үүрэгт байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг байхгүй, энэ чиглэлийн мэргэжилтний тусгайлсан орон тоон байхгүй байгаа бөгөөд Зам, тээврийн яамны нэг албан хаагч нь байгаль орчны мэргэжилтний чиглэлийн ажлыг хавсран ажилдаг байна.

Түүнчлэн гол зураг төслийн хүрээнд холбогдох стандартыг барьж ажиллах ёстой зураг төсөл боловсруулах байгууллага, уг зураг төслийг хянах, магадлах байгууллагууд нь зэрлэг амьтанд зориулсан гарц гарам, хамгаалах хэрэгслийн стандартын талаар мэдлэг сул байна.

Харин Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яамны бодлогын газар, хэрэгжилтийн газар, хяналтын газрын алба хаагч нар ЦДХШ, төмөр зам, авто замыг зэрлэг амьтанд ээлтэй болгох, хэрэглэх ёстой хууль тогтоомж, стандарт болон дээрх төслүүдэд хийгдэх байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаар мэдлэг, мэдээлэлтэй байна. Түүнчлэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө хийх, төсөл хэрэгжсэний дараа мониторинг хийх талаар болон практикт тухайн үнэлгээ бүрэн хийгдэхгүй байгаа, хийгдэхгүй байгаа шалтгаан зэргийн талаар мэдээлэлтэй байсан. Харин доод шатны байгууллагуудын албан хаагч нар нь стандарт болон байгаль орчны үнэлгээний зохицуулалтын учир холбогдлыг мэдэхгүй байна.

Энэ нь дээрх яамд газрууд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд хамтран хийгдсэн ажлуудын үр дүн гэж үзэхээр байна. Тухайлбал, байгаль орчны үнэлгээний сургалтыг 2013 оноос хойш тогтмол төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хийж байсан, авто болон төмөр замын зэрлэг амьтанд ээлтэй болгох 2 стандартыг хамтарсан ажлын хэсгээс судалгааг хийж, боловсруулалтыг хийсэн байдаг.

Мөн эрчим хүчний барилга байгууламжийн болон авто, төмөр замын барилга байгууламжийг барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь тэр бүр зэрлэг амьтны гарц гармын стандарт, тогонд цохиулах эрсдэлийг бууруулах хамгаалах хэрэгслийн стандартаар тогтоосон шаардлагыг зураг төсөлд тусгаж өгдөггүй нь зарим мэдээ тоо баримтаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, зураг төсөл боловсруулж байгаа дээрх байгууллага болон зураг төслийн хянан магадалгааг хийж байгаа байгууллагын энэ талын мэдлэг мэдээлэл сул байгааг харуулж байгаа болно.

Хүснэгт 14. Чадавхын үнэлгээний оноо

Д/д	Шалгуур	Сул	Дунд	Сайн	Оноо
1	Байгууллагад хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй,		3		3 оноо
2	Албан тушаалтанд хуулиар олгогдсон чиг үүрэгтэй	1			1 оноо
3	Тухайлсан орон тоотой,	1			1 оноо
4	Мэдлэг, мэдээлэлтэй		3		3 оноо
5	Эрх зүйн орчин		3		3 оноо
6	Бичиг баримтын боловсруулалт		3		3 оноо
7	Оролдлого, санаачлага		3		3 оноо
8	Хамтын ажиллагаа			5	5 оноо
		2	15	5	22

Чадавхын онооны нийлбэр: 22 буюу “дунд” түвшинд гэж үнэллээ.

- o 0-10 оноо сул
- o 11-25 оноо дунд
- o 26-40 оноо сайн

4.4. Зөвлөмж

- Байгаль орчин хариуцсан тусгайлсан мэргэжилтний орон тоог бий болгож, түүгээр дамжуулан цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад аюулгүй байлгах соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллийг бий болгох ажлыг зохион байгуулж, цахилгаан дамжуулах агаарын шугам эзэмшигчийн үүргийг биелүүлэх талаар арга хэмжээг зохион байгуулж ажиллах,
- Эрчим хүчний салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, байгууллагуудын хууль биелүүлэх, байгаль орчинд учруулах нөлөөллийг бууруулах ажил хийсэн байдал нь харилцан адилгүй байгаа нь дээр судалгаа мэдээллээс харагдаж байх тул төрийн өмчийн оролцоотой эрчим хүчний цахилгаан дамжуулах шугам эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудыг хувьчлах асуудлыг шийдвэрлэх нь зах зээлийн зарчим, өрсөлдөөний байдлаар шинэ технологи, байгаль орчинд ээлтэй байдлыг бий болгох давуу талтай болохыг анхаарах,
- Цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа

төрийн өмчийн оролцоотой болон бусад байгууллагууд нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан хугацаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж, уг үнэлгээний дагуу шувуудад сөрөг нөлөө үзүүлж буй нөхцөл байдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

- Цахилгаан дамжуулах агаарын шугамууд нь шувуу үргээх төхөөрөмжтэй эсэх, түүний ажиллагааны талаарх мониторингийг тогтмол хийж байх /шугам сүлжээний байгууллагууд нь байгаль орчин хариуцсан тусгайлсан мэргэжилтэн болж тухайн асуудлыг хэрэгжүүлэх үр дүнг болгох/
- Шинээр баригдаж буй 35 кВ хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөлд шувуу хамгаалах тоног төхөөрөмж тусгасан эсэх, түүний дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж, хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгах талаар техник хяналтын төрийн захиргааны төв байгууллагуудын салбарын хяналтын газруудын хяналт шалгалтын хяналтын хуудаснуудад тусгай асуулт оруулж, хянах механизмыг сайжруулах, тэднийг энэ чиглэлийн соён гэгээрүүлэх ажлаар хангах,
- Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвд олгогдсон салбарын боловсон хүчнийг сургах, чадавхжуулах чиг үүрэгтэй нь уялдуулан Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн амьтныг хамгаалах хэлбэр, амьтныг хамгаалахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага, цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөллийн ерөнхий, нарийвчилсан үнэлгээ, төрөөс эрчим хүчний бодлогын баримт бичигт хийх стратегийн үнэлгээний ач холбогдол, анхаарах асуудал, зохицуулалтын талаар болон эрчим хүчний бодлого, цаашид баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын байршил зэрэгтэй уялдуулан шувуудын байршил, нүүдлийн зам, шилжилт хөдөлгөөний байршлын судалгаа мэдээллийн талаарх сургалтыг тогтмол хийх сургагч багш болон сургалтын гарын авлагыг бэлтгэн хүргэх.
- Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвийн алба хаагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн амьтныг хамгаалах хэлбэр, амьтныг хамгаалахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага, цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөллийн ерөнхий, нарийвчилсан үнэлгээ, төрөөс эрчим хүчний талаарх бодлогын баримт бичигт хийх стратегийн үнэлгээний ач холбогдол, анхаарах асуудал, зохицуулалтын талаар соён гэгээрүүлэх арга хэмжээг авах,
- Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт зэрлэг амьтдын амьдрах шилжилт, нүүдлийн асуудлыг хариуцах чиг үүргийг бий болгож, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллахад голлон үүрэгтэй оролцуулах, уг газрыг чадавхжуулах мэдээ мэдээллээр хангах сургалтыг хийх,
- Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтсээс боловсруулдаг Монгол Улсын авто замын орон зайн мэдээллийн санг боловсронгуй болгох, байнгын баяжилт хийхдээ тухайн орон нутгийн захиргааны байгууллага, байгаль орчны мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллага зэрэг бүх талын оролцоог хангаж, авто болон өмөр зам болон бусад шугаман дэд бүтцийн мэдээллийг нэгтгэх, нүүдлийн зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдлийн зам нь шугаман дэд бүтэцтэй огтлолцож байгаа газруудыг тодорхойлох, тухайн газруудад шугаман дэд бүтцийг амьтдад ээлтэй төлөвлөх,
- Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын салбарын боловсон хүчнийг сургах чиг үүрэгтэй нь уялдуулан байгаль орчны хууль тогтоомж, стандарт, зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн замын мэдээллийг тухай бүр хүргэж байх сургагч багшийг бэлтгэх ажлыг хийх, холбогдох гарын авлагыг гаргах,

- Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зам, тээврийн хөгжлийн төв зэрэг байгууллагуудын албан хаагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон холбогдох стандарт, зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн зам, авто зам болон төмөр замаас зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ зэргийг агуулсан сургалтын гарын авлагыг бэлтгэж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэх,
- Эрчим хүчний болон зам, тээврийн салбарт авах арга хэмжээг дараах хүснэгтээр үзүүлэв:

д/д	Шалгуур	Байгууллага, албан тушаалтанд хуулиар олгогдсон тухайлсан чиг үүрэгтэй	Тухайлсан орон тоотой,	Мэдлэг, мэдээлэлтэй
1	Эрчим хүчний яам	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг нэмэх	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх орон тоо бий болгох Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хуулийн талаар сургалт явуулах.
2	Зам, тээврийн хөгжлийн яам	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг нэмэх	Бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх орон тоо бий болгох Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хуулийн талаар сургалт явуулах.
3	Эрчим хүчний хөгжлийн төв	Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Зураг төслийг боловсруулахдаа стандарт, техникийн зохицуулалтыг анхаарч тусгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдөн ажиллах	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хууль, амьтны тархац нутаг, нүүдлийн замын талаар сургалт авах, салбарын боловсон хүчнийг сургах сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, салбарын боловсон хүчнийг сургах.

4	Байгаль орчин, аялал жуулчлалын яам		Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Эрчим, зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд болон хэрэгжүүлэгч агентлаг, ТӨҮГ-н боловсон хүчнийг байгаль орчны хууль тогтоомж, стандартыг таниулах сургалтыг хамтран хийх, тусгайсан экологийн боловсролын хөтөлбөрийг боловсруулах.
5	Барилгын хөгжлийн төв	Байгаль орчны хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн чиг үүргийг хэрэгжүүлэх Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Зураг төслийг боловсруулахдаа стандарт, техникийн зохицуулалтыг анхаарч тусгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдөн ажиллах	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хууль, амьтны тархац нутаг, нүүдлийн замын талаар сургалт авах, салбарын боловсон хүчнийг сургах сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, салбарын боловсон хүчнийг сургах.
6	Авто тээврийн үндэсний төв	Байгаль орчны бодлого, хууль тогтоомжтой уялдуулах, хэрэгжилтийг хангуулах Стандартыг боловсронгуй болгох, техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж, мөрдүүлэх	Зураг төслийг боловсруулахдаа стандарт, техникийн зохицуулалтыг анхаарч тусгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны чиглэлийн албан тушаалын орон тоо бий болгох Байгаль орчны болон салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, стандартыг мөрдөн ажиллах	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хууль, амьтны тархац нутаг, нүүдлийн замын талаар сургалт авах, салбарын боловсон хүчнийг сургах сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, салбарын боловсон хүчнийг сургах.

7	Эрчим хүчний сүлжээ ТӨК	Байгаль орчны бодлого, хууль тогтоомжтой уялдуулах, хэрэгжилтийг хангуулах	Стандартын хэрэгжилтийг хангах, зураг төслийн дагуу байгууламжийг барих, мониторинг хийх	Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хуулийн талаар сургалт авах,
8	Салбарын төрийн бус байгууллага	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	БОАЖЯ, холбогдох ТББ, судалгааны байгууллага, судлаач, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Байгаль орчны бодлого, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хууль, амьтны тархац нутаг, нүүдлийн замын талаар сургалт авах, салбарын боловсон хүчнийг сургах сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, салбарын боловсон хүчнийг сургах.

- Авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц гармыг барихад санхүүжилт их шаардагдах тул хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхой болгох хүрээнд олон улсын байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулж нэвтрүүлэх, авто замын сангийн санхүүжилтийн тодорхой хувийг жил бүр судалгаа шинжилгээний ажилд хуваарилж байх зэрэг арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийг Засгийн газраас баталдаг тул Зам, тээврийн хөгжлийн яамны болон бусад яамны бүтцэд байгаль орчны чиглэлийн орон тоог бий болгох, эсвэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад орон нутгийн захиргааны байгууллага, байгаль орчны мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиг үүргийг тусгаж өгөх,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг “Ерөнхий чиг үүргийн яам” болгож, байгаль орчны мэргэжилтэн нарыг байгаль орчны бодлого шийдвэрийг бусад салбарын бодлого шийдвэрт тусгуулах, нийцүүлэх зорилгоор салбар яамнуудад тусгайлсан орон тоог бий болгох,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, судалгааны байгууллага, төрийн бус байгууллагаас бусад салбар яам, захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагч нарт байгаль орчны бодлого, хууль эрх зүйн талаар соён гэгээрүүлэх ажлын тогтмол явуулах.

ТАВ

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5.1. Монгол орны амьтны аймгийн хууль эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл

5.1.1. Монгол орны байгаль орчныг хамгаалах эрх зүйн суурь үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, **Гучин наймдугаар зүйлийн 1-д** “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.” гэж, 2-т “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гэж, 4-т “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;” гэж тус тус зааснаас эхлэлтэй болно. Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь харин байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зүй зохистой ашиглах эрх зүйн үндэс, төрийн болон төрийн бус байгууллага иргэний эрх үүргийг тодорхойлж өгсөн бөгөөд уг хуулийн зохицуулах харилцааг хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцаа байх, уг харилцааг энэхүү хуулиар зохицуулахаар заасан.

Харин зэрлэг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой эрх зүйн гол эх сурвалж буюу холбогдох харилцааг зохицуулсан тусгайлсан хууль нь Амьтны тухай хууль бөгөөд уг хуульд зэрлэг амьтныг ховордлын зэргээр нь нэн ховор, ховор, элбэг гэж ангилан тухайн ангилал тус бүрд хамгаалал, ашиглалтын хэлбэрийг тодорхойлж, энэ харилцаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцох оролцоо, эрх үүргийг зааж өгсөн байдаг.

Түүнчлэн байгаль орчныг хамгаалах чиглэлийн дараагийн нэг эрх зүйн баримт бичиг бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль бөгөөд энэ хуулиар зэрлэг амьтны тархац нутагт, эсхүл нүүдлийн замыг дайруулан төсөл хэрэгжүүлэхэд уг төслөөс зэрлэг амьтанд учрах нөлөөллийг тодорхойлох, нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулдаг болно.

5.2. Эрчим хүчний хууль зүй эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл

5.2.1. Бодлогын баримт бичиг

3.1.1 Монгол Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай” бодлогын баримт бичиг гарч, улмаар 2015-2030 он хүртэлх хийж хэрэгжүүлэх зорилт, үр дүн, найдвартай ажиллагааг дээшлүүлэх асуудлыг тусгасан байдаг.

Дээрх бодлогын баримт бичгийн 3 дугаар хэсэгт байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн хүрээнд 3.2.6.5 дахь заалтад эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, мөн 3.2.6.6-д байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах талаар онцгойлон тусгасан байсан.

Гэвч тухай бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор Улсын их хурлын 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна.

Цаашид “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай”-ийн дагуу Монгол Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор «Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого», «Алсын хараа-2050» Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа» бодлогын баримт бичгүүдийг баталсан байна.

Тус “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд буюу 4.8 дахь заалтад “цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.” мөн “эрчим хүчний хөндлөн гол тэнхлэгийн болон бүсийн босоо тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж байгуулан, зарим дулааны цахилгаан станцыг өргөтгөж нэгдсэн системийг бүрдүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

“Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.35 дахь заалтад “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.” гэж тусгасан байна.

Дээрх 2 бодлогын баримт бичгийн цахилгаан дамжуулах агаарын шугамын байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх буюу шувуу хамгаалах эрх зүй орчин, хамгаалах нөхцөлийг тусгасан байдлаар харьцуулалт хийв.

Анхны батлагдсан бодлогын баримт бичиг нь зөвхөн эрчим хүчний салбарт хэрэгжих бөгөөд тухайн баримт бичигт байгаль орчин хамгаалах, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулах, түгээх үйл ажиллагааны явцад байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах талаар тусгайлан хэрэгжүүлэх тусгасан давуу талтай байсан байна.

Харин Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар тусгайлсан бодлогын баримт бичиг байхыг хориглосон бөгөөд урт, дунд, богино хугацааны баримт бичгийг тодорхойлсон. Уг хуулиар урт хугацааны баримт бичиг нь зөвхөн “Алсын хараа-2050”, харин дунд хугацааны баримт бичиг нь 7 чиглэлийг агуулсан Хөгжлийн зорилтод хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл байхаар заасан.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг нь ерөнхий байдлаар тусгасан ба “босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.” гэж заасан боловч энэ шугамыг барьж байгуулахад байгаль орчин хамгаалах, нөлөөллийг буруулах талаар тусгаагүй байна. Харин байгаль орчныг хамгаалах хэсэгт энэ тухайн заасан байдаг.

5.2.3. Хууль эрх зүйн орчин

Цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын явцад үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөх техникийн холбогдолтой 2 хууль /Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль/ байна.

Шинээр баригдаж буй цахилгаан агаарын шугамуудад Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-д *байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх* шаардлагын бүрэн хангасан байхаар хуульчилсан байдаг.

Гэвч шинээр баригдаж буй барилга байгууламжуудын зураг төслийг боловсруулахдаа зураг төсөл зохиогч нь байгаль орчин буюу агаарын шугамын ашиглалтын явцад шувуу үрэгдүүлэхгүй байх нөхцөл шаардлагыг орхигдуулж улмаар тус шугам сүлжээ баригдаж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх буюу шувуу үрэгдүүлэх үндсэн шалтгаан болж байна(Шугаман дэд бүтцийн байгууламжийн амьтны аймагт үзүүлэх нөлөө, холбогдол бүлэг).

Барилга байгууламжийг баригдахын өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх зайлшгүй шаардлагатай бөгөөд хөрөнгө, санхүү хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан 35 кВ ба түүнээс доош цахилгаан дамжуулах агаарын шугам төдийлөн хийгдэхгүй байна.

Харин 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам буюу гаднын томоохон хөрөнгө оруулалт, санхүүжилтэй холбоотой төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэж байна. Тухайлбал: Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь Чойр, Сайншандын хооронд 220.2 километр (км) урт, 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилгын ажил эхлэхийн өмнө барилга орчны нөлөөллийн иж бүрэн судалгаа хийсэн байна.

Тус судалгаагаар шувуудын нүүдэл, тоо, хэмжээ төрөл болон ашиглалтын явцад хэрхэн хамгаалах талаар тусгасан ба цаашид ашиглалтын явцад хэрхэн сөрөг нөлөөг багасгах талаар тодорхой тусгасан байна.

Ашиглагдаж буй цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хувьд Монгол Улсын эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.11-д “үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар

батлуулж мөрдөх;" тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг заасан байдаг болно.

Иймд Монгол Улсад цахилгаан дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшиж буй цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага нь жил бүр байгаль хамгаалах /агаарын шугамд шувуу үрэгдэж буй нөхцөл байдал/, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хангалтгүй буюу зөвхөн цахилгаан дамжуулах, түгээх үйл ажиллагаандаа онцгой анхаарч ажиллаж байна.

Мөн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгаль орчны төрийн захиргааны байгууллагууд нь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй цахилгаан шугам сүлжээ эзэмшигчийн жил бүр гарган ирүүлэх шаардлагатай байгаль орчны нөлөөллийн үнэлгээний судалгаа мэдээллийг үнэн зөв ирүүлэх, түүний дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулж буй эсэхэд хяналт тавихгүй байгаа нь цахилгаан дамжуулах агаарын шугамаас шувууг хамгаалах ажлыг үр дүнгүй байдал хүргэх үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна.

5.2.4. Эрчим хүчний дүрэм журам.

Эрчим хүчний салбарт эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн болон хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн гэсэн 2 үндсэн техник ашиглалтын дүрэм мөрдөгдөж байна.

1. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй эрчим хүчний бүх үйлдвэр, аж ахуйн газрууд дагаж мөрдөх үүрэгтэй байдаг.

Тус дүрмийн 1.12 дугаар хэсэгт тусгайлан заасан байгаль орчныг хамгаалах бүлэг, мөн дүрмийн 5.7 дугаар хэсэгт цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын явцад шувуу үргээх буюу хөндийрүүлэгч дээр суулгахгүй байх тусгай хэрэгсэл төхөөрөмж ашиглах хэрэгтэй гэж заасан байдаг.

Гэвч шинээр баригдаж буй шугам сүлжээг барих үед байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байгаа улмаас шувуудын нүүдэл, түүнд нөлөөлөх асуудал нь судалгаа хийгдэхгүйн улмаас цахилгаан дамжуулах агаарын шугамуудад шувуу үргээх, түүнийг хамгаалах тоноглол хийгдэхгүй сөрөг нөлөөллийг бууруулахгүй байна.

2. Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрмийг өмчийн хэлбэрээс үл хамааран Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд буюу хэрэглэгчид /эрчим хүчний салбарын үйлдвэр аж ахуйн нэгжээс бусад/ мөрдөхөөр заасан байдаг.

Дээрх дүрмийн 2.3.20 дахь заалтад тусгаарлагч нь шувуудын нөлөөгөөр илүү бохирддог буюу шувуудын үүр бөөнөөр байрласан газарт гирлянд дээр шувуу суулгахгүй айлган үргээх төхөөрөмж ашиглах нь зүйтэй гэж тусгасан байна.

Дээрх 2 техник ашиглалтын дүрэмд цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалт, үйл ажиллагааны явцад шувуу хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх хангалттай заалт, техникийн нарийн шаардлага тусгаагүй улмаас орхигдох үндсэн шалтгаан болж байдаг.

5.2.5. Стандартын баримт бичиг

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг;”, 4.1.3 дахь заалтад “техникийн зохицуулалт” гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;” гэж тус тус тодорхой заасан бөгөөд энэхүү зохицуулалт нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Гэвч тус хууль 2017 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн боловч өнөөг хүртэл эрчим хүчний салбарын техникийн зохицуулалт боловсруулагдаж батлагдаагүй байна.

Харин стандартын хувьд цахилгаан дамжуулах агаарын шугамын хувьд шувуудад аюулгүй байлгах нөхцөл бүрдүүлэхтэй холбоотой тусгайлсан стандарт байхгүй бөгөөд харин MNS 6518:2015 “0.4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах сүлжээний дэд өртөө. Барьж байгуулахад тавигдах үндсэн шаардлага”-ын хавсралт D хэсэгт шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагыг сонгон хэрэглэж байна.

Цахилгаан дамжуулах агаарын 10-15 кВ-ын шугамд шувуудад эрсдэлгүй ээлтэй байх, үхэж хорогдохоос сэргийлэх зорилгоор тулгуурын орой дээр шувуу суух боломжийг хязгаарласан толгой эсвэл цахилгаан дамжуулагдаггүй тусгаарлагч бүрхүүл суурилуулах, мөн дүүжин хэлбэрийн ПС-70 маркийн тусгаарлагч суурилуулахад тавих техникийн шаардлагуудыг “MNS 6518:2015 “0.4 кВ-аас 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам барьж байгуулахад тавих шаардлага” стандартад мэргэжлийн байгууллага болон холбогдох эрдэмтэн судлаачдын саналыг үндэслэн 2021 оны 05 дугаар сарын 24-нд Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас тус стандартад нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан байна.

Энэ нь Монгол Улсад анх удаа эрчим хүчийг шувуудад ээлтэй байлгахад чиглэсэн Монгол Улсын хэмжээнд мөрдөх стандартын баримт бичиг болж байгаа юм. Ингэснээр цаашид цахилгаан дамжуулах агаарын шугам барихдаа энэхүү стандартад оруулсан нэмэлт өөрчлөлт болох D хавсралтын “Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлага”-ын дагуу барьж байгуулах юм. Монгол Улсын MNS 6518:2015 стандартын нэмэлт өөрчлөлтөд орсон “D” хавсралтад Завсрын болон анкер тулгуурын бүтцийг шувуудад ээлтэй байлгахад дараах 5 зурагт үзүүлсэн шаардлагуудыг тавьсан байна.

ЦДАШ-ыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагаар тусгаарлах материал нь -500С-аас +700С-ын температур болон 6, 10, 15 кВ-ын хүчдэлийг тэсвэрлэх чадвартай, 25-35 жилийн ашиглалтын хугацаатай, 40 м/с хүртэл салхинд тэсвэртэй, хөнгөн байх шаардлага тавигдсан байна.

Дээрх шаардлагын дагуу эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалттай түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч болох “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь 110/35/10кВ-ын Баруунхараа дэд станцын Яч№17 10кВ-н Сүмбэр АШ-ын тулгуур №1-240-н хооронд Р-15 тусгаарлагчид 672 ширхэг тусгаарлагчтай бүрхүүл, АС дамжуулагч утсанд 403 метр шувуу хамгаалах дамжуулагч утасны тусгаарлагчийг суурилуулсан байна. (Зураг 13-16, 23)

5.3. Зам тээврийн хууль эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл

5.3.1. Төмөр замын тээврийн тухай хууль нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулдаг гол хууль юм.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.” гэж, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13-д “үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар нь тусгай хэрэгцээний газар байх;” гэж, 16.3-т “Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно.” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.3-т “улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох;” гэж, 42 дугаар зүйлийн 42.1-д “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.” гэж тус тус заасан байдаг.

5.3.2. Авто замын тухай хууль. Авто замын тухай хууль” нь 2017 онд батлагдаж, шинээр баригдаж буй авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулахад Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1-д “зураг төсөл зохиох зургийн даалгавар, хайгуул геологийн судалгааны дүгнэлт, геодезийн хэмжилт, техникийн нөхцөл, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу боловсруулсан байх” гэж, 19.2.2-т “зорчигчдын эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байх” гэж, 19.2.3-т “авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах” гэж тус тус заасан шаардлагын бүрэн хангасан байхаар хуульчилсан байдаг. Дээрх зохицуулалтаар авто замыг барьж байгуулахдаа замын зураг төсөлд зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийг замыг Монгол Улсын стандартад заасан шаардлагыг тусгахаар заасан байна.

5.3.3. Стандартын баримт бичиг

2010 онд батлагдсан “Төмөр замын зурвас газарт тавигдах шаардлага” 6060:2010 стандартын баримт бичгээр төмөр замын барилга байгууламжийг барьж байгуулах, төмөр замын зурвас газарт тавигдах техникийн зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

Авто замын салбарт мөрдөгдөж байгаа авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн норм дүрэмд гадаргуу, үерийн ус нэвтрүүлэх зориулалтаар усны тооцооны үндсэн дээр гүүр хоолойг төлөвлөж баригддаг. Тусгайлсан нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцыг тус чиглэлийн тооцоо, судалгааны үндсэн дээр 2015, 2018 оноос өмнө төлөвлөх эрх зүйн орчин бүрдээгүй байсан.

2015 онд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандарт, 2018 онд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018 стандартуудыг батлуулагдсанаар тухайн чиглэлээр авто зам, төмөр замын салбарт нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх нөхцөл бүрдсэн байна.

ЗУРГАА

ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАР, ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА.

6.1. Шугаман дэд бүтцийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар

Хоёр. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

6.2.1. Үнэлгээ хийх шалтгаан

Зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулах эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн эрх зүйн актууд хэрэгжиж эхэлснээс хойш тус хууль тогтоомжийн практик хэрэгжилтэд олон бэрхшээл үүссэн төдийгүй, шаардлагатай чухал асуудлууд ч өнөөг хүртэл зохицуулалтгүй явж ирснийг энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, хяналт шалгалтын дүнгээс харагдаж байна.

Гэвч өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилтийн сул талыг харгалзсан дорвитой өөрчлөлт хийгдээгүйгээс эрх зүйн шинэчлэлээс хоцорч, улмаар энэ төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүйн зэрэгцээ зохицуулалтын хувьд бусад хуультай зарим талаар зөрчилдөхөд хүрсэн байна.

6.2.2. Үнэлгээний зорилго:

Үнэлгээ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 51 дүгээр зүйлд заасны дагуу зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахад чиглэсэн эрх зүйн орчны хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, улмаар уг харилцааг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын хувилбарыг тогтоох зорилготой болно.

6.2.3. Үнэлгээний хүрээ

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид Аргачлал гэх/-ын дагуу гүйцэтгэсэн.

Аргачлалын 3.3-т заасны дагуу үнэлгээний хүрээнд зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахад чиглэсэн хууль, эрх зүйн актуудын холбогдох хэсгүүдэд хамруулахаар тогтоолоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль 9 бүлэг, 59 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон байгаль орчныг хамгаалах иргэний эрх үүрэг болон төрийн чиг үүрэг, зарчим хэрэгжүүлэх хүрээг;
- Хоёрдугаар бүлэг буюу Байгаль орчны үнэлгээ, судалгаа, шинжилгээ, аудит хэсгээр Байгаль орчны үнэлгээ, аудит, санхүүжилтийн хүрээг;
- Гуравдугаар бүлэг буюу Байгаль орчныг хамгаалах чиглэлээр төрийн байгууллагын бүрэн эрх хэсгээр Улсын Их Хурал, Засгийн Газар, Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, сум, нийслэлийн Засаг Дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээг;
- Дөрөвдүгээр бүлэг буюу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах, нөхөн сэргээх нийтлэг арга хэмжээ хэсгээр байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэрийг;
- Тавдугаар бүлэг буюу Байгаль орчны хяналт хэсгээр байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэгч субъектийн эрх, үүрэг, эрх хэмжээ, арга хэлбэрийг;
- Зургаадугаар бүлэг буюу байгаль орчин, байгалийн баялгийг хамгаалах аж ахуйн нэгжийн үүрэг хэсгээр мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг, байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлсон;
- Долоодугаар бүлэг буюу байгаль орчны мэдээллийн сан хэсгээр мэдээллийн сангийн хэлбэр, тогтолцоо, бүрдэл, мэдээллийн төвийн бүрэн эрх, мэдээллийн сан хэрэглэгчийн эрх, үүрэг, хориглох зүйлүүд;
- Есдүгээр бүлэг буюу бусад зүйл хэсгээр санхүүжилт, байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг, байгалийн баялгийн нөөц ашигласны хураамж, хохирол нөхөн төлөх болон хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, зохицуулсан байна.

Амьтны тухай хууль нь 5 бүлэг 39 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон амьтныг хамгаалах чиглэлээр төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг;
- Хоёрдугаар бүлэг буюу Амьтан хамгаалах хэсгээр Амьтныг хамгаалах хүрээг;
- Дөрөвдүгээр бүлэг буюу Амьтны мэдээллийн сан, төлбөр, санхүүжилт хэсгээр амьтны мэдээллийн сан, төлбөр, хураамж, санхүүжилтийн хэлбэрийг;

Эрчим хүчний тухай хууль нь 6 бүлэг 38 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон нэр томьёо;
- Хоёрдугаар бүлэг буюу Төрийн байгууллагын бүрэн эрх хэсгээр Улсын Их Хурал, Засгийн Газар, Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, сум, нийслэлийн Засаг Дарга болон Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн эрх хэмжээг;
- Гуравдугаар бүлэг буюу Тусгай зөвшөөрөл хэсгээр тусгай зөвшөөрөл авах зохицуулалтыг;
- Тавдугаар бүлэг буюу Хангагч, хэрэглэгчийн харилцаа хэсгээр эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн эрх үүргийг;

Нэг талаас стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах, нөгөө талаас гэрээгээр тохирсон тарифын дагуу, тогтоосон хугацаанд төлбөрөө төлөх үүргийг хүлээдэг.

Шувуунаас хамааралтай цахилгаан шугам сүлжээний тасралтын давтамжийг авч үзвэл

- 2016 онд 11 удаа
- 2017 онд 6 удаа
- 2018 онд 4 удаагийн давтамжтай тасалдал үүсэж байсан гэсэн судалгаа байна.

Шувуу үргээгчийг суурилуулснаар цахилгаан шугам сүлжээг шувуудад аюулгүй болгох, түүнтэй хамааралтай тасралт гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь судалгаа, мэдээллээр батлагдсан байна.

Шувуу хамгаалагч хязгаарлагч толгой, дамжуулагчийн тусгаарлагчийг суурилуулснаар цахилгаан дамжуулах агаарын шугамд дараах давуу талууд бий болно. Үүнд:

- Хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын нөлөөллийн бүсэд шувууд өртөхгүй байх;
 - Цахилгаан дамжуулах агаарын шугамд шувуутай холбоотой тасралт гарахгүй байх буюу хэрэглэгчид тасалдал үүсгэхгүй байх, гэрээний үүргээ биелүүлэх;
 - Байгаль орчинд ээлтэй, шувууд үхэхгүй байх нөхцөл бүрдэх.
- Зургаадугаар бүлэг буюу Хяналт хариуцлага хэсгээр хуулийн биелэлтэд хяналт тавих, маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх болон хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, зохицуулсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь 5 бүлэг 20 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон нэр томьёо;
- Хоёрдугаар бүлэг буюу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бүтэц, тогтолцоо, зохицуулалт хэсгээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэлбэр, хэм хэмжээг;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд дэд бүтэц гэж байхгүй байгаа нь өөрөө энэ төрлийн төсөл дээр үнэлгээ хийхгүй юм шиг харагдаж байна. Энэ утгаараа төслийг хэрэгжүүлэхдээ үнэлгээг хийхгүй байх тохиолдол их гарч байна. Жишээ нь Говь-Алтай аймгийн алтай сумаас Ховд аймгийн Зэрэг сум хүртэлх хатуу хучилттай босоо тэнхлэгийн авто замын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ) төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө биш төслийг хэрэгжүүлж байх шатандаа хийсэн байдаг. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг төслийг хэрэгжүүлж дуусах шатанд хийж, батлуулсан байдаг. Энэ нь тэр бүр хэрэгжилт сайн бүрэн дүүрэн зорилгодоо хүрч хэрэгжихгүй байгааг харуулж байна.

- Гуравдугаар бүлэг буюу Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцогчдын эрх үүрэг хэсгээр тэдгээрийн эрх, үүргийн зохицуулалтыг;
- Дөрөвдүгээр бүлэг буюу Олон нийтийн оролцоо хэсгээр нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, түүний эрх зүйн зохицуулалт
- Тавдугаар бүлэг буюу Бусад хэсгээр хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж, зохицуулсан байна.

Авто замын тухай хууль нь 10 бүлэг 36 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон нэр томьёо, зарчим, санхүүжилт, авто замын норм, норматив, техникийн баримт бичиг;
- Хоёрдугаар бүлэг буюу Төрийн байгууллагын бүрэн эрх хэсгээр Засгийн Газар,

Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, сум, нийслэлийн Засаг Дарга болон, авто замын судалгаа, шинжилгээ, хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага;

Авто замын тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн бус байгууллагын оролцоог хуульчилсан ба 13.1-д “Авто замын салбарын төрийн бус байгууллага нь авто замын тухай хууль тогтоомж, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, авто замчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно.” гэж, 13.2-т “Энэ хуулийн 13.1-д заасан ажлыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.” гэж тус тус тусгасан байна.

- Дөрөвдүгээр бүлэг буюу Авто зам барих хэсгээр авто замын техник эдийн засгийн үндэслэл, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт;

Авто зам, замын байгууламжийн зураг төсөл нь Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3-т “авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах” зохицуулалтыг тусгасан байна.

Дээрх гүүрэн, нүхэн гарц гарам барих шаардлагыг Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6515:2015 стандарт, Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6735:2018 стандартуудаар тус тус тогтоосон байдаг ба дээрх стандартуудад авто замын тухай хуулийн дагуу зураг төсөл боловсруулахдаа удирдлага болгоно гэж тусгаагүйн улмаас хууль хийгээд стандартууд нь хоорондоо уялдаа холбоогүй зохицуулалттай байна.

- Наймдугаар бүлэг буюу Авто зам барих засварлах, арчлах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, тусгай зөвшөөрөл хэсгээр тусгай зөвшөөрөл олгох;

Төмөр замын тээврийн тухай хууль нь 8 бүлэг 34 зүйлтэй бөгөөд

- Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэл хэсгээр хуулийн зорилт болон нэр томьёо, зарчим, хуулийн үйлчлэх хүрээг;
- Хоёрдугаар бүлэг буюу Төрийн байгууллагын бүрэн эрх хэсгээр Засгийн Газар, Төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, сум, нийслэлийн Засаг Дарга болон, төмөр замын тээврийн хяналтын алба, тусгай зөвшөөрөл, стандартчилал;

Суурь бүтэц барих, ашиглах, тусгай зөвшөөрөл авахад тус хуулийн 16.3.1-д заасны дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байх гэж заасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т дэд бүтэц гэх нэршил тусгагдаагүй ба тус хуулийн хавсралтад тусгагдсан байгаа нь Төмөр замын тээврийн тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь хоорондоо зөрчилдөж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төмөр замын тээврийн салбарт баримтлах стандартыг энэ хууль болон стандартчилал, техникийн зохицуулалт,

тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ” гэж тусгасан.

Зэрлэг амьтдад ээлтэй байх төмөр замын салбарт ашиглагдаж буй голлох стандарт нь Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6515:2015 юм.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т «стандарт» гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан байна.

Дээрхээс дүгнэвэл зэрлэг амьтдад ээлтэй дэд бүтэц барьж байгуулахад голлох үүрэг гүйцэтгэх баримт бичиг болох Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. MNS 6515:2015 стандарт нь заавал дагаж мөрдөх хүчин чадал бүхий бус сонгон хэрэглэх баримт бичгийн нэг байна.

- Тавдугаар бүлэг буюу Төмөр замын тээврийн аюулгүй байдлын үндсэн шаардлага хэсгээр Төмөр замын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг;

Төмөр замын тээврийн аюулгүй байдал нь төмөр замын болон бусад байгууллага, иргэд нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх үүргийг хүлээсэн байна.

0.4 кВ-оос 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага: MNS 6518:2015 нь 8 бүлэг 4 хавсралттай бөгөөд

- Нэгдүгээр зүйл буюу Хэрэглэх хүрээ хэсгээр тус стандартыг улсын хэмжээнд мөрдөх субъектийг аж ахуйн нэгж, байгууллага байна гэж тусгасан,

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2-т «стандарт» гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан байна.

Харин техникийн зохицуулалт нь тус хуулийн 5.2-т зааснаар нийтээр заавал дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Дээрхээс үзвэл хууль зүйн хүчин чадлын хувьд техникийн зохицуулалт нь заавал дагаж мөрдөх баримт бичиг бол стандарт нь заавал дагаж мөрдөх бус сонгон хэрэглэх баримт бичиг байна.

Иймд зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулах ерөнхий шаардлагууд нь дээрх стандартуудад илүү дэлгэрэнгүй, нарийн тусгагдсанаас тус стандартыг хэрэгжүүлэгч нь тэдгээрийг заавал дагаж мөрдөх нь хуулиараа үүрэг болж тусгагдаагүй учраас практикт хэрэгжилт нь дутмаг байна гэж дүгнэж болохоор байна.

- Гуравдугаар зүйл буюу агаарын шугам барьж байгуулахад тавих нөхцөл, норм шаардлага хэсгээр агаарын шугам барьж байгуулах ерөнхий шаардлагыг тусгасан ба f.“шувуудын аюулгүй байдал, цахилгааны аюулгүйн шаардлагын мөрдөлт”-ийг хангасан байвал зохино гэж тусгасан. Түүнчлэн тус зүйлд хүрээлэн

буй орчныг хамгаалах шаардлага хэсэгт “Е.Шувуудын суурьшлын бүс, нүүдлийн замд тэдгээрийг үхэлд хүргэх нөхцөл байгаа эсэх”-ийг тооцно гэж тусгасан.

Түүнчлэн 3.11.11-д “Энэ стандартын 3.11.1-д нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 6, 10, 15 кВ-ын цахилгаан дамжуулах аваарын шугамын зураг төсөл боловсруулах, барьж байгуулахдаа D хавсралтад үзүүлсэн ЦДАШ-ыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагаас сонгон хэрэглэнэ.” гэж тус тус тусгасан;

Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц **MNS 6515:2015 стандарт нь 11 зүйл 3 хавсралттай бөгөөд**

- Нэгдүгээр зүйл буюу Зорилго хэсгээр тус стандартыг зорилго нь тал хээр, говийн бүс нутагт авто зам, төмөр замын дагуу зэрлэг амьтдад зориулсан гарцын төлөвлөлт түүний хийц, ашиглалт, засвар арчилгаа, хяналтын ерөнхий шаардлагыг тогтооход оршино гэж тусгасан,
- Хоёрдугаар бүлэг буюу хамрах хүрээ хэсгээр тал хээр говийн бүсэд тархсан хулан адуу, хар сүүлт, цагаан зээр, аргаль хонь, янгир ямаа, монгол бөхөн зэрэг зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх, барьж байгуулах, ашиглахад хамаарна гэж тусгасан;
- Тавдугаар бүлэг буюу Зэрлэг амьтанд зориулсан гарцын ангилал хэсгээр гарцын ангилал, барьж байгуулахад тавигдах шаардлагыг тус тус тусгажээ.

Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6735:2018 нь 10 зүйл 2 хавсралттай.

- Нэгдүгээр зүйл буюу Зорилго хэсгээр уулархаг нутагт замын байгууламжийн дагуу зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдэд зориулсан гарц төлөвлөх, түүний хийц, ашиглалт, засвар арчлалт болон хяналт тавих ерөнхий шаардлагыг тогтоох;
- Хоёрдугаар бүлэг буюу хамрах хүрээ хэсгээр Уулархаг нутагт тархсан аргаль хонь, янгир ямаа, молцог хандгай, халиун буга, бор гөрөөс, буган цаа, зэрлэг гахай, баданги хүдэр, цоохор ирвэс, шилүүс мий зэрэг зэрлэг амьтдад гарц төлөвлөх, барьж байгуулах, ашиглах;
- Гуравдугаар бүлэг буюу ач холбогдол хэсгээр уулархаг нутагт авто замын дагуу гарц байгуулснаар зэрлэг амьтдын нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг аюулгүй, чөлөөтэй нэвтрүүлэх боломжийг олгох, экосистемийн нэгдмэл байдлыг хангах, хамгаалах, Биологийн олон янз байдлын тухай конвенци, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн хүрээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулах;

Түүнчлэн зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн орчныг зохицуулж буй салбарын хууль тогтоомжоос гадна холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан стандартуудаар мөн зохицуулж байна.

Иймд үнэлгээний хүрээнд салбарын хууль тогтоомжоос гадна холбогдох бусад стандартуудын тодорхой зохицуулалтыг давхар хамруулсан болно.

Өндөр уулын бүсэд төлөвлөгдсөн замын дагуу зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн коридор нутгийг холбох гарц, гарам байгуулах стандарт боловсруулах ажлын хүрээнд Ховд, Баян-Өлгий аймгуудаар өнгөрөх босоо тэнхлэгийн замын ажил явагдаж байгаатай холбогдуулан түүгээр дамжин өнгөрөх аргаль хонь, янгир ямаа, бөхөн, хар сүүлтийн шилжилт

хөдөлгөөнийг хэвийн явуулах боломжит газар нутгийн төлөв байдалтай танилцах, улмаар стандартад оновчтой зураглал гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулахад зорилгоор БОАЖЯ, ЗТЯ, «Аргаль, агнуур судлалын төв» ТББ зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг 2017 онд ажилласан байна.

Тус ажлын хэсгийн судалгаанд Улаанбайшинт-Цагааннуур-Өлгий-Толбо-Бураатын даваа-Ховд- Бодончийн хавцал бөхөн (*Saigatatarica*), хар сүүлтий (*Gasellasubgutturosa*), Баян-Өлгий аймгийн Баянзүрх, Бураат орчмын аргаль хонь (*Ovisammon*), янгир ямааны (*Capra sibirica*), Ховд, Баян-Өлгий аймгуудын хилийн бүс дагуух, Хашаатын давааны янгир ямааны байршил ба хөдөлгөөний чиглэл, Ховд аймгийн Шарга-Манханы бөхөн, хар сүүлтийн шилжилт, Мянган угалзатын нурууны БЦГ, Мөнххайрхан уулын БЦГ-ын дундах Бодончийн хавцлын аргаль, янгир ямааны шилжилт тус тус хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан нутаг буюу олон улсын чанартай зам нь үндсэндээ уулын туруутны байршил нутгаар болон тархац нутгуудын хоорондын коридор нутгаар дамжин өнгөрч байгаа нь тогтоогдсон.

Судалгаанд Ховд, Баян-Өлгий аймгуудын хилийн бүс дагуух, Хашаатын даваа, Баян-Өлгий аймгийн Баянзүрх, Бураат орчмын аргаль хонь, янгир ямааны байршил ба хөдөлгөөний чиглэл, Ховд аймгийн Шарга-Манханы бөхөн, хар сүүлтийн шилжилт, Мянган угалзатын нурууны Байгалийн цогцолбор газар, Мөнххайрхан уулын Байгалийн цогцолбор газрын дундах Бодончийн хавцлын аргаль, янгир ямааны шилжилт хамрагдсан.

Түүнчлэн дээрх байршлаас гадна бусад газруудад амьтанд зориулсан гарц барих шаардлагатай газрууд судалгааны явцад тогтоогдсон байна. Тухайлбал, Ховд хотын хойд хэсэгт 10-ийн гарам, 2-ын хөтөл, Ховд хотын Хойд болон Урд улаан гэх газруудад янгир ямаа байршдаг бөгөөд Буянт голоос ундаалдаг байна. Баатархайрхан, Мөнххайрхан уулуудын янгир ямаа, аргаль хонины популяциуд харилцан солилцож байдаг бөгөөд хатуу хучилттай авто зам тус 2 газрыг зааглаж байгааг тогтоож, тодорхой газруудад гарц гаргах, тэмдэглэгээ хийх саналыг гаргасан байна.

Энэхүү тайланг бэлтгэхэд 2009 онд улсын хэмжээнд хийсэн уулын туруутны нөөцийн үнэлгээний тайланд хавсаргасан аргаль хонь, янгир ямааны тархцын зураглалыг ашигласан. Түүнээс хойш 8 жил өнгөрсөн бөгөөд аргаль хонь, янгир ямааны байршил ихээхэн өөрчлөгдсөн, шинэ газар нутгуудад тэмдэглэгдэх болсон байна. Мөн хуучин тэмдэглэсэн байршил нутаг нь ихээхэн нарийвчлалтай байсан тул аргаль хонь, янгир ямааны байршлыг шинэчлэн тогтоох шаардлага үүсэж байгаа ба дахин томоохон судалгаа хийх шаардлагатай байна.

Тал хээрийн туруутны нөөцийн үнэлгээг мөн 2009 онд хийсэн бөгөөд хар сүүлтийн судалгааг хийхдээ Ховд аймгийг орхигдуулснаас тус аймгийн нутагт хар сүүлт зээр тархаагүй мэтээр зураглагдсан боловч Манханд хар сүүлт байгааг судлаачид, орон нутгийн иргэд мэддэг нь тогтоогдсон тул үндэсний хэмжээний тайланд энэ асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

Зам, тээврийн салбарын зураг төсөл боловсруулах, угсралт хийх үед болон ашиглалтын явцад зэрлэг амьтадыг хэрхэн хамгаалах, шилжилт хөдөлгөөний чөлөөтэй нэвтрүүлэх асуудлыг тодорхой болгож эрх зүйн орчин сайжруулах буюу техникийн зохицуулалт тусгайлан тусгах шаардлагатай байна.

Тус стандартын 9.5 -д “Авто зам барих төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэхдээ тухайн зүйлийн амьтан судлаач болон авто замын төлөвлөлтийн инженерийн бүрэлдэхүүнтэй багийг оролцуулна.” гэж заасан боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд дээрх зохицуулалт тусгагдаагүйн улмаас практикт хэрэгжилт дутмаг байна.

Стандартын 9.11-д гарцад урсгал засварыг тогтмол, ээлжит засварыг 5 жил тутам, их засварыг 15 жил тутам, зэрлэг амьтдад хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэн бол хугацааг үл харгалзан засварыг гүйцэтгэнэ гэж заасан байна. Монгол улсын зам барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 216 тоот тушаалаар батлагдсан авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын техникийн шаардлага батлагдсан ба тус дүрэмд дээрх стандартад заасан засвар арчлалт хийх зохицуулалт зөрүүтэй тусгагдсан байна. Хууль зүйн хүчин чадлын хувьд техникийн зохицуулалт нь заавал дагаж мөрдөх баримт бичиг учраас тус стандартаар тогтоосон засвар, арчлалтын зохицуулалтын хэрэгжилт практикт хэрэгжих боломжгүй байна.

Түүнчлэн стандартын 9.8-д авто замын зурвас газрын дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага нүүдлийн амьтдыг хамгаалах зорилгоор хяналт тавьж нутгийн иргэдэд мэдээ, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулна гэж заасан боловч авто замын тухай хуулийн 12 дугаар зүйл аймаг, сум, дүүрэг, нийслэлийн засаг даргын эрх, үүрэг хэсэгт дээрх зохицуулалт тусгагдаагүйн улмаас мөн практикт хэрэгжилт дутмаг байна.

Стандартын 7.1-д инженерийн нарийвчилсан тооцоо судалгааг хийхдээ гарц төлөвлөж буй орчныг урьдчилан судалж, зүйлийн амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөний холбоос (коридор), эзэмшил нутаг байршлыг тодорхойлон, гарцын тохирох ангиллыг оновчтой төлөвлөж, экосистем, ландшафтын нэгдмэл байдлыг алдагдуулахгүй байх үндэслэлээр тогтооно гэж заасан.

Гэтэл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд аливаа төсөл эхлэхээс өмнө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ангилалд дэд бүтэц гэсэн ангилал тусгагдаагүй байгаагийн улмаас стандартын дээрх зохицуулалтын хэрэгжилт мөн практикт хэрэгжихэд хүндрэлтэй байна.

6.2.4. Шалгуур үзүүлэлт ба харьцуулах хэлбэр

Аргачлалын 3.4, 3.5, 3.6-д заасны дагуу хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ хамрах хүрээ болон шалгуур үзүүлэлт, түүний томъёоллыг дараах байдлаар тогтоож байна:

Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн томъёолол	Харьцуулах хэлбэр
1	Зорилгод хүрсэн түвшин	Хуулийн зорилтыг хангаж чадаж байна уу?	Байх ёстой болон одоо байгаа
2	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн зохицуулалтууд хэрэгжиж байна уу? Хэрэв хэрэгжилт сул бол шалтгаан юунд байна?	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
3	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Гэмт хэрэг, зөрчилд тооцсон үйлдэл, эс үйлдэл, түүнд хүлээлгэх хариуцлага оновчтой байна уу?	Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль үйлчилж эхлэхээс /2017-07-1/ өмнө болон хойш

- Зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтээр Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актуудад хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх дэвшүүлсэн зорилгын дагуу энэ төрлийн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтооно.
- Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актууд (Стандарт эрх зүйн акт биш) хэрэгжилттэй холбоотой гарч байгаа эерэг, сөрөг үр дагаврыг илрүүлж, улмаар түүнийг үүсгэж байгаа учир шалтгааныг тодорхойлно. Стандарт нь заавал дагаж мөрдөх бус сонгон хэрэглэх зохицуулалт бүхий баримт бичиг буюу хэм хэмжээ тогтоосон актад хамаарахгүй боловч манай судалгааны голлох зохицуулалтууд холбогдох стандартуудад нарийвчлан тусгагдсан байгаа учраас үнэлгээний практикт нийцэж байгаа байдал хэсэгт үнэлгээ хийх баримт бичигт оруулан үнэлсэн болно.
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтээр Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актуудаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуулиар оновчтой тогтоосон эсэх, түүний үр нөлөөг тодорхойлно. Стандартын шаардлага хангаагүй бол хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зөрчлийн хууль болон эрүүгийн хуулиар байхгүй. Харин холбогдох стандартыг дагаж, мөрдөнө гэж хуульд тусгайлан заасан бол хариуцлага хүлээлгэх үндэслэл бий болох юм.

Энэхүү үнэлгээний ажлыг гүйцэтгэх зорилгоор Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актуудын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, энэ чиглэлээр хийгдсэн төрийн болон ТББ-ын судалгаа, төрийн холбогдох байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн болон статистик тоон мэдээлэл зэргийг цуглуулсан болно.

Гурав. Үнэлгээний тайлан

6.3.1. Зорилгод хүрэх түвшин:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлд "...байгаль орчныг хамгаалах...", Амьтны тухай хуулийн 1 дүгээр зүйл "... амьтныг хамгаалах...", Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 1 дүгээр зүйл "...байгаль орчныг хамгаалах..." хэмээн хуулийн зорилтыг тодорхойлсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.11 дэх заалтад "...аливаа хуулийн зорилт нь тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгасан байх ёстой." гэжээ. Өөрөөр хэлбэл, хуулийн зорилтоос хамаарч тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа буюу хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, уг зохицуулалтад удирдлага болгох болон харгалзах нөхцөл байдал тодорхойлогддог.

Энэхүү шалгуураар зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актуудын зорилтыг үнэлбэл хууль тогтоомжийн хамрах хүрээ нэлээдгүй өргөн, ерөнхий тодорхойлогдсон байна. Тухайлбал, зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулах ерөнхий шаардлагуудыг байгаль орчин, амьтныг хамгаалах тухай хуулиудад нарийвчлан тусгаагүй ерөнхий тодорхойлсон ба дээрх шаардлагуудыг нарийвчлан тусгасан эрх бүхий байгууллагаас баталсан стандартууд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т «стандарт» гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан байдаг ба өөрөөр хэлбэл стандарт нь заавал дагаж мөрдөх хүчин чадал бүхий эрх зүйн

акт биш учраас тус стандартуудын хэрэгжилт практикт дутмаг байна.

Гэвч зохицуулалтын хүрээ нь байгаль орчныг хамгаалах, амьтан хамгаалах гэж тусгасан боловч шугаман дэд бүтэц барьж байгуулахад амьтдыг хэрхэн хамгаалах зохицуулалтууд дутмаг, хязгаарлагдмал байна.

Түүнчлэн Амьтны тухай хуульд амьтныг хамгаалах талаар дурдсан боловч яг яаж, ямар арга, хэлбэрээр хамгаалах нь ерөнхий байгаа бөгөөд нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлд амьтныг хамгаалах хэлбэрийг дурдсан боловч энэхүү зохицуулалт нь төдийлөн хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байна.

7 дугаар зүйл. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах

7.4. Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Тус зохицуулалтын дагуу нэн ховор, ховор амьтны амьдрах нутагт авто болон төмөр зам тавих тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхээр тусгасан боловч Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, холбогдох стандартууд нь уялдаа холбоогүй, практикт хэрэгжих боломжгүй тусгагдсанаас үүдэн дээрх амьтан хамгаалалтын заалт хэрэгжихгүй байна.

Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтад шугаман дэд бүтцээс зөвхөн авто болон төмөр зам хамаарч байгаа бөгөөд цахилгаан дамжуулах шугам, усны шугам, суваг барьж байгуулах төсөл нь хамаарахгүй болно.

Түүнчлэн уг зохицуулалт нь Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2-т зөвхөн заасан бөгөөд энэхүү зохицуулалттай уялдсан тухайлсан хууль буюу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд уялдсан зохицуулалт байхгүй болно. Өөрөөр хэлбэл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн ... зааснаар зөвхөн шинжээчийн дүгнэлт, орон нутгийн иргэдийн саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхээр заасан, Засгийн газар төслийг хэрэгжүүлэхийг шийдвэрлэх эрх бүхий этгээд биш болж болох бөгөөд Амьтны тухай хуулийн дээрх зохицуулалт нь энэхүү зохицуулалттай зөрчилдөж байна. Жишээ нь гашуун-сухайтын төмөр замын төсөл хэрэгжиж байгаа газар нутаг нь Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан нэн ховор амьтан болох хулан адууны үндсэн тархац нутгийг хуваан хэрэгжих бөгөөд төмөр замын гарц гарам нь хулангийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлөхөөргүй байх ёстой. Иймд тухайн төмөр замын маршрутыг батлах, зураг төслийг боловсруулах шатанд үүнийг анхаарах, түүнчлэн төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг төслийг хэрэгжиж эхлэхээс өмнө хийх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Төрийн захиргааны төв байгууллага нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу “байгаль орчныг хамгаалах” чиглэлийн хүрээнд тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтад заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын удирдлага,

бодлогын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцаж, байгаль орчны чадавхын хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тооцох аргачлалыг батлах чиг үүрэгтэй гэж заасан.

Гэтэл практикт стандарт боловсруулж, батлуулах ажлууд хэрэгжиж байгаа боловч тус стандартуудын биелэлтийг зохион байгуулах чиг үүрэг төдийлөн хангалттай хэрэгжихгүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн зорилгод тусгасан байгаль орчныг хамгаалах чиг үүргийн хүрээнд тус хуулийн 7.2-т заасны дагуу “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ” гэж тусгасан ба үүнд дэд бүтэц ангилал тусгагдаагүй орхигдсон байгаа нь зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлагагүй гэж ойлгогдохоор тусгагдсан байна. Энэ нь мөн тус хуулийн зорилгод хүрэх түвшин хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 5.4.9-д зааснаар харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх, Аймаг, нийслэлийн засаг дарга нь тус хуулийн 5.5.4-д зааснаар нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх, 6.1.11-д иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах чиг үүрэгтэй байна.

Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага MNS 6735:2018 стандартын 9.8-д авто замын зурвас газрын дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага нүүдлийн амьтдыг хамгаалах зорилгоор хяналт тавьж нутгийн иргэдэд мэдээ, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулна гэж тусгасан боловч энэ нь Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалттай уялдаа холбоогүй тусгагдсан байгаагаас үүдэн хэрэгжилт дутмаг байна.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2 дугаар зүйл. Амьтны тухай хууль тогтоомж

1. Амьтны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Хуулийн төсөл боловсруулах практикаас үзэхэд тухайн харилцааг зохицуулах хууль тогтоомжийг тодорхойлохдоо зохицуулалтад баримтлах зарчмыг тогтоож байгаа болон голлон хэрэглэгдэх хууль тогтоомжийг хамруулдаг. Нөгөө талаар эдгээр хууль тогтоомжийн зохицуулалт нь тус хуулийн зорилтыг хангах гол хэрэглэгдэхүүн байх ёстой.

Өнөөдрийн байдлаар Байгаль хамгаалах тухай хууль, Амьтны тухай хуулиар ерөнхий хамгаалалтын зохицуулалтыг ерөнхийлөн тусгасан. Эрчим хүчний тухай хуулиар эрчим хүчний дэд бүтэц барьж байгуулахад тусгай зөвшөөрөл авсан байхыг шаардах ба тус тусгай зөвшөөрөл авахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байх зохицуулалтыг тус тус заасан.

Дээрх хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар тус тус зохицуулж байна.

Мөн Монгол Улс нь Биологийн олон янз байдлын тухай конвенци, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцид тус тус нэгдэн орсон байна.

Цаашид хуулийн нарийвчилсан зохицуулалтыг Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэхэд анхаарах нь чухал байна.

6.3.2. Практикт нийцэж байгаа байдал:

Зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийн эрх зүйн актын хүрээнд эрчим хүчний салбарт эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн болон хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн гэсэн 2 үндсэн техник ашиглалтын дүрэм мөрдөгдөж байна.

Эрчим хүчний салбарт эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын дүрэм

1.12. Байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангах

1.12.8. Эрчим хүчний үйлдвэр, байгууллагууд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад байгаль орчны хамгаалалт, эрүүл ахуйн талаарх Монгол улсын бүх хууль тогтоомжуудын шаардлагыг хангаж ажиллах

Эрчим хүчний салбарт эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын дүрэм

5.7. Цахилгаан дамжуулах агаарын шугам

5.7.11.шувуу олноор үүрлэж, хөндийрүүлэгчийг их бохирдуулдаг бүсэд шувууг үргээх буюу хөндийрүүлэгч дээр суулгахгүй байх тусгай хэрэгсэл төхөөрөмж ашиглах хэрэгтэй.

Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрмийг өмчийн хэлбэрээс үл хамааран Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуйн нэгж байгууллагууд буюу хэрэглэгчид /эрчим хүчний салбарын үйлдвэр аж ахуйн нэгжээс бусад/ мөрдөхөөр заасан байдаг.

Дээрх дүрмийн 2.3.20-д тусгаарлагч нь шувуудын нөлөөгөөр илүү бохирддог буюу шувуудын үүр бөөнөөр байрласан газарт гирлянд дээр шувуу суулгахгүй айлган үргээх төхөөрөмж ашиглах нь зүйтэй гэж тусгасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.

Гэвч шинээр баригдаж буй шугам сүлжээг барих үед Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт дэд бүтэц гэж тусгаагүй боловч тус хуулийн хавсралт хэсэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхээр зөрүүтэй тусгаснаас үүдэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байгаа учраас шувуудын нүүдэл, түүнд нөлөөлөх асуудал нь судлагдахгүй түүнчлэн цахилгаан дамжуулах агаарын шугамуудад шувуу үргээх, түүнийг хамгаалах тоноглол хийгдэхгүй байна.

Дээрх 2 техник ашиглалтын дүрэмд цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалт, үйл ажиллагааны явцад шувуу хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх хангалттай заалт, техникийн нарийн шаардлага тусгаагүй улмаас орхигдох үндсэн шалтгаан болж байна.

2022 онд ЦДАШ, дэд станцын төслүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх судалгаагаар ЦДАШ-ын хувьд байгаль орчинд түүний дотор шувуудад үзүүлэх сөрөг нөлөө нь түгээх шугамын ашиглалтын үед илүү их тохиолдож байхад нөлөөллийг үнэлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хянах зэрэг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулсан ажлууд хийгдэхгүй орхигдож байна гэсэн дүгнэлт гарсан байгаа нь дээрх хуулийн зохицуулалт нь хэлбэрийн төдий зохицуулалт ба практикт хэрэгжилт дутмаг байна гэж дүгнэж болохоор байна. (“Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төслүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх төсөл” 2022 он)

Авто замын салбарт мөрдөгдөж буй эрх зүйн актуудад 2015 оноос өмнө зам, замын байгууламжийн төлөвлөлтийн норм дүрэмд гадаргуу, үерийн ус нэвтрүүлэх зориулалтаар усны тооцооны үндсэн дээр гүүр хоолойг төлөвлөж барьдаг байсан ба тусгайлан нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцыг тус чиглэлийн тооцоо судалгаан дээр үндэслэж барьж байгуулах эрх зүйн орчин, норм, норматив, стандарт бүрдээгүй байв.

Авто замын сүлжээ нь улсын чанартай 14,918.4 км олон улс, улсын чанартай авто замаас 7,551.5 км хатуу хучилттай авто зам бөгөөд 875 гүүрнүүд ашиглагдаж байгаа бөгөөд сүүлийн 10 гаруй жилд уул уурхайн салбарын тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдэж, тусгай зориулалтын авто замын урт 1.057,6 км болж цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Авто замын тухай хууль 2017 онд батлагдсанаар авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байх эрх зүйн орчин нэг талаас бүрдсэн юм.

19 дүгээр зүйл. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл

19.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлага:

19.2.1. зураг төсөл зохиох зургийн даалгавар, хайгуул геологийн судалгааны дүгнэлт, геодезийн хэмжилт, техникийн нөхцөл, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу боловсруулсан байх;

19.2.2. зорчигчдын эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байх;

19.2.3. авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах;

“Авто замын тухай хууль” 2017 онд батлагдаж, шинээр баригдаж буй авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулахад тус хуулийн 19 дүгээр зүйлд заасан шаардлагын бүрэн хангасан байхаар хуульчилсан байдаг.

Гэвч шинээр баригдаж буй авто зам, замын байгууламжийн барилга байгууламжуудын зураг төслийг боловсруулахдаа зураг төсөл зохиогч нь зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхгүй, дээрх шаардлагыг орхигдуулж улмаар зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хэвийн нэвтрүүлэх боломж алдагдаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх буюу ховор амьтад үрэгдүүлэх нэгэн шалтгаан болж байна.

Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байх гэж хуульд тусгасан боловч тус шаардлагыг дэлгэрэнгүй зохицуулсан холбогдох стандартуудыг тусгаагүйн улмаас практикт зураг төсөлд тусгагдахгүй орхигдох голлох шалтгаан болж байна.

Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1-д заасан техникийн нөхцөл, норм, норматив гэдэг нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд тодорхойлсноор техникийн зохицуулалтад хамаарах ба стандартууд нь 19.2.1-д тодорхойлсон баримт бичигт хамаарахгүй юм.

Авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээс өмнө байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг хийдэг боловч дээрх асуудал ихэнх тохиолдолд орхигддог тул зайлшгүй хийлгэж байх шаардлагатай бөгөөд хөрөнгө мөнгө санхүү хүндрэлтэй нөхцөл байдлаар шалтгаалан төдийлөн хийгдэхгүй байна.

Түүнчлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт төсөл эхлэхээс өмнө зайлшгүй байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх салбарын ангиллыг тусгасан ба тус ангилалд дэд бүтэц гэсэн ангилал тусгагдаагүй орхигдсон байгаа нь мөн дээрх хуулийн зохицуулалт практикт хэрэгжих боломжийг хязгаарлаж байна.

Төмөр замын салбарт Монгол улсын хойд хил Сүхбаатар өртөөнөөс урд хил Замын-Үүд өртөө хүртэл 1115 км төмөр замыг 1955 онд барьж ашиглалтад оруулсан ба Ази-Европыг холбосон олон улсын төмөр замын тээврийн гол коридор болсон ба эдийн засгийн хувьд нэн чухал салбар хэдий ч хамгаалалтын хориг хашаа нь биологийн төрөл зүйлийн амьдрах орчны хувьд хоёр хэсэгт хуваан тал хээрийн тууртан амьтдад шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, үхэл хорогдолд нөлөөлж байгааг мэргэжлийн байгууллага,

эрдэмтэн, судлаачдын 2013-2018 оны хооронд хийсэн мониторингийн судалгаагаар тогтоосон боловч эрх зүйн орчин төдийлөн бүрдээгүй байв.

2018 онд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018, 2015 онд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартуудыг батлагдсанаар тухайн чиглэлээр авто зам, төмөр замын салбарт нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх шаардлагыг тусгасан баримт бичгийг баталсан юм. Түүнээс өмнө баригдсан төмөр зам барьж байгуулахдаа нүхэн гарц, гармыг байгаль орчныг хамгаалах зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн замыг судалгаан дээр үндэслэн төлөвлөж, байгуулаагүй байна.

Төмөр замын зурвас газрын асуудал нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.”, Газрын тухай хуулийн “Улсын тусгай хэрэгцээ”-ны талаар 16 дугаар зүйлийн 16.1.13-т “үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар”, 16.3-т “Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно”, 18 дугаар зүйлийн 18.1.3-т “улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох”, 42.1-д “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.” гэж тус тус тусгасан байдаг.

Түүнчлэн “Төмөр замын зурвас газарт тавигдах шаардлага” 6060:2010, Төмөр замын зурвас газар болон аюулгүй бүсийн дэглэм, Төмөр замын аюултай бүсийн дэглэм, Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам зэрэг баримт бичгээр зохицуулагддаг байна.

Төмөр замын зурвас газар, аюулгүй бүс болон аюултай бүсийн эрх зүйн орчны зохицуулалтад зэрлэг амьтан, нүүдлийн замд үзүүлэх сөрөг нөлөөллийг тусгаагүй байна.

2015 онд “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” батлагдсан ба тус стандартаар тал хээр, говийн бүс нутагт тархсан хулан адуу, хар сүүлт, цагаан зээр, аргаль хонь, янгир ямаа, монгол бөхөн зэрэг зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх, барьж байгуулах, ашиглахад хамаарахаар тусгасан боловч тус салбарын гол эрх зүйн акт болох Төмөр замын тээврийн тухай хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй орхигдсон гэж үзэхээр байна. Тухайлбал хуулийн нэр томъёо хэсэгт “Нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц” гэх нэршил тусгагдаагүй орхигдсон ба тус хуулийн 3.1.10-д “төмөр замын гарам” гэж авто болон явган хүний зам төмөр замтай нэг түвшинд огтлолцсоныг хэлнэ.” гэж тодорхойлсон ба тус тодорхойлолтоос үзэхэд зэрлэг амьтдад хамааралгүй мэт ойлгогдохоор байна.

Түүнчлэн тус хуулийн 17.1-д “Төмөр замын тээврийн салбарт баримтлах стандартыг энэ хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ” гэж тусгасан боловч хэн тус стандартын хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх нь тодорхойгүй тусгагдсанаар практикт хэрэгжих боломж дутмаг байна гэж үзэхээр байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын хамтарсан 2013 оны А192/145, 2016 оны А/93-74 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Улаанбаатар-Замын-Үүд хүртэлх төмөр замын дагуух хамгаалалтын өргөст торыг хэсэгчлэн авч, зэрлэг амьтад төмөр замыг аюулгүй, чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлж, холбоос нутаг бий болгохоор 2019, 2022 онуудад ЗТХЯ, БОАЖЯ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, Замын 4-р анги, мэргэжлийн байгууллагуудтай хамтран шилжилт хөдөлгөөний эрчимтэй цэгүүдийн судалгаанд үндэслэн Дорноговь аймгийн Даланжаргалан, Алтанширээ, Өргөн сумдын нутагт 825-р км-т 300 м, 914-р км-т 500 м, 957-р км-т 700 м нийт 3 байршилд 1,500 м хамгаалалтын өргөст тор авах, торны бүтэц өөрчлөх ажлыг хийж, тор авсан байршлуудаар зэрлэг амьтад төмөр зам хөндлөн гарч буй цэгийг тогтоох зорилгоор автомат камерын тусламжтай мониторинг хийсэн.

Түүнээс гадна тор нээх боломжтой айл, болон малын хөдөлгөөн бага, зэрлэг амьтад ихээр байршдаг газруудыг тогтоохын тулд Дорноговь аймгийн Замын-Үүд болон Айраг сумдын хооронд төмөр замын камераар мониторинг хийсэн байна.

Дээрх мониторингийн судалгаагаар 1955 оноос хойш өргөст торноос болж популяци нь хумигдсан хулан адуу төмөр замын зүүн талд түүхэн тархац нутагтаа шилжилт хөдөлгөөн гарсан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд зэрлэг амьтад зориулсан зориулалтын гарц, гарам барьж байгуулах, цаашид шинээр барих төслүүдэд мөн стандартын дагуу барьж байгуулах нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэж байна.

6.3.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

58 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Амьтны тухай хууль

39 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 39.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан “нэн ховор амьтны амьдрах нутагт ... авто зам болон төмөр зам барих тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ” гэж заасны дагуу хэрэв Засгийн газрын шийдвэргүйгээр авто зам болон төмөр зам барьснаас үүдэн нэн ховор амьтанд хохирол учирсан тохиолдолд зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх үндэслэлгүй байна.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг

иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.” гэж заасан ба иргэн, хуулийн этгээд нь 6.1.7-д зааснаар үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй байна. Гэвч Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд амьтны тухай хууль зөрчих гэх бүлэг байх боловч зохих зөвшөөрөлгүй амьтан барьсан, агнасан, ашигласан бол хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Эрүүгийн хууль

24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах
 2. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуульд мөн нэгэн адил тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн тохиолдолд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээхээр заасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

19 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
 19.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих	Оногдуулах арга хэмжээ
1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол	хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
3 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол	хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
4 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон бол	Хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрчим хүчний тухай хууль

37 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.8 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хууль зөрчих		Оногдуулах арга хэмжээ
1	5.Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хуульд заасан үүрэг, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар ашиглалт, аюулгүй ажиллагааны норм, стандарт, дүрэм, журам, Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолыг зөрчсөн, эсхүл үйлдвэрлэлийн осол, аваар гаргасан, эд хөрөнгийн хохирол учруулсан, эсхүл техникийн гэмтэл гаргахад хүргэсэн бол	Хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Авто замын тухай хууль

35 дугаар зүйл. Авто замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

35.4. Авто замын тухай хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг зөрчсөн, авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан шийтгэл ногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн Тайлбар: Авто замын ашиглалтын нөхцөл хангагдаагүйгээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хохирол учирсан болохыг хууль, хяналтын байгууллага тогтоосон бол тухайн авто замын арчлалт, хамгаалалт хариуцсан авто замын байгууллага уг хохирлыг хариуцан төлнө” гэж заасан ба дээрхээс үзвэл байгаль орчин, амьтанд хохирол учирсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох үндэслэлгүй байна.

Төмөр замын тээврийн тухай хууль

34 дугаар зүйл. Авто замын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

34.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

14.10 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хууль зөрчих		Авах арга хэмжээ
2	Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, стандарт, холбогдох норм, дүрмийг зөрчсөн бол	хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Авто зам болон төмөр замын барилга байгууламж барихад ан амьтдыг хамгаалах зохицуулалт бүхий стандартууд нь бус сонгож хэрэглэх зохицуулалттай учраас дээрх стандартуудыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээх үндэслэлгүй байна.

6.4. Холбогдох зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа. дүгнэлт

ШУГАМАН ДЭД БҮТЦЭЭС ЗЭРЛЭГ АМЬТАНД НӨЛӨӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ХОЛБОГДОХ ХУУЛИУДЫН ДАВХАРДАЛ ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙН СИСТЕМЧЛЭЛ

1. Давхардал 4

7.1.2	Тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх	3
7.1.3	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх	1

2. Зөрчил 1

7.2.13	тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх	4
--------	--	---

3. Хийдэл 11

7.3.6	Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	6
7.3.8	хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх	5

Шугаман дэд бүтцээс зэрлэг амьтанд нөлөөлөх нөлөөллийг бууруулахтай холбоотой холбогдох хуулийн зохицуулалтын давхардлыг ХЗДХЯ-аас гаргасан "Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал"-д заасан шалгуурын дагуу тогтоолоо. Үүнд дараах хуулийн холбогдох зохицуулалтыг сонгон авч үзлээ.

1. Байгаль орчныг хамгаалах тухай
2. Амьтны тухай хууль
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
4. Эрчим хүчний тухай хууль
5. Авто замын тухай хууль
6. Монгол Улсын стандарт

I. Энэхүү үнэлгээг хийхдээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахтай холбоотой гол малгай хууль болох Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн шугамд дэд бүтцээс зэрлэг амьтанд нөлөөлөх нөлөөллийг бууруулахтай холбоотой зохицуулалтын холбогдох бусад хуультай давхардсан зохицуулалтыг дараах байдлаар тогтоолоо:

ДАВХАРДАЛ:

7.1.2 Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд бичвэрийн, эсхүл агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх

д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/
1.	<p>7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ 4. Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ олгоно.</p>	<p>12 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох 12.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.7-д заасан тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.</p>
<p>Дүгнэлт: Агуулгын хувьд давхардуулсан мэт боловч энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу эшлэл авсан тул давхардал үүсэхгүй. Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 7.4 дэх хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд эшлэх.</p>		

д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.01/
2.	<p>7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ 5. Дараах шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно: 1/үнэлгээний багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх; 2/хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх; 3/магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаас батлагдсан байгаль орчны үнэлгээ хийх арга зүйтэй байх; 4/үнэлгээ хийх асуудлаарх мэдээллийн сантай байх.</p>	<p>12 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох 12.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргасан байна: 12.2.1. аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тухай танилцуулга; 12.2.2. үнэлгээний ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан, материаллаг бааз, боловсон хүчний хангамж болон чадавхыг илтгэх бичиг баримтууд.</p>
<p>Дүгнэлт: Агуулгын хувьд давхардуулан хуульчилсан байна. Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 7.5 дахь заалтыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд эшлэх.</p>		

Журамтай харьцуулсан давхардал:

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	Аж ахуйн нэгж байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам Засгийн газрын тогтоол 2006 оны №137
3.	<p>30 дугаар зүйл. Мэргэжлийн байгууллага</p> <p>1. Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.</p>	<p>1.2. Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хууль болон байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.</p>
<p>Дүгнэлт: Агуулгын хувьд хууль дээрх зохицуулалтыг журамд хуулбарлан зохицуулсан байна.</p> <p>Санал: 2006 оны Засгийн газрын тогтоолоор батлагдсан “ Аж ахуйн нэгж байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”-ын зохицуулалтыг хүчингүй болгох.</p>		

7.1.3 Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх

Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/		
4.	<p>16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>2. Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p>	<p>17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх</p> <p>2. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; /Энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</p>

Дүгнэлт: Аймаг нийслэл, сум дүүргийн засаг даргын бүрэн эрхийг давхардуулан хуульчилсан байна.

Санал:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 зүйлийн 17/4 дэх хэсгийг хүчингүй болгох;
2. 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад “нийслэлийн” гэсний дараа “сум, дүүргийн” гэж нэмэх.

ЗӨРЧИЛ:

7.2.13 Хуулийн зүйл, заалт нь тухайн хууль болон өөр хуулийн заалттай зөрчилдөж байгаа эсэх

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	
1.	<p>54 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг</p> <p>4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p>	<p>54 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг</p> <p>8. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p>
<p>Дүгнэлт: Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд нөхөн төлбөрийн орлогын 15 хувиар тооцож урамшуулах уу 150,000 төгрөгийн урамшуулал олгох уу гэдэг нь зөрүүтэй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 150000 төгрөгтэй хэсгийг хүчингүй болгож, мөн зүйлийн 4 дэх хэсэгтэй нийцүүлэн өөрчлөн найруулах.</p>		

ХИЙДЭЛ:

7.3.6 Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/	
1.	<p>9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</p> <p>4. Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.</p>	
<p>Дүгнэлт: Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг зааж өгөөгүй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Эрүүгийн тухай хуульд хэрхэн ямар хариуцлага тооцох тусгаж өгөөгүй байна. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэх.</p>		

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
2.	<p>10¹ дугаар зүйл. Байгаль орчны аудит</p> <p>1. Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.</p> <p>5. Төрийн аудитын байгууллагаас байгаль орчны санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.</p>
<p>Дүгнэлт: Байгаль орчны аудитыг зөвхөн байгаль орчны нөөц, баялгийг ашиглах үйлдвэрлэл, үйлчилгээнд хийхээр заасан нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудитыг хийх хуулийн хязгаарлалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан байна. Шугаман дэд бүтцийн төсөл нь тухайлбал, Монгол Улсын босоо тэнхлэгийн авто болон төмөр замын төсөл нь буюу хулан, хар сүүлтий, цагаан зээр, хавтгай тэмээ зэрэг нэн ховор, ховор, элбэг туурайтан амьтны тархац нутгаар дайран өнгөрдөг, тэдгээр амьтны нүүдлийн замыг хаан боогдуулснаас үүдэн үржил сэлэцэд орох нь байхгүй болсон байдаг. Иймд шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудит хийх эрх зүйн орчныг бүрдүүлж, тухайн төсөл нь хууль, дүрэм журам, байгаль орчны стандартад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, зөвлөмж өгдөг цаашлаад амьтанд ээлтэй стандартыг мөрдүүлэхэд хөшүүрэг болох юм. Үүгээр шугаман дэд бүтцийг стандартын дагуу барьж байгуулдаг болохоос гадна одоо баригдсан байгаа тухайн дэд бүтцийг амьтанд ээлтэй шинэ стандартад нийцүүлэн засварлах боломжтой болох ач холбогдолтой.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд байгаль орчны аудитыг хийх төслийн жагсаалтыг байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 4 жил тутамд байгаль орчны бодлого шийдвэртэй уялдуулан жагсаалтыг баталдаг байх зохицуулалтыг тусгах.</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
3.	<p>27 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг</p> <p>2. Улсын байцаагч дараах үүрэгтэй байна:</p> <p>1/байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;</p> <p>4/илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;</p> <p>6/байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.</p>
<p>Дүгнэлт: Байгаль орчныг хамгаалахад улсын байцаагчийн үүргийг зааж өгсөн бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тусгаж өгөөгүй байна. Мөн 27.2.1-д стандартыг орхигдуулснаар холбогдох стандартуудаар хамгаалагдсан амьтдын хамгаалагдах эрхийг орхигдуулан хуульчилсан байна. Тухайлбал, шугаман дэд бүтцийг барьж байгуулахдаа холбогдох стандартын дагуу бариагүй тохиолдолд улсын байцаагчаас өсгөн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд оногдуулах хариуцлагыг тусгайлан тусгаж өгөөгүй байна.</p> <p>Санал: Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зөрчсөн тохиолдолд тусгайлан хүлээлгэх хариуцлагыг нэмэх. Мөн зүйлийн 27.2.1-д дүрэм, журам гэсний ард стандартууд гэж нэмэх</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
4.	<p>31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна:</p> <p>1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;</p> <p>2/эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;</p> <p>3/үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;</p> <p>4/байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;</p> <p>5/гэрээний дагуу тарьж ургуулсан ой, ургамал, үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан усны ундарга, засаж тохижуулсан газрыг сум, дүүргийн Засаг даргад хугацаанд нь хүлээлгэн өгөх;</p> <p>6/төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх.</p> <p>7/бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.</p> <p>8/хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах;</p> <p>9/өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх;</p> <p>10/байгаль орчинд хохирол учруулж болох аливаа үйлдлээс татгалзах.</p>
	<p>Дүгнэлт: Байгаль орчныг хамгаалахад аж ахуйн нэгж байгууллагын үүргийг зааж өгсөн бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тусгаж өгөөгүй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Эрүүгийн тухай хуульд хэрхэн ямар хариуцлага тооцох тусгаж өгөөгүй байна. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэх.</p>

д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
5.	<p>49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</p> <p>8. Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.</p>
<p>Дүгнэлт: Байгаль орчинд хохирол учруулсан бол нөхөн төлбөр ногдуулах бөгөөд нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй. Хэрэв 14 хоногт багтаан төлбөрийг барагдуулаагүй бол хүлээлгэх хариуцлагыг зааж өгөөгүй байна. Стандартын шаардлага хангаагүй өндөр хүчдэлийн шугамд шувуу сууж тогонд цохиулж үхсэнээс байгаль орчин, амьтны аймагт учирсан хохиролыг тооцон тухайн шугамыг эзэмшиж байгаа этгээдээс гаргуулах нь зүйтэй бөгөөд хохирлыг барагдуулах хугацаанд барагдуулаагүй бол тодорхой хэмжээгээр алданги, торгууль, шийдвэрийн биелэлтийг хангуулах хөшүүрэг хэрэгтэй.</p> <p>Санал: Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээрх хөшүүргийг тусгайлан оруулах нь зүйтэй.</p>	

д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
6.	<p>57 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</p> <p>1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p>
<p>Дүгнэлт: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль учруулсан хохирлыг нөхөн төлөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой зааж өгөөгүй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Эрүүгийн тухай хуульд хэрхэн ямар хариуцлага тооцох тусгаж өгөөгүй байна. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмэх.</p>	

7.3.8 Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх

д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль/1995.03.30/
7.	<p>54 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг</p> <p>4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.</p>
<p>Дүгнэлт: Зөвхөн иргэнд урамшуулал олгохоор зохицуулсан байна. Хэрэв байгууллага бодитой мэдээлэл өгсөн бол яах вэ гэдэг нь тодорхойгүй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 зүйлийн 54.4-г “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэн, хуулийн этгээд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно” гэж өөрчлөх.</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль/1995.03.30/
8.	<p>49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</p> <p>1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно.</p>
<p>Дүгнэлт: Зөвхөн иргэн аж ахуйн нэгж байгууллага байгалийн нөөцөд хохирол учруулахаар заасан байна. Хэрэв албан тушаалтан байгалийн нөөцөд хохирол учруулсан бол хариуцлага хүлээхээргүй байна.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д албан тушаалтан гэж нэмэх.</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль/1995.03.30/
9.	<p>4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг</p> <p>1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ: 1/гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;</p>
<p>Дүгнэлт: Байгаль орчинд хортой нөлөөлснөөс хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан бол зөвхөн гэм буруутай иргэн учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй, аж ахуйн нэгж байгууллага нэхэмжилж болохгүй юм шиг зохицуулсан байна. Тухайлбал, стандартын дагуу баригдаагүй цахилгаан дамжуулах шугам дээр шувуу сууж тогонд цохиулсны улмаас цахилгаан тасрах, уг тасалдлаас иргэн, аж ахуй нэгжид учирсан хохирлыг гэм буруутай этгээд төлөх ёстой бөгөөд иргэнээс гадна аж ахуй нэгж, эсхүл хуулийн этгээдэд хохирол учирч болно.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 зүйлийн 4.1/1 заалтыг “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд хортой нөлөөлсөн бол гэм буруутай этгээд бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх” гэж өөрчлөх.</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
10.	Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй
<p>Дүгнэлт: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд улсын мэдээллийн санд төвлөрүүлэх мэдээллийн төрлүүдийг зааж өгсөн боловч байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл гэж ерөнхий тусгасан ба эрх бүхий байгууллагаас баталсан стандартыг зөрчсөнөөс байгаль орчинд хор хохирол учирсан тохиолдолд дээрх нөхцөлд хамаарах эсэх нь тодорхойгүй орхигдуулан зохицуулсан байна. Ялангуяа байгаль орчны холбогдох стандартыг хангаж ажиллаагүйн улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэх, цаашлаад гэмт хэрэг, зөрчил үүсэх нөхцөл бүрдэнэ.</p> <p>Санал: Байгаль орчныг хамгаалах тухай 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 22 дах заалт “35.1.22. “эрх бүхий байгууллагаас баталсан стандартыг зөрчсөнөөс учирсан хохирол” гэж нэмэх.</p>	

Д/д	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995.03.30/
11.	Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй
<p>Дүгнэлт: Байгаль орчныг хамгаалах тухай хуульд мэдээллийн санд ямар байгууллага, хэдий хугацаанд мэдээллээ хэрхэн төвлөрүүлэх талаар тодорхой заагаагүй орхигдуулсан байна.</p> <p>Санал: Эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх стандартыг зөрчсөнөөс байгаль орчинд хохирол учирсан тохиолдолд тухайн зөрчлийн мэдээллийг ямар албан тушаалтан ямар хугацаанд тус мэдээллийн санд тусгах зохицуулалтыг тусгах шаардлагатай.</p>	

САНАЛ:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг бусад хуультай болон Улсын их хурал, Засгийн газар, холбогдох яам, агентлагаас гаргасан шийдвэр зэргийг давхар харьцуулсны үндсэн дээр дараах саналыг гаргаж байна. Судалгааны ажлын хүрээнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль сонгон судалсан хуулиудтай давхардал - 5
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль сонгон судалсан хуулиудтай зөрчил - 1
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль сонгон судалсан хуулиудтай хийдэл - 11 тогтоосон байна.

Давхардлын талаар:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 4, 5 дахь хэсэг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 4 дэх хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд эшлэх.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дахь заалт нь мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалттай давхардаж байгаа нь тухай аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын чиг үүрэг давхардсанаар хэн уг үйл ажиллагааг хийх нь тодорхойгүй болгож байна. Иймд
3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 5 дахь хэсэг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 зүйлийн 12.2 хэсэгтэй агуулгын хувьд давхардсан байна. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 зүйлийн 7.5 дах хэсгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд эшлэх.

Зөрчлийн талаар:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 зүйлийн 4 дэх хэсгийг “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн **иргэн, хуулийн этгээд** зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно” гэж өөрчлөх.
2. **54 дугаар зүйлийн** 1-д Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна гэдгийг тодорхой болгох.

Нэр томъёоны зөрчлийн талаар: Захиалагч этгээд эсвэл төсөл санхүүжүүлэгч гэж аль нэг үгийг сонгож хэрэглэх. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хасаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэр томъёог хэвээр үлдээх.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 заалтыг “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж өөрчлөх.

Хийдлийн талаар:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй бөгөөд үүргээ биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд нэмэлтээр тусгах.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд байгаль орчны аудитыг хийх төслийн жагсаалтыг байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 4 жил тутамд байгаль орчны бодлого шийдвэртэй уялдуулан жагсаалтыг баталдаг байх зохицуулалтыг тусгах. Үүгээр шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудитыг хийж байх зайлшгүй шаардлагыг хангах юм.
3. Байгаль орчинд хортой нөлөөлснөөс хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан бол зөвхөн гэм буруутай иргэн учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй, аж ахуйн нэгж байгууллага нэхэмжилж болохгүй юм шиг зохицуулсан байна. Тухайлбал, стандартын дагуу баригдаагүй цахилгаан дамжуулах шугам дээр шувуу сууж тогонд цохиулсны улмаас цахилгаан тасрах, уг тасалдлаас иргэн, аж ахуй нэгжид учирсан хохирлыг гэм буруутай этгээд төлөх ёстой бөгөөд иргэнээс гадна аж ахуй нэгж, эсхүл хуулийн этгээдэд хохирол учирч болно. Иймд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 зүйлийн 4.1/1 заалтыг “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд хортой нөлөөлсөн бол гэм буруутай этгээд бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх” гэж өөрчлөх.
4. Байгаль орчныг хамгаалах тухай 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 22 дах заалт нэмэх,

“35.1.22. “эрх бүхий байгууллагаас баталсан стандартыг зөрчсөнөөс учирсан хохирол” гэж нэмэх.

Нэр томъёоны зөрчлийн талаар: захиалагч этгээд эсвэл төсөл санхүүжүүлэгч гэж аль нэг үгийг сонгож хэрэглэх. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг хасаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн нэр томъёог хэвээр үлдээх.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 зүйлийн 49.2/4 хэсэг, 49 зүйлийн 49.3 заал, Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 заалтуудад заасан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль орчны байцаагч гэсэн нэр томъёог Байгаль орчны хяналтын улсын байцаагч гэж өөрчлөх.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 заалтыг “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж өөрчлөх.

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХИЙДЭЛ, ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

Хэрэглэсэн арга: Баримт бичиг судлах;
Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
Харьцуулалт хийх /synopse/;
Ярилцлагын арга;

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

- Амьтны тухай хуультай шууд холбоотой олон улсын гэрээ, хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Цуглуулан нэгтгэсэн хууль, эрх зүйн акттай Амьтны тухай хуулийг харьцуулж, уг хуульд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг судлах;
- Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган холбогдох санал боловсруулж Захиалагч талд шилжүүлэх;

Цуглуулсан эрх зүйн актууд:

Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хийдэл, давхардал, зөрчлийг арилгах, бусад хуулиудыг уялдуулах ажлын хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомж, Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэхээр Засгийн газар, Улсын Дээд Шүүх, холбогдох яам агентлагаас баталж гаргасан доорх эрх зүйн актууд байна. Үүнд:

- Амьтны тухай хуультай шууд холбогдох хууль

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

1. Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтын дотоод давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
2. Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
3. Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг Засгийн газрын тогтоолтой харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх,
4. Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалтай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг илрүүлэх

Хуулийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Монгол Улсын Их Хурлын 2012.05.17-ны өдөр Амьтны тухай хуулийг шинэчлэн баталсан. Амьтны тухай хууль нь 5 бүлэг 39 зүйлтэй. Хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Уг хууль нь 2000 онд гарсан Амьтны аймгийн болон Ан агнуурын тухай хуулиудыг нэгтгэсэн зохицуулсан онцлогтой.

Амьтны тухай хуулиар дараах харилцааг зохицуулж өгсөн:

Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт уг хуульд хамаарах хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, төрийн болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг зааж өгсөн.

Хоёрдугаар бүлэг - Амьтан хамгаалах

Энэ бүлэгт амьтан хамгаалах хэлбэр, нэн ховор, ховор амьтныг хамгаалах, амьтныг сэргээн нутагшуулах, агнуурын ан амьтан агнах, барихыг хориглох хугацаа, хориглох арга, зэвсэг, хэрэгсэл, агнуурын амьтан агнах барихад хориглох зарим үйл ажиллагааг тус тус зааж өгсөн.

Гуравдугаар бүлэг - Амьтныг өмчлөх, эзэмших, ашиглах, ан агнуур

Энэ бүлэгт амьтан өмчлөх болон эзэмших, ашиглах хэлбэр, амьтан ашиглах эрхийг хүчингүй болгох үндэслэл, амьтны цуглуулга, иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах,

- агнуурын амьтны сан, түүний байршил нутгийг эзэмших, ашиглах, агнуур зохион байгуулалт, түүний санхүүжилт, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох;
- агнуурын амьтан агнах, барих эрх, зориулалт, агнах барих зөвшөөрөл, агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох, ангийн буу, сумны захиалга, зарцуулалт зэргийг тусгасан.

Дөрөвдүгээр бүлэг - Амьтны мэдээллийн сан, төлбөр, санхүүжилт

Энэ бүлэгт Амьтны мэдээллийн сан, төлбөр, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулж өгсөн.

Тавдугаар бүлэгт - Бусад зүйл

Энэ бүлэгт амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, энэрэнгүй хандах, амьтны тоо толгойг зохицуулах, амьтныг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах, амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгажээ.

Эдгээр зохицуулалтаас шугаман дэд бүтцийг барьж байгуулахад амьтныг хамгаалах, үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалтыг сонгон авч давхардал, зөрчил, хийдлийн үнэлгээг хийлээ.

6.1. Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална:

6.1.3. амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй бай

6.2. Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Нэн ховор, ховор амьтныг хамгаалах

7.1. Нэн ховор амьтанд Мазаалай баавгай /*Ursus arctos gobiensis*/, Хавтгай тэмээ /*Camelus bactrianus ferus*/, Тахь адуу /*Equus ferus przewalskii*/, Ойн буган цаа /*Rangifer tarandus*/, Цоохор ирвэс /*Uncia uncial*/, Баданга хүдэр /*Moshus moschiferus*/, Молцог хандгай /*Alces alces*/, Татаар бөхөн /*Saiga tatarica*/, Голын халиу /*Lutra lutra*/, Азийн минж /*Castor fiber*/, Ойн унтаахай /*Dryomys nitedula*/, Зүүн гарын даахай /*Stylodipus sungorus*/, Борцгор хотон /*Pelicanus crispus*/, Хургац бор /*Paradoxornis heudei*/, Цагаан тогоруу /*Grus leucogeranus*/, Хар мөрний хилим /*Acipenser schrenckii*/, Шаргал үхэрдэй /*Tinca tinca*/, Цөөвөр чоно /

Cuon alpinus/, Шивэр молцог хандгай /Alces alces pfizenmayeri/, Дорнын молцог хандгай / Alces alces cameloides/, Соргог бөхөн /Saiga tatarica/, Монгол бөхөн /Saiga borealis/, Алтайн чацуулин /Talpa altaica/, Гозоорой зурам /Citellus alaschanicus/, Сухайн чичүүл /Meriones tamariscinus/, Давжаа алагдаага /Allactaga elater/, Цагаантолгойт ямаансүүл /Oxyura leucosephala/, Могойч загалай /Circaetus gallicus/, Бор бүргэд /Aguilla clanga/, Усны нөмрөгбүргэд /Aguila clanga/, Реликт цахлай /Larus relictus/ зэрэг амьтан хамаарна.

7.4. Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

7.6. Ховор амьтны жагсаалтыг Засгийн газар батална.

I ХЭСЭГ. ДҮГНЭЛТ АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙН СИСТЕМЧЛЭЛ

1. Зөрчил

1

Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хийдлийг ХЗДХЯ-аас гаргасан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу тогтоолоо.

III. Амьтны тухай хуулийн холбогдох зохицуулалт нь зөрчил байгаа эсэхийг дараах аргачлалаар тогтоолоо:

д/д	Амьтны тухай хууль /2012 он/	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012 он/
1.	<p>6.1. Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална:</p> <p>6.1.3. амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах</p> <p>6.2. Энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ.</p> <p>7.4. Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p>7.6. Ховор амьтны жагсаалтыг Засгийн газар батална.</p>	<p>10 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ</p> <p>10.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p>

Дүгнэлт: Амьтны тухай хуульд зааснаар амьтны аймгийн хамгаалах нэг хэлбэр нь амьтны тархац нутгийн хэмжээнд ховордлын зэргээр нь нэн ховор, ховор, элбэг гэж ангилах бөгөөд тархац нутгийг нэн ховор, ховроос хамааран хамгаалах нь өөр өөр байна.

Тухайлбал, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т нэн ховор амьтны тархац нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр заасан. Гэвч уг зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд үүнтэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд харин уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж заасан нь зөрчил үүсгэхээр байна. Тодруулбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд зөвхөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн дүгнэлт, тухайн орон нутгийн саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэхээр заасан нь Амьтны тухай хуулийн дээрх зохицуулалттай зөрчилдөж байна. Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан нэн ховор амьтны тархац нутагт авто замын төслийг хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэх тухайн нэн ховор амьтны хамгааллыг хэрэгжүүлэх нэг хэлбэр бөгөөд бодлогын хувьд нэн ховор амьтныг хамгаалах ач холбогдолтой юм.

Гэвч ялангуяа авто замын төсөл дээр Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан хэмжээг хэрэглэсэн тохиолдолд байдаггүй. Тухайлбал, Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын төсөл нь хулан, хавтгай зэрэг нэн ховор, хар сүүлтий зэрэг ховор амьтны тархац нутгийг хамтруулан, голлон хувааж төсөл хэрэгжсэн. Харин уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлээгүй, зөвхөн төмөр замын маршрутын цэг, болон бусад шийдвэрийг гаргасан байдаг. Энэ нь Амьтны тухай хуульд заасан тухайн зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд ороогүй, түүнчлэн хоорондоо зөрчилтэй байсан учир түүнийг мэргэжлийн байгууллага болон холбогдох яам нь хэрэгжүүлэлгүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль буюу тухайлсан хуулийн зохицуулалтыг баримтлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна. Ингэж Засгийн газрын хуралдаанаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлээгүй нь тухайн нэн ховор амьтныг хамгаалах Засгийн газрын үүргийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна гэж үзэж байна.

Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан агуулга бүхий зохицуулалтыг нэмж тусгах. Тодруулбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн Амьтны тухай хуулийн 7.2-т зааснаас бусад төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулах, мөн зүйлд “10.5. Амьтны тухай хуулийн 7.2-т заасан тохиолдолд нөлөөллийн үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, орон нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.” гэсэн хэсгийг нэмж, бусад хэсгийн дугаарлалтыг өөрчлөх нь зүйтэй болно.

II ХЭСЭГ. САНАЛ

Амьтны тухай Монгол Улсын хуульд заасан шугаман дэд бүтэцтэй холбоотой төслийг хэрэгжүүлэхэд амьтны аймгийг хамгаалахтай холбоотой зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бусад хуультай харьцуулан давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд нийт шууд хамааралтай 22 хуулийг харьцуулсан бөгөөд УИХ, Засгийн газар, холбогдох яамнаас гаргасан шийдвэр зэргийг давхар харьцуулсны үндсэн дээр дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Амьтны тухай хуульд зааснаар амьтны аймгийн хамгаалах нэг хэлбэр нь амьтны тархац

нутгийн хэмжээнд ховордлын зэргээр нь нэн ховор, ховор, элбэг гэж ангилах бөгөөд тархац нутгийг нэн ховор, ховроос хамааран хамгаалах нь өөр өөр байна.

Тухайлбал, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т нэн ховор амьтны тархац нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр заасан. Гэвч уг зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд үүнтэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд харин уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж заасан нь зөрчил үүсгэхээр байна. Тодруулбал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд зөвхөн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн дүгнэлт, тухайн орон нутгийн саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэхээр заасан нь Амьтны тухай хуулийн дээрх зохицуулалттай зөрчилдөж байна. Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан нэн ховор амьтны тархац нутагт авто замын төслийг хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэх тухайн нэн ховор амьтны хамгааллыг хэрэгжүүлэх нэг хэлбэр бөгөөд бодлогын хувьд нэн ховор амьтныг хамгаалах ач холбогдолтой юм.

Гэвч ялангуяа авто замын төсөл дээр Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан хэм хэмжээг хэрэглэсэн тохиолдолд байдаггүй. Тухайлбал, Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын төсөл нь хулан, хавтгай зэрэг нэн ховор, хар сүүлтий зэрэг ховор амьтны тархац нутгийг хамтруулан, голлон хувааж төсөл хэрэгжсэн. Харин уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлээгүй, зөвхөн төмөр замын маршрутын цэг, болон бусад шийдвэрийг гаргасан байдаг. Энэ нь Амьтны тухай хуульд заасан тухайн зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд ороогүй, түүнчлэн хоорондоо зөрчилтэй байсан учир түүнийг мэргэжлийн байгууллага болон холбогдох яам нь хэрэгжүүлэлгүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль буюу тухайлсан хуулийн зохицуулалтыг баримтлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна. Ингэж Засгийн газрын хуралдаанаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлээгүй нь тухайн нэн ховор амьтныг хамгаалах Засгийн газрын үүргийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна гэж үзэж байна.

Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд нэн ховор амьтны тархац нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэх агуулга бүхий зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

Хууль:	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Хугацаа:	
Гүйцэтгэсэн:	
Хэрэглэсэн арга:	Баримт бичиг судлах; Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх; Харьцуулалт хийх /synopse/; Ярилцлагын арга.

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Үүний үндсэн дээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн судалгааны объекттой хамаарал бүхий зохицуулалтыг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг хуульд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг судлах;
- Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган холбогдох санал боловсруулж Захиалагч талд шилжүүлэх.

Харьцуулан судалсан эрх зүйн актууд:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, бусад хуулиудыг уялдуулах ажлын хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай зэрэг холбогдох хууль тогтоомж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох яам агентлагаас баталж гаргасан эрх зүйн актуудыг судаллаа.

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зохицуулалтын дотоод давхардал, зөрчил, хийдлийг судлах,
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох зохицуулалтыг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг судлах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай холбогдон гарсан Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал зэрэг нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нийцэж гарсан эсэхийг судлах.

II ХЭСЭГ. ДҮГНЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шугаман дэд бүтэцтэй холбоотой төслийг хэрэгжүүлэхэд хийгдэх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, төсөл хэрэгжүүлэгчийн эрх үүрэг, менежментийн төлөвлөгөөнд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтын давхардал, зөрчил, хийдлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу шалгаж тогтоолоо.

1. Зөрчил

4

7.2.13	тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх	4
--------	--	---

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тухай хуулийн зохицуулалтын давхардлыг ХЗДХЯ-аас гаргасан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу тогтоолоо.

ЗӨРЧИЛ:

7.3.13. тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

д/д	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	Төмөр замын тээврийн тухай хууль 2007.07.05
1	7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ 7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.	16 дугаар зүйл. Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 16.3. Суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа энэ хуулийн 16.2-т зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ: 16.3.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
<p>Дүгнэлт: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт нөлөөллийн үнэлгээг хийх үндэслэлүүдийг тусгасан ба үүнд дэд бүтцийн хөгжлийн төслийг орхигдуулан тусгасан байна. Гэтэл Төмөр замын тээврийн тухай хуулийн 16.3.1 дэх хэсэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байвал зохино гэж зөрүүтэй зохицуулалтууд тусгасан байна.</p> <p>Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг дэд бүтцийн төсөл гэж нэмэх</p>		

Д/д	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	Эрчим хүчний тухай хууль 2001.02.01
2	7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ 7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.	20 дугаар зүйл. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл 20.3. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсний үндсэн дээр олгоно.;
<p>Дүгнэлт: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт нөлөөллийн үнэлгээг хийх үндэслэлүүдийг тусгасан ба үүнд дэд бүтцийн хөгжлийн төслийг орхигдуулан тусгасан байна. Гэтэл Эрчим хүчний тухай хуулийн 20.3 дахь хэсэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно хэмээн зөрүүтэй зохицуулалтууд тусгасан байна.</p> <p>Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дахь хэсэг дэд бүтцийн төсөл гэж нэмэх</p>		

Д/д	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/	
3.	Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй	
<p>Дүгнэлт: Төсөл хэрэгжүүлэгчээс төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дагаж мөрдөх стандартын санал болгодог бөгөөд үүнийг төсөл хэрэгжүүлэгчээс заавал удирдлага болгон дагаж мөрдөж байх, төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийх талаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан төсөл хэрэгжүүлэгчийн үүрэгт зааж өгөөгүй байдаг.</p> <p>Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг заавал хэрэгжүүлэх үүрэгтэй байх, мөн төслийг хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн байхаар нэмж тусгах.</p>		

Д/д	Байгаль орчинд нөлөөллийн үнэлгээний ЖУРАМ Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоол	
4.	5.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бүрэн тусгахаас гадна дараах зүйлийг тусгана:	
<p>Дүгнэлт: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмаар төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бүрэн тусгах гэж ерөнхий байдлаар заасан нь тухайн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд стандарт, техникийн зохицуулалтыг тусгах нь сайн дурын үндсэн дээр хийгдэх ажил болохоор байна.</p> <p>Санал: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.1-д байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал тусгах ёстой арга хэмжээнд төслийг хэрэгжүүлэхэд заавал дагаж мөрдөх ёстой стандарт, техникийн зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.</p>		

Дүгнэлт.

Зөрчлийн талаар:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт нөлөөллийн үнэлгээг хийх үндэслэлүүдийг тусгасан ба үүнд дэд бүтцийн хөгжлийн төслийг орхигдуулан тусгасан байна. Гэтэл Төмөр замын тээврийн тухай хуулийн 16.3.1 дэх хэсэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байвал зохино гэж зөрүүтэй зохицуулалтууд тусгасан байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг дэд бүтцийн төсөл гэж нэмэх
2. Төсөл хэрэгжүүлэгчээс төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дагаж мөрдөх стандартын санал болгодог бөгөөд үүнийг төсөл хэрэгжүүлэгчээс заавал удирдлага болгон дагаж мөрдөж байх талаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан төсөл хэрэгжүүлэгчийн үүрэгт зааж өгөөгүй байдаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар нэмж тусгах.
3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмаар төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бүрэн тусгах гэж ерөнхий байдлаар заасан нь тухайн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд стандарт, техникийн зохицуулалтыг тусгах нь сайн дурын үндсэн дээр хийгдэх ажил болохоор байна. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.1-д байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал тусгах ёстой арга хэмжээнд төслийг хэрэгжүүлэхэд заавал дагаж мөрдөх ёстой стандарт, техникийн зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ЗӨРЧИЛ, ХИЙДЛИЙГ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

Ажлыг дараах үндсэн үе шатаар хийж гүйцэтгэсэн болно:

- Эрчим хүчний тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Эрчим хүчний тухай хуулийг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг хуульд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох, системчлэх
- Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган санал боловсруулж захиалагч талд хүргүүлэх.

Энэхүү ажилд дараах судалгааны аргыг хэрэглэсэн болно:

- Баримт бичиг судлах;
- Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
- Харьцуулалт хийх;
- Бичвэр харьцуулах арга;
- Ярилцлагын арга.

Хуулийн бүтэц, зохицуулж буй харилцаа

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрчим хүчний тухай хууль нь 6 бүлэг, 38 зүйлтэй, 2001.11.30-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа бөгөөд нийт 14 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2001 оны 11 сарын 30
- 2002 оны 07 сарын 04
- 2007 оны 01 сарын 11
- 2008 оны 12 сарын 19
- 2009 оны 07 сарын 16
- 2011 оны 12 сарын 09
- 2012 оны 08 сарын 17
- 2015 оны 06 сарын 19
- 2015 оны 12 сарын 04
- 2017 оны 01 сарын 26
- 2022 оны 04 сарын 22
- 2022 оны 11 сарын 11
- 2022 оны 12 сарын 09
- 2023 оны 01 сарын 06–нд тус, тус өөрчлөлт орсон байна.

Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

Хууль: Эрчим хүчний тухай хууль
 Хугацаа:
 Гүйцэтгэсэн:
 Хэрэглэсэн арга: Баримт бичиг судлах;
 Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
 Харьцуулалт хийх /synopse/;
 Ярилцлагын арга.

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

- Эрчим хүчний тухай хуультай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Үүний үндсэн дээр Эрчим хүчний тухай хуулийг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг хуульд давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг судлах;
- Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган холбогдох санал боловсруулж Захиалагч талд шилжүүлэх

Харьцуулан судалсан эрх зүйн актууд:

Монгол Улсын шугаман дэд бүтцийн эрх зүйн орчныг үнэлж, зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн хамгаалалтыг хангах зөвлөмжийг боловсруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох, бусад хууль, эрх зүйн актуудтай уялдуулах ажлын хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох яам агентлагаас баталж гаргасан эрх зүйн акт болон стандартуудыг судаллаа.

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

1. Эрчим хүчний тухай хуулийн дотоод давхардал, зөрчил, хийдлийг судлах,
2. Эрчим хүчний тухай хуулийг бусад хуультай харьцуулж давхардал, зөрчил, хийдлийг судлах,
3. Эрчим хүчний тухай хуультай холбогдон гарсан Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, болон стандартууд нь тус хуульд нийцэж гарсан эсэхийг судлах

II ХЭСЭГ. ДҮГНЭЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шугаман дэд бүтэцтэй холбоотой төслийг хэрэгжүүлэхэд хийгдэх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, төсөл хэрэгжүүлэгчийн эрх үүрэг, менежментийн төлөвлөгөөнд тавигдах шаардлагатай холбоотой зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтын давхардал, зөрчил, хийдлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу шалгаж тогтоолоо.

1. Давхардал 1

7.1.3	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх	1
-------	--	---

Зөрчил 1

7.2.1.	Тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	1
--------	--	---

3. Хийдэл 2

7.3.3	тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томьёолсон эсэхийг тодорхойлох	2
-------	---	---

Эрчим хүчний тухай хуулийн зохицуулалтын давхардлыг ХЗДХЯ-аас гаргасан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу тогтоолоо.

ДАВХАРДАЛ

7.0.3. төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх

д/д	Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/	Зөвшөөрлийн тухай хууль /2022.06.17/
1.	6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.6. тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах;	14. Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно: 14. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
Дүгнэлт: Агуулга, бичвэрийн хувьд давхардуулан хуульчилсан байна.		
Санал: 1. Зөвшөөрлийн тухай хуульд Эрчим хүчний тухай хуулийн 6.1.6 дахь заалтыг эшлэх		

ЗӨРЧИЛ

7.2.1. тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх

д/д	Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/	Зөвшөөрлийн тухай хууль /2022.05.01/
1.	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1. Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

Дүгнэлт: Эрчим хүчний тухай хуулийн зөвшөөрөл олгох бүлэгт үндэслэж Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчилсан. Зөвшөөрлийн тухай хуулийн зорилтод хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад ... гэж оруулсан бол Эрчим хүчний тухай хуулийн зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох талаар дурдагдаагүй буюу энэ төрлийн үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, байгаль орчинд ээлтэй байх талаар огт тусгагдаагүй байна.

Санал:

1. Эрчим хүчний тухай хуулийн зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох гэж нэмэх

ХИЙДЭЛ

7.3.3. тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох

Д/Д	Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/	<i>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт</i> Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилал	
1.	21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах 21.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21, 14.22 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад стандартаар тогтоосон үйл ажиллагааны төрөл, суурь үзүүлэлтийг баримтална.	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5. Дэд бүтцийн хөгжлийн төсөл - 1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар - 1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам - орон нутгийн чанартай зам, холбоо

Дүгнэлт: Эрчим хүчний тухай хуульд “тусгай зөвшөөрөл авахдаа стандартаар тогтоосон үйл ажиллагааны төрөл, суурь үзүүлэлтийг баримтална” гэж ерөнхий тусгасан ба тус стандарт, суурь үзүүлэлтэд нийцүүлэхийн тулд аль эх сурвалжаас харах нь тодорхойгүй, тус зохицуулалт нь тасралтгүй үргэлжлэх боломжгүй тусгагдсан байна. Тус хуулийн нэр томъёо хэсэгт мөн тусгаагүй байна.

Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт хэсэгт дэд бүтцийн хөгжлийн төсөл ангилалд Эрчим хүчний тухай хуулийн 14.2, 14.5-д заагдсан үйл ажиллагаа эрхлэхэд зайлшгүй тухайн төсөл эхлүүлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийсэн байх тухай зохицуулалт тусгасан боловч Эрчим хүчний тухай хуулийн 21.1 дэх хэсгээс үзвэл тус үнэлгээг хийлгэсэн байх шаардлагыг тусгаагүй буюу тус хуулиуд нь уялдаа холбоогүй хуульчлагдсан байна.

Санал:

1. Эрчим хүчний тухай хуулийн 21.1 дэх хэсэгт бүрдүүлэх баримт бичгийн төрөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэж тусгах,
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дугаар зүйлд тус хуулийн хавсралтаар тусгагдсан төслийн ангиллуудыг иш татаж тусгах.

Д/д	Эрчим хүчний тухай хууль /2001.02.01/	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/
2.	<p>21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах</p> <p>21.2. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.23, 14.24, 14.25, 14.26, 14.27, 14.28, 14.29, 14.30, 14.31, 14.32, 14.33, 14.34 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:</p> <p>21.2.1. техник, эдийн засгийн үндэслэл;</p> <p>21.2.2. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа;</p> <p>21.2.3. үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;</p> <p>21.2.4. үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;</p> <p>21.2.5. үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;</p> <p>21.2.6. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;</p> <p>21.2.7. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;</p> <p>21.2.8. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавх;</p> <p>21.2.9. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;</p> <p>21.2.10. мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага.</p>	<p>7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ</p> <p>7.2. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.</p>
<p>Дүгнэлт: Эрчим хүчний тухай хуулийн 21.2.6 дугаар зүйл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх гэж тусгасан боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т дэд бүтцийн хөгжлийн төслийг орхигдуулан хуульчилсан ба тус хуулийн хавсралтад дэд бүтцийн хөгжлийн төсөл гэх нэршлийг оруулсан байгаа нь тус зохицуулалт нь ойлгомжгүй, тасралтгүй үргэлжлэх боломжгүй, тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учрахаар хуульчилсан байна.</p> <p>Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2-д дэд бүтцийн хөгжлийн төсөл гэж, мөн төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийх агуулгыг нэмэх.</p>		

Дүгнэлт.

Давхардлын талаар

1. Агуулга, бичвэрийн хувьд давхардуулан хуульчилсан байна. Зөвшөөрлийн тухай хуульд Эрчим хүчний тухай хуулийн 6.1.6 дахь заалтыг эшлэх.
2. Эрчим хүчний тухай хуулийн зөвшөөрөл олгох бүлэгт үндэслэж Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчилсан. Зөвшөөрлийн тухай хуулийн зорилтод хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад гэж оруулсан бол Эрчим хүчний тухай хуулийн зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох талаар дурдагдаагүй буюу энэ төрлийн үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, байгаль орчинд ээлтэй байх талаар огт тусгагдаагүй байна. Эрчим хүчний тухай хуулийн

зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох гэж нэмэх.

Зөрчлийн талаар.

Эрчим хүчний тухай хуулийн зөвшөөрөл олгох бүлэгт үндэслэж Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчилсан. Зөвшөөрлийн тухай хуулийн зорилтод хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад гэж оруулсан бол Эрчим хүчний тухай хуулийн зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох талаар дурдагдаагүй буюу энэ төрлийн үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, байгаль орчинд ээлтэй байх талаар огт тусгагдаагүй байна.

Эрчим хүчний тухай хуулийн зорилтод байгаль орчин, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болохуйц зарим төрлийн үйл ажиллагаанд хязгаартай, хяналттай зөвшөөрөл олгох гэж нэмэх

Хийдлийн талаар.

1. Эрчим хүчний тухай хуульд тусгай зөвшөөрөл авахдаа стандартаар тогтоосон үйл ажиллагааны төрөл, суурь үзүүлэлтийг баримтална гэж ерөнхий тусгасан ба тус стандарт, суурь үзүүлэлтэд нийцүүлэхийн тулд аль эх сурвалжаас харах нь тодорхойгүй, тус зохицуулалт нь тасралтгүй үргэлжлэх боломжгүй тусгагдсан байна. Тус хуулийн нэр томъёо хэсэгт мөн тусгаагүй байна.

Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт хэсэгт дэд бүтцийн хөгжлийн төсөл ангилалд Эрчим хүчний тухай хуулийн 14.2, 14.5 – д заагдсан үйл ажиллагаа эрхлэхэд зайлшгүй тухайн төсөл эхлүүлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийсэн байх тухай зохицуулалт тусгасан боловч Эрчим хүчний тухай хуулийн 21.1 дэх хэсгээс үзвэл тус үнэлгээг хийлгэсэн байх шаардлагыг тусгаагүй буюу тус хуулиуд нь уялдаа холбоогүй хуульчлагдсан байна.

Эрчим хүчний тухай хуулийн 21.1 дэх хэсэгт бүрдүүлэх баримт бичгийн төрөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэж тусгах, Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2 дугаар зүйлд тус хуулийн хавсралтаар тусгагдсан төслийн ангиллуудыг иш татаж тусгах.

ЗЭРЛЭГ АН АМЬТАНД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЭЦ БАРЬЖ БАЙГУУЛАХТАЙ ШУУД ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТУУДЫН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

I ХЭСЭГ. ТАНИЛЦУУЛГА

Хууль: Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахтай шууд холбоотой Монгол Улсын стандартууд

Хугацаа:

Гүйцэтгэсэн:

Хэрэглэсэн арга: Баримт бичиг судлах;
Задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх;
Харьцуулалт хийх /synopse/;
Ярилцлагын арга.

Судалгааны хамрах хүрээ, хязгаар:

- Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахтай шууд холбоотой Монгол Улсын стандартуудтай шууд холбоотой хууль, эрх зүйн бусад актыг нэгтгэн цуглуулах, түүнд ангилал хийх;
- Үүний үндсэн дээр Зэрлэг ан амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулахтай шууд холбоотой Монгол Улсын стандартуудыг цуглуулан нэгтгэсэн хууль эрх зүйн акттай харьцуулж уг стандартын давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг судлах;
- Илэрсэн зөрчил, давхардал, хийдлийг хуулийн зүйл заалт тус бүрээр гарган холбогдох санал боловсруулж Захиалагч талд шилжүүлэх.

Харьцуулан судалсан эрх зүйн актууд:

Монгол Улсын шугаман дэд бүтцийн эрх зүйн орчныг үнэлж, зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийн хамгаалалтыг хангах зөвлөмжийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох стандартуудын давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох, бусад хууль, эрх зүйн актуудтай уялдуулах ажлын хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох яам агентлагаас баталж гаргасан эрх зүйн акт болон стандартуудыг судаллаа.

Хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг илрүүлэх зорилгоор эрх зүйн актыг шалгах дараалал:

1. “0.4 кВ-аас 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавих шаардлага: Стандарт: MNS 6518:2015”-ын давхардал, зөрчил, хийдлийг судлах, “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц Стандарт: MNS 6515:2015”-ын давхардал, зөрчил, хийдлийг судлах

ДҮГНЭЛТ

Холбогдох стандартуудын давхардал, зөрчил, хийдлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурыг төсөөтэй хэрэглэн шалгаж тогтоолоо.

1. Зөрчил

5

7.2.5.	хуульд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа эсэх	5
--------	---	---

3. Хийдэл

2

7.3.3	тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томьёолсон эсэхийг тодорхойлох	1
7.3.8.	хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх	1

Эрчим хүчний тухай хуулийн зохицуулалтын давхардлыг ХЗДХЯ-аас гаргасан “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-д заасан шалгуурын дагуу тогтоолоо.

1. Стандарт: 0.4 кВ- аас 22 кВ- ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавих шаардлага: MNS 6518:2015

Энэхүү стандартыг улсын хэмжээнд эрчим хүчний зураг төсөл, ашиглалт, засвар угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөнө.

2. “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц Стандарт: MNS 6515:2015”

Энэхүү стандарт нь тал хээр, говийн бүс нутагт авто зам, төмөр замын дагуу зэрлэг амьтдад зориулсан гарцын төлөвлөлт, түүний хийц, ашиглалт, засвар арчилгаа, хяналтын ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

ЗӨРЧИЛ

7.2.5. хуульд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа эсэх

д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14		
1.	1. Хамрах хүрээ Энэхүү стандарт нь тал хээр, говийн бүсэд тархсан хулан адуу, хар сүүлтий, цагаан зээр, аргаль хонь, янгир ямаа, монгол бөхөн зэрэг зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх, барьж байгуулах, ашиглахад хамаарна.	2.1. Амьтан Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн	2.2. Зэрлэг амьтан Нэг нутгаас (амьдрах орчин эсвэл газраас) нөгөөд шилжин нүүх, тодорхой, үечлэлтэй (хоног, улирал гэх мэт) шилжилт хөдөлгөөнд оролцож буй бодгаль, эсвэл бүлэг туургатан амьтдыг
<p>Дүгнэлт: Дээрх стандартын хамрах хүрээ хэсэгт зөвхөн зэрлэг амьтдад хамаарах байдлаар тодорхойлсон байна. Цаашлаад нэр томьёо хэсэгт амьтан, зэрлэг амьтан гэж дахин тус тусад нь тодорхойлсон байна.</p> <p>Амьтны тухай хуулийн нэр томьёо хэсэгт “Зэрлэг амьтан” гэх нэршил тусгагдаагүй болно.</p> <p>Санал: MNS 6515:2015 стандартын нэр томьёо хэсгийг Амьтны тухай хуульд нийцүүлэн хамрах хүрээг мөн тодорхой тусгах шаардлагатай.</p>			
д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14		Авто замын тухай хууль 2017.05.11
2.	4.5. Авто зам Авто тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж сайжруулсан болон замын хөдөлгөөнд нээлттэй зурвас газрыг	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.1. “авто зам” гэж тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж, сайжруулсан болон ердийн хөрсөн замыг;	
<p>Дүгнэлт: Дээрх стандартын нэр томьёо хэсэгт тодорхойлсон авто зам гэх тодорхойлолт нь Авто тээврийн тухай хуулийн нэр томьёо хэсэгт тусгасан авто зам гэх нэршилтэй зөрүүтэй тусгагдсан байна.</p> <p>Санал: MNS 6515:2015 стандартын нэр томьёо хэсгийг Авто замын тухай хуульд нийцүүлэн нэр томьёог нэг утгаар тодорхойлж, тусгах шаардлагатай.</p>			
д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14		Авто замын тухай хууль 2017.05.11
3.	4.8. Замын байгууламж Модон ба төмөр, төмөр бетон, чулуун бусад гүүр, тавилан, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжийг	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.11. “замын байгууламж” гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг;	

Дүгнэлт: “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон замын байгууламж гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна.
Санал: Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.

д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14	Авто замын тухай хууль 2017.05.11
4.	4.9. Авто замын зурвас газар Авто зам, замын байгууламж байрлаж байгаа болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий газрыг,	4дүгээрзүйл.Хуулийннэртөмьёонытодорхойлолт 4.1.8.“авто замын зурвас газар” гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалтаар энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон газрыг;

Дүгнэлт: “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон Авто замын зурвас газар гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна.
Санал: Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.

д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14	Авто замын тухай хууль 2017.05.11
5.	4.10. Хяналт тавих зурвас газар Авто замын зурвас газар болон жолооч нарын үзэгдэх орчин, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх газрыг,	4дүгээрзүйл.Хуулийннэртөмьёонытодорхойлолт 4.1.29. “хяналт тавих зурвас газар” гэж авто замын зурвас газрын хязгаараас үл хамааран зорчигчийн үзэгдэх орчныг хязгаарлаж байгаа болон авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай газрыг;

Дүгнэлт: “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон Хяналт тавих зурвас газар гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна.
Санал: Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.

ХИЙДЭЛ

7.3.3. тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох

д/д	0.4 кВ - аас 22 кВ - ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавих шаардлага: Стандарт: MNS 6518:2015 2016.02.15	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай 2017.12.21	
1.	<p>1. Хамрах хүрээ Энэхүү стандартыг улсын хэмжээнд эрчим хүчний зураг төсөл, ашиглалт, засвар угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөнө.</p> <p>3.1.2. Агаарын шугам барихад дор дурдсан шаардлагыг хангасан байна.</p> <p>Ү. Шуувуудын аюулгүй байдал, цахилгааны аюулгүйн шаардлагын мөрдөлт</p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.2. “стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг; Тайлбар: Энэ зүйлийн 4.1.2-т заасан “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж хүчин төгөлдөр стандартаас хэрэглэхэд тохирох стандартыг сонгохыг ойлгоно.</p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.3. “техникийн зохицуулалт” гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;</p>
<p>Дүгнэлт: Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд зааснаар “Стандарт” нь заавал дагаж мөрдөх ёстой бус сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан ба заавал дагаж мөрдөх ёстой баримт бичиг нь “Техникийн зохицуулалт” байхаар хуульчилсан байна. Дээрхээс үзвэл MNS 6518:2015 стандартыг аж ахуйн нэгж байгууллагууд заавал дагаж мөрдөх бус сонгох хэрэглэх баримт бичгийн хүрээнд мөрдөж байгаа учраас хэрэгжилт нь дутмаг байгааг дээрхээс дүгнэж болохоор байна.</p> <p>Санал: MNS 6518:2015 стандартыг “Техникийн зохицуулалт” болгон батлуулах буюу заавал дагаж мөрдөх баримт бичиг болгон батлуулах</p>			

7.3.8. хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх

д/д	“Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015” 2015.09.14	Төмөр замын тухай хууль 2007.07.05	Авто замын тухай хууль 2017.05.11
2	<p>4.4. Нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц Хүний үйл ажиллагаа, дэд бүтцийн шугаман байгууламжийн улмаас үүссэн саад бэрхшээлийг зэрлэг амьтад нүүдэллэх явцад аюулгүй даван туулахад зориулсан төмөр зам болон авто замын байгууламж болон суурь бүтцийг,</p>	<p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо Тусгагдаагүй.</p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт Тусгагдаагүй.</p>
<p>Дүгнэлт: “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д “Нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц” гэх нэр томъёог тусгасан ба холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томъёог тусгаагүй байна.</p> <p>Санал: Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томъёог тодорхойлох шаардлагатай.</p>			

Дүгнэлт

Зөрчлийн талаар.

1. Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарцын стандартын хамрах хүрээ хэсэгт зөвхөн зэрлэг амьтдад хамаарах байдлаар тодорхойлсон байна. Цаашлаад нэр томьёо хэсэгт амьтан, зэрлэг амьтан гэж дахин тус тусад нь тодорхойлсон байна.
Амьтны тухай хуулийн нэр томьёо хэсэгт “Зэрлэг амьтан” гэх нэршил тусгагдаагүй болно. MNS 6515:2015 стандартын нэр томьёо хэсгийг Амьтны тухай хуульд нийцүүлэн хамрах хүрээг мөн тодорхой тусгах шаардлагатай.
2. Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарцын стандартын нэр томьёо хэсэгт тодорхойлсон авто зам гэх тодорхойлолт нь Авто тээврийн тухай хуулийн нэр томьёо хэсэгт тусгасан авто зам гэх нэршилтэй зөрүүтэй тусгагдсан байна. MNS 6515:2015 стандартын нэр томьёо хэсгийг Авто замын тухай хуульд нийцүүлэн нэр томьёог нэг утгаар тодорхойлж, тусгах шаардлагатай.
3. “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон замын байгууламж гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна. Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.
4. “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон **Авто замын зурвас газар** гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна. Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.
5. “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д тодорхойлсон **Хяналт тавих зурвас газар** гэх нэр томьёог Авто замын тухай хуулийн нэр томьёо хэсэгт өөрөөр тодорхойлсон байна. Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог ижил утгаар тусгах шаардлагатай.

Хийдлийн талаар.

1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд зааснаар “Стандарт” нь заавал дагаж мөрдөх ёстой бус сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан ба заавал дагаж мөрдөх ёстой баримт бичиг нь “Техникийн зохицуулалт” байхаар хуульчилсан байна. Дээрхээс үзвэл MNS 6518:2015 стандартыг аж ахуйн нэгж байгууллагууд заавал дагаж мөрдөх бус сонгох хэрэглэх баримт бичгийн хүрээнд мөрдөж байгаа учраас хэрэгжилт нь дутмаг байгааг дээрхээс дүгнэж болохоор байна. MNS 6518:2015 стандартыг “Техникийн зохицуулалт” болгон батлуулах буюу заавал дагаж мөрдөх баримт бичиг болгон батлуулах,
2. “Тал хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан” Стандарт: MNS 6515:2015”-д “Нүүдлийн тууртан амьтдад зориулсан гарц” гэх нэр томьёог тусгасан ба холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог тусгаагүй байна. Холбогдох хууль тогтоомжуудад дээрх нэр томьёог тодорхойлох шаардлагатай.

6.7. ШУГАМАН ДЭД БҮТЦИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТЫН ДУТАГДАЛТАЙ БАЙДЛААС ЗЭРЛЭГ АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ.

Зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулах эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн эрх зүйн актууд хэрэгжиж эхэлснээс хойш тус хууль тогтоомжийн практик хэрэгжилтэд олон бэрхшээл үүссэн төдийгүй, шаардлагатай чухал асуудлууд ч өнөөг хүртэл зохицуулалтгүй явж ирснийг энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, хяналт шалгалтын дүнгээс харагдаж байна. Мөн өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилтийн сул талыг харгалзсан дорвитой өөрчлөлт хийгдээгүйгээс эрх зүйн шинэчлэлээс хоцорч, улмаар энэ төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүйн зэрэгцээ зохицуулалтын хувьд бусад хуультай зарим талаар зөрчилдөх, уялдахгүй байдалд хүрсэн байна.

Хуулийн хэм хэмжээний давхардал тэр бүр хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхгүй бол зөрчил, хийдэл нь тухайн хууль хэрэглээд илүү их хүндрэл үүсгэдэг. Тодруулбал, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хууль хоорондын уялдаагүй, зөрчилтэй байдал нь хуулийн хэм хэмжээг зөвхөн хэрэглэх, тухайн харилцаанд таарсан аль хэм хэмжээ хэрэглэх нь тодорхойгүй, нэг талаар зөвшөөрдөг ч нөгөө талаар хориглох асуудал үүсгэдэг.

Харин хийдэл нь тухайн харилцааг бүрэн зохицуулаагүй, зохицуулалт дутуу байдлаас улбаалан тухайн харилцаанд оролцогч талуудын хооронд үүсэж байгаа асуудлыг шийдвэрлэхэд мухардалд ордог, эсхүл өөр байдлаар асуудлыг шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл харилцааны хүндрэлтэй асуудлыг зохицуулсан зохицуулалт байхгүй тул тухайн асуудлыг хууль хэрэглэж буй этгээд өөрийн субъектив хандлагаар хэрэглэн өөр өөр шийдвэр гаргах үр дагавартай байдаг.

Энэхүү судалгааны тайлангийн Шугаман дэд бүтцийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар, холбогдох зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийн судалгааны хэсгээс эрчим хүчний, зам тээврийн, байгаль орчны холбогдох хууль тогтоомж, стандартын хоорондын уялдаа, хийдэл, зөрчлийг болон практикт хэрхэн хэрэгжиж байгаа хэрэгжилтийн судалгааг хийсэн. Харин тайлангийн энэхүү хэсгээр дээрх хуулиудын хэм хэмжээний зөрчил, хийдэл, давхардал, хэрэгжилтээс зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг тайлбарлан орууллаа.

6.7.1. Эрчим хүч, зам тээвэртэй холбоотой ялангуяа шугаман дэд бүтцээс зэрлэг амьтантай шууд холбогдох байгаль орчны салбарын Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд болон Эрчим хүчний тухай, Зам тээврийн тухай хууль, холбогдох 3 төрлийн стандартыг сонгон авсан. Эдгээр хууль стандартуудаас шугаман дэд бүтцээс зэрлэг амьтанд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, хамгаалах чиглэлийн зохицуулалт, үүргийг тусгасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Амьтны тухай хууль болон холбогдох стандартыг голлон авч үзсэн.

6.7.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт нөлөөллийн үнэлгээг хийх үндэслэлүүдийг тусгасан ба үүнд дэд бүтцийн хөгжлийн төслийг орхигдуулан тусгасан байна. Гэтэл Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байвал зохино.” гэж зөрүүтэй зохицуулалт байна. Мөн Эрчим хүчний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно.” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгээс үзвэл тус үнэлгээг хийлгэсэн байх шаардлагыг тусгаагүй буюу тус хуулиуд нь уялдаа холбоогүй хуульчлагдсан байна. Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дээрх хэм хэмжээ нь Төмөр замын тээврийн тухай хуультай зөрчилддөг.

Энэхүү зөрчилтэй уялдаагүй зохицуулалтууд нь цахилгаан дамжуулах агаарын шугам, авто болон төмөр замын төслийг хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгээгүйгээс зэрлэг амьтан цаашлаад байгаль орчинд их хэмжээний сөрөг нөлөөл үзүүлэх тухайн төслийг хэрэгжүүлэхгүй байх шийдвэр гаргах боломжийг алдахаас гадна сөрөг нөлөөллийг бууруулах, жишээлбэл зэрлэг амьтанд нийцсэн стандартыг хэрэглэх боломжийг алдах болно.

Жишээ нь Говь-Алтай аймгийн Алтай сумаас Ховд аймгийн Зэрэг сум хүртэлх хатуу хучилттай босоо тэнхлэгийн авто замын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ) төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө биш төслийг хэрэгжүүлж байх шатандаа хийсэн байдаг. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг төслийг хэрэгжүүлж дуусах шатанд хийж, батлуулсан байдаг.

6.7.3. Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т нэн ховор амьтны тархац нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр заасан.

Гэвч уг зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд үүнтэй холбоотой зохицуулалт байхгүй бөгөөд харин уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.” гэж заасан нь зөрчилтэй байдаг.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан нэн ховор амьтны тархац нутагт авто замын төслийг хэрэгжүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэх тухайн нэн ховор амьтны хамгааллыг хэрэгжүүлэх нэг хэлбэр бөгөөд бодлогын хувьд нэн ховор амьтныг хамгаалах ач холбогдолтой юм. Гэвч ялангуяа авто замын төсөл дээр Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан хэм хэмжээг хэрэглэсэн тохиолдол байдаггүй. Тухайлбал, Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын төсөл нь хулан, хавтгай зэрэг нэн ховор, хар сүүлтий зэрэг ховор амьтны тархац нутгийг хамтруулан, голлон хувааж төсөл хэрэгжсэн. Харин уг төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлээгүй, зөвхөн төмөр замын маршрутын цэг, болон бусад шийдвэрийг гаргасан байдаг.

Энэ нь Амьтны тухай хуульд заасан тухайн зохицуулалт нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд ороогүй, түүнчлэн хоорондоо зөрчилтэй байсан учир түүнийг мэргэжлийн байгууллага болон холбогдох яам нь хэрэгжүүлэлгүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль буюу тухайлсан хуулийн зохицуулалтыг баримтлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна. Ингэж Засгийн газрын хуралдаанаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлээгүй нь тухайн нэн ховор амьтныг хамгаалах Засгийн газрын үүргийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна гэж үзэж болно.

6.7.4. Байгаль орчны аудитыг зөвхөн байгаль орчны нөөц, баялгийг ашиглах үйлдвэрлэл, үйлчилгээнд хийхээр Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудитыг хийх хуулийн хязгаарлалтыг энэ хуульд заасан нь хуулийн хийдэл үүсгэхээр байна. Шугаман дэд

бүтцийн төсөл нь тухайлбал, Монгол Улсын босоо тэнхлэгийн авто болон төмөр замын төсөл нь буюу хулан, хар сүүлтий, цагаан зээр, хавтгай тэмээ зэрэг нэн ховор, ховор, элбэг туурайтан амьтны тархац нутгаар дайран өнгөрдөг, тэдгээр амьтны нүүдлийн замыг хаан боогдуулснаас үүдэн үржил сэлэцэд орох нь байхгүй болсон байдаг. Иймд шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудит хийх эрх зүйн орчныг бүрдүүлж, тухайн төсөл нь хууль, дүрэм журам, байгаль орчны стандартад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийж, зөвлөмж өгдөг цаашлаад амьтанд ээлтэй стандартыг мөрдүүлэхэд хөшүүрэг болох юм.

Үүгээр шугаман дэд бүтцийг стандартын дагуу барьж байгуулдаг болохоос гадна одоо баригдсан байгаа тухайн дэд бүтцийг амьтанд ээлтэй шинэ стандартад нийцүүлэн засварлах боломжтой болох ач холбогдолтой. Үүгээр шугаман дэд бүтцийг стандартын дагуу барьж байгуулдаг болохоос гадна одоо баригдсан байгаа тухайн дэд бүтцийг амьтанд ээлтэй шинэ стандартад нийцүүлэн засварлах боломжтой болох ач холбогдолтой. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дүгээр зүйлд байгаль орчны аудитыг хийх төслийн жагсаалтыг байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 4 жил тутамд байгаль орчны бодлого шийдвэртэй уялдуулан жагсаалтыг баталдаг байх зохицуулалтыг тусгах. Үүгээр шугаман дэд бүтцийн төсөлд байгаль орчны аудитыг хийж байх зайлшгүй шаардлагыг хангаж амьтанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах юм.

6.7.5. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2-т „стандарт“ гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ гэж заасан байна.

Харин техникийн зохицуулалт нь дээрх хуулийн 5.2-т зааснаар нийтээр заавал дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Дээрхээс үзвэл хууль зүйн хүчин чадлын хувьд техникийн зохицуулалт нь заавал дагаж мөрдөх баримт бичиг бол стандарт нь заавал дагаж мөрдөх бус сонгон хэрэглэх баримт бичиг байна.

Иймд зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж байгуулах ерөнхий шаардлагууд нь дээрх стандартуудад илүү дэлгэрэнгүй, нарийн тусгагдсанаас тус стандартыг хэрэгжүүлэгч нь тэдгээрийг заавал дагаж мөрдөх нь хуулиараа үүрэг болж тусгагдаагүй учраас практикт хэрэгжилт нь дутмаг байгаагаас зэрлэг амьтанд ээлгүй, сөрөг нөлөө ихтэй шугаман дэд бүтэц баригдахад хүрч байна.

6.7.6. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл нь Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3-т “авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах” гэсэн зохицуулалтыг заасан байна.

Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1-д заасан техникийн нөхцөл, норм, норматив гэдэг нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд тодорхойлсноор техникийн зохицуулалтад хамаарах ба стандартууд нь 19.2.1-д тодорхойлсон баримт бичигт хамаарахгүй юм.

Энэ нь шинээр баригдаж буй авто зам, замын байгууламжийн барилга байгууламжуудын зураг төслийг боловсруулахдаа зураг төсөл зохиогч нь зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөний судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхгүй, дээрх

шаардлагыг орхигдуулдаг, зураг төсөлд зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байх гэж ерөнхий агуулгаар орсон нь зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хэвийн нэвтрүүлэх боломж алдагдаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх буюу ховор амьтад үрэгдүүлэх нэгэн шалтгаан болж байна.

Түүнчлэн 2018 онд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018, 2015 онд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартуудыг батлагдсанаар тухайн чиглэлээр авто зам, төмөр замын салбарт нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцыг төлөвлөх шаардлагыг тусгасан баримт бичгийг баталсан юм. Түүнээс өмнө баригдсан төмөр зам барьж байгуулахдаа нүхэн гарц, гармыг байгаль орчныг хамгаалах зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн замыг судалгаан дээр үндэслэн төлөвлөж, байгуулаагүй нь мөн адил зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулах сөрөг нөлөөллийг үзүүлсэн байна.

Мөн дээрх стандартын 9.8-д авто замын зурвас газрын дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага нүүдлийн амьтдыг хамгаалах зорилгоор хяналт тавьж нутгийн иргэдэд мэдээ, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулна гэж заасан боловч авто замын тухай хуулийн 12 дугаар зүйл аймаг, сум, дүүрэг, нийслэлийн засаг даргын эрх, үүрэг хэсэгт дээрх зохицуулалт тусгагдаагүйн улмаас мөн практикт хэрэгжилт дутмаг байна.

Дээр дурдсан голлох сөрөг нөлөөллүүд нь байгаль орчны, эрчим хүчний, зам тээврийн салбарын хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо муу байдлаас үүдэн үүсэж байгаа нь харагдаж байна. Түүнчлэн салбарын хуулиудын уялдаа холбоо муу байдлаас гадна хуулийн хэрэгжүүлэх хөшүүрэг болсон зохицуулалт дутмаг байгаа нь хуулийн хэрэгжилт муу болох үндсэн нөхцөл болж зэрлэг амьтанд сөрөг нөлөөтэй шугаман дэд бүтэц баригдахад хүрч байна.

ДОЛОО

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол орны махчин шувууд нь агаарын цахилгаанд дамжуулах 6 кВ, 10 кВ, 15 кВ 35 кВ-ын шугамын хүчдэлд цохиулан ихээхэн үхдэг. Үүнээс 15кВ-ын шугамд /4515 км/ хүчдэлд цохиулж үхэх нь хамгийн их байдаг байна.

2017 оны тооцоогоор 86 км урттай 15кВ-ын шугамыг шувуудад аюулгүй болгон засварлахад нийт 40,5 сая төгрөг шаардлагатай байсан байна. Нийт Монгол Улсын 4515 км урт 15кВ-ын шугамыг засварлахад буюу шувуудад аюулгүй болгоход 2.2 тэрбум төгрөг шаардлагатай тооцоог 2017 онд гаргасан байдаг.

Дээрх судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, зураг төсөл зохиогч, ашиглагч байгууллагууд нь цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулах болон ашиглахдаа байгаль орчин тэр дундаа шувуудад учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг орхигдуулдаг бөгөөд байгаль орчны мэргэжлийн тухайн чиглэлийн асуудлыг хариуцсан албан тушаалтан байхгүй, төсөв санхүүжилтийн дутагдалтай байдлын улмаас тус асуудал нь үүссэн байна.

Иймд Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж заасны дагуу төр хуулиар хүлээсэн хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлж, улмаар шугаман дэд бүтцийг хөгжүүлэхдээ байгаль орчин, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар бодлогын баримт бичигт огт тусгаагүй, мөн түүнийг хэрэгжүүлдэг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудад тухайн байгаль орчны чиглэл хариуцсан мэргэжилтэнгүй, мөн шугаман дэд бүтцийг барьж байгуулах, ашиглах, эзэмших үйл ажиллагааг явуулж буй байгууллагууд нь тусгайлсан чиг үүргээ буюу цахилгаан дамжуулах ажиллагааг голлон анхаарч, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийдэггүй, түүний хийгдсэн ч нөлөөллийн үнэлгээний дагуу ямар нэгэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй байдал нь төр үүргээ биелүүлж чадахгүй үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт шугаман дэд бүтцийг хөгжүүлэхдээ байгаль орчин, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх асуудлыг буруулсан байх нөхцөл байдлыг тусгасан байх ёстой. Ингэснээр тухайлбал: “Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2 дахь заалтад шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг байгаль орчинд ээлтэй, шувуудад аюулгүй болгож, төр Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн байгаль орчныг хамгаалах

үүргээ биелүүлж, техник технологид дэвшилт гарч, цахилгааны тасралт буурч, цахилгаан эрчим хүчний тасралттай холбоотой аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн хохирол буурч, эдийн засаг, нийгмийн үр өгөөж дээшлэх нөхцөл бүрдэх юм.

Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.11-д “үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх” тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг заасан байдаг боловч тус зохицуулалт нь практик, бодит нөхцөл байдал хэрэгжилт хангалтгүй байгаа тул төрийн захиргааны төв байгууллагад салбарын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнийг ажиллуулж, улмаар салбарын байгууллагуудын байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хянах, улсын хэмжээнд төрийн өмчийн агаарын цахилгаан дамжуулах шугамуудын шувуу хамгаалах тоноглолын нөхцөл байдлыг тодорхойлж, шугаман дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй болгох нь зүйтэй. Энэ нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ерөнхий чиг үүргийн яам байх ёстойг харуулж байна. Өөрөөр хэлбэл, ерөнхий буюу чиг үүргийн яамд нь бусад чиглэлийн яамнуудын бодлогын баримт бичиг, холбогдох хууль эрх зүйн орчинд тусгуулах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байгууллагын бүтэц тухайн чиглэлээр хамаарал бүхий нэгж, ажилтан ажиллуулдаг. Тухайлбал бүх яамнуудад санхүү, хууль зүйн, гадаад харилцааны нэгж бүтэцтэй байдагтай адил юм.

Иймд байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагыг үндсэн буюу ерөнхий чиг үүргийн яам болгож улмаар салбар яамнуудын бүтэцэд байгаль орчны асуудал хариуцсан ажилтан, албан хаагчтай болгож, шугаман дэд бүтэцтэй холбоотой гарч буй бодлогын баримт бичиг, хууль, дүрэм, журам, стандартад байгаль орчныг хамгаалах, шувуудад ээлтэй байх нөхцөлийг бүрдүүлбэл байгаль орчин, эх дэлхийгээ хамгаалах үндсэн үүргээ биелүүлэх боломжтой нөхцөл байдал үүснэ.

Харин төрийн байгууллагын чадавх “дунд” зэрэг гэж үнэлэгдсэн бөгөөд хэдийгээр тусгайлсан чиг үүрэг, орон тоо байхгүй байгаа боловч “хамтын ажиллагаа”-ны хүрээнд дээрх “сул” талыг нөхөн ажиллаж байгаа нь сайн туршлага болж байна. Тухайлбал, шугаман дэд бүтцийн салбарт зэрлэг амьтанд ээлтэй дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай 3 стандартыг хамтын ажиллагааны хүрээнд боловсруулан батлуулан мөрдүүлэх, стандартыг хэрэгжүүлэх тал дээр төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж, шаардлагатай судалгаа, тайлангаар хангагдаж байна. Эрчим хүчний болон зам, тээврийн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, тайланд дурдсан бодлогыг хэрэгжүүлэгч захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой байгууллага нь байгаль орчны хууль тогтоомж тэр дундаа Амьтны тухай хуульд заасан амьтныг хамгаалах хэлбэр түүний зохицуулалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг, хариуцлага, эрчим хүч, зам, тээврийн төслөөс зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ зэргийг тэр бүр мэдэхгүй байна. Энэ тухайн албан хаагч нар нь эрчим хүч, зам, тээврийн төслийг хэрэгжүүлэхдээ сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд анхаарч ажиллах эрх зүйн орчныг танилцуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлд соён гэгээрүүлэх ажлыг тусгайлан хөтөлбөртэйгөөр хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн эрчим хүчний салбарт мөрдөгдөж буй “0.4 кВ-22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага” стандартад шувуу хамгаалах талаар хавсралт хэсэг тусгагдсан байдаг тул зураг төсөл зохиогчид төдийлөн анхаардаггүй тул тусгайлсан

0-22 кВ-ын хүртэлх хүчдэлийн түвшинтэй цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлага стандартын шинээр боловсруулж, зураг төсөл зохиох мөрдөх шаардлагатай. Нөгөө талаас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар стандарт нь нэгдүгээрт заавал дагаж мөрдөх бус сонгон хэрэглэх, хоёрдугаарт стандарт нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалт болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг бол техникийн зохицуулалт нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой нийтээр дагаж мөрдөх шинжтэй байдаг. Иймд зэрлэг амьтны аюулгүй байдлыг хангах хүрээнд хэрэглэж байгаа дээрх стандартыг техникийн зохицуулалт болгон боловсруулж, Засгийн газраар батлуулан нийтээр дагаж мөрдөх нь зүйтэй болно.

Мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаас уг харилцаанд оролцогч нар нь хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дүрэм журам, стандартыг мөрдөж, ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал, холбогдох стандарт байдаг, хуулиар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхээр үүрэг болгосон боловч цахилгаан дамжуулах агаарын шугамын болон авто болон төмөр замын зураг төсөлд стандартаар тогтоосон шаардлагыг тэр бүр тусгаж өгдөггүй (2015-2023 оны хооронд нийт 1603 авто замын төсөлд хянан магадалгаа хийхэд 14 төсөлд зэрлэг амьтанд зориулсан гарц, гарам төлөвлөсөн), хянан магадлах эрх бүхий этгээдийн зүгээс үүнийг анхаарч үздэггүй, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг цахилгаан дамжуулах агаарын шугамын 99 хувьд нь хийдэггүй, авто болон төмөр замын төслийг хэрэгжүүлж эхэлсний дараа нөхөж, хийх зэрэг дутагдалтай асуудал байна.

Цахилгаан дамжуулах агаарын шугам, авто болон төмөр замын барилга байгууламжаас зэрлэг амьтанд учрах сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүй орчин, стандарт 2010 оноос хойш батлагдан хэрэгжиж байгаа боловч шинээр бий болгох дэд бүтцээс гадна эрх зүйн орчин бүрдэхээс, стандартууд батлагдахаас өмнө байгуулагдсан дэд бүтцийг стандартад нийцүүлэх шаардлага байгаа зайлшгүй юм. Хэдийгээр авто болон төмөр замаас зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 2 чухал стандартыг батлан мөрдөж байгаа боловч төмөр замаас зэрлэг амьтанд ихээхэн хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж тэдгээрийн амьдрах орчны хуваагдлыг бий болгож, нүүдлийн зам, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж байгаа төмөр замын торон хашааны стандарт байхгүй хэвээр байна.

Эрх зүйн орчны хувьд 2010 оноос хойш шугаман дэд бүтцээс зэрлэг амьтанд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн орчин бүрдэж, холбогдох стандартууд батлагдсан хэдийн боловч хууль хоорондын уялдаагүй байдал байсаар байгаа нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, зэрлэг амьтныг хамгаалахад хүндрэл учирч байна. Тухайлбал, Амьтны тухай хуульд нэн ховор амьтны тархац нутагт төмөр зам болон авто зам барьж байгуулахад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газраас уг төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхээр заасан боловч Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зөвхөн шинжээчийн дүгнэлт, орон нутгийн саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэхээр заасан байдаг.

Иймд зэрлэг амьтанд ээлтэй шугаман дэд бүтцийг бүрдүүлэхэд тайланд дурдсан хууль эрх зүйн орчны уялдаагүй байдал, төрийн байгууллагын чадавхын сул байдал, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн тааруу байдал зэрэг асуудлууд нь зэрлэг амьтанд сөрөг нөлөө

үзүүлж байна гэж үзлээ. Энэхүү сөрөг нөлөө үзүүлж байгаа талуудыг дараах зөвлөмжийн хүрээнд сайжруулах боломжтой гэж үзэж байна.

1. Шинээр баригдаж буй 35 кВ хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлын явцад зураг төсөлд шувуу хамгаалах тоног төхөөрөмж тусгасан эсэх, түүний дагуу угсралтын ажлыг хийж гүйцэтгэж, хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгах талаар техник хяналтын төрийн захиргааны төв байгууллагуудын салбарын хяналтын газруудын хяналт шалгалтын механизмыг сайжруулах;
2. Цахилгаан дамжуулах агаарын шугам шувуудад аюулгүй байх талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгаль орчны мэргэжилтний орон тоог төрийн захиргааны төв, төрийн захиргааны, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд бий болгох, түүгээр дамжуулж соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, цахилгаан дамжуулах агаарын шугамын эзэмшигчийн үүргийг биелүүлэх талаар арга хэмжээг авч ажиллах;
3. Монгол Улсад ашиглагдаж буй 35 кВ хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам эзэмшигчийн үйл ажиллагаанд эрчим хүч болон байгаль орчны чиглэлийн хамтарсан хяналт шалгалтыг тогтмол хийж, шувуу хамгаалах ажлыг үр дүнтэй болгох буюу жил бүрийн Засгийн газрын тогтоолоор батлагддаг хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлэх;
4. Монгол Улсад ашиглагдаж буй 35 кВ хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамыг шувуудад ээлтэй болгох хүрээнд шувуу үргээх, шувуу тогонд цохиулахаас урьдчилан сэргийлэх төхөөрөмжтэй эсэх мониторинг, судалгааг дахин хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн засварлах төслийг хэрэгжүүлэх;
5. Эрчим хүчний салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд болон хувийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын хууль биелүүлэх, байгаль орчны нөлөөллийг бууруулах ажил хийсэн байдал харилцан адилгүй байгаа тул эрчим хүчний цахилгаан шугам сүлжээ эзэмшигчийн төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудыг хувьчлах төслийг хэрэгжүүлэх;
6. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийг магадлал хийж баталгаажуулахдаа байгаль орчин, шувуудад аюулгүй байх шаардлагыг тусгах, тусгайлсан стандартыг мөрдүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.12, 6.12.10-т инженерийн шугам сүлжээ нь байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг дагуу зураг төсөлд хамгаалах талаар тусгасан эсэх” гэж тусгаж, улсын хэмжээнд бүх салбарын зураг төсөлд магадлал хийхэд мөрдүүлэхээр тодотгох;
7. Байгаль орчны аудитыг дэд бүтцийн төсөлд хийдэг болох өөрчлөлтийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд тусгуулж, шугаман дэд бүтцийн төслийн хэрэгжилтэд Монгол Улсын стандартыг мөрдөж буй эсэхэд байгаль орчны аудит хийдэг болох төслийг хэрэгжүүлэх;
8. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт “авто зам, замын байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах”, 11.1.6-д “авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж заасны дагуу авто зам, замын байгууламжийн зураг төслийг боловсруулах явцад “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018, “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартуудын тусгуулахад анхаарч ажиллах;

9. Тусгай зориулалтын авто зам, төмөр замын зураг төслийг боловсруулах явцад “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартын хэрэгжилтийг хангуулах, зэрлэг амьтдын байршил, нүүдлийн маршрут ихээхэн өөрчлөгдсөн, шинэ газар нутгуудад тэмдэглэгдэх болсон тул байршлыг шинэчлэн тогтоох, хамгаалах төсөл хэрэгжүүлэх;
10. Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвд олгогдсон салбарын боловсон хүчнийг сургах, чадавхжуулах чиг үүрэгтэй нь уялдуулан Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн амьтныг хамгаалах хэлбэр, амьтныг хамгаалахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага, цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөллийн ерөнхий, нарийвчилсан үнэлгээ, төрөөс эрчим хүчний бодлогын баримт бичигт хийх стратегийн үнэлгээний ач холбогдол, анхаарах асуудал, зохицуулалтын талаар болон эрчим хүчний бодлого, цаашид баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын байршил зэрэгтэй уялдуулан шувуудын байршил, нүүдлийн зам, шилжилт хөдөлгөөний байршлын судалгаа мэдээллийн талаарх сургалтыг тогтмол хийх сургагч багш болон сургалтын гарын авлагыг бэлтгэн хүргэх;
11. Эрчим хүчний хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвийн алба хаагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн амьтныг хамгаалах хэлбэр, амьтныг хамгаалахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага, цахилгаан дамжуулах агаарын шугамд байгаль орчны нөлөөллийн ерөнхий, нарийвчилсан үнэлгээ, төрөөс эрчим хүчний талаарх бодлогын баримт бичигт хийх стратегийн үнэлгээний ач холбогдол, анхаарах асуудал, зохицуулалтын талаар соён гэгээрүүлэх арга хэмжээг авах;
12. Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газарт зэрлэг амьтдын амьдрах шилжилт, нүүдлийн асуудлыг хариуцах чиг үүргийг бий болгож, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллахад голлон үүрэгтэй оролцуулах, уг газрыг чадавхжуулах мэдээ мэдээллээр хангах сургалтыг хийх;
13. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зам, тээврийн хөгжлийн төв зэрэг байгууллагуудын албан хаагч нарт Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон холбогдох стандарт, зэрлэг амьтны тархац нутаг, нүүдлийн зам, авто зам болон төмөр замаас зэрлэг амьтанд үзүүлэх сөрөг нөлөө, түүнийг бууруулах арга хэмжээ зэргийг агуулсан сургалтын гарын авлагыг бэлтгэж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэх;
14. Цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, хянан магадалгааг хийхэд холбогдох стандартыг тусгах, шувуудад ээлтэй болгох зөвлөмж бүхий гарын авлагыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
15. Авто болон төмөр замын барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, хянан магадалгаа хийхэд “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018, “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартыг тусгах, байгаль орчинд ээлтэй болгоход анхаарах зөвлөмж бүхий гарын авлага бэлтгэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;

16. Зэрлэг амьтад, тэдгээрийн амьдрах орчин, нүүдлийн замд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авто зам, төмөр замын эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, гадаадын мэргэжилтнүүдийг урьж, хамтран судлах, судалгааны бааз суурийг бэхжүүлэх, олон улсад нэвтэрч байгаа дэвшилтэд шинэ техник технологи, иновацыг нэвтрүүлэх, нутагшуулах төсөл хэрэгжүүлэх;
17. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын хэлтсээс боловсруулж байгаа Монгол Улсын авто замын орон зайн мэдээллийн санг боловсронгуй болгох, байнгын баяжилт хийхдээ тухайн орон нутгийн захиргааны байгууллага, байгаль орчны мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллага зэрэг бүх талын оролцоог хангаж, авто замаас гадна төмөр зам болон бусад шугаман дэд бүтцийн мэдээллийг нэгтгэх, нүүдлийн зэрлэг амьтдын амьдрах орчин, шугаман дэд бүтэцтэй огтлолцож байгаа чухал газруудыг тодорхойлох, тухайн газруудад шугаман дэд бүтцүүдийг амьтдад ээлтэй төлөвлөх;
18. Авто замын тухай хуулиар шинээр баригдаж буй авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулахад тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтад “зураг төсөл зохиох зургийн даалгавар, хайгуул геологийн судалгааны дүгнэлт, геодезийн хэмжилт, техникийн нөхцөл, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу боловсруулсан байх”, 19.2.2 дахь заалтад “зорчигчдын эрүүл ахуй, хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль орчин, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байх”, 19.2.3 дахь заалтад “авто зам, замын байгууламжийг зэрлэг амьтдын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гарамтай байхаар тусгах” гэж тус тус заасан шаардлагын бүрэн хангасан байхаар хуульчилсныг хэрэгжүүлэх;
19. Авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц, гармыг барихад санхүүжилт их шаардагдах тул хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхой болгох, олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулж нэвтрүүлэх, авто замын сангийн санхүүжилтийн тодорхой хувийг жил бүр судалгаа шинжилгээний ажилд хуваарилж байх зэрэг арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
20. Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг “ерөнхий чиг үүргийн яам” болгож, Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яамны бүтцэд байгаль орчны чиглэлийн орон тоог бий болгох, салбарын бодлого, хууль эрх зүйд байгаль орчныг хамгаалах чиглэлийн асуудлыг тусгуулах;
21. Зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц барьж, байгуулахад голлох шаардлагуудыг дэлгэрэнгүй зохицуулсан стандартуудыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нийцүүлэн техникийн зохицуулалт болгон өөрчилж, Монгол Улсын Засгийн газраар батлуулан мөрдүүлэх төслийг хэрэгжүүлэх;
22. Авто болон төмөр замыг барьж байгуулахдаа холбогдох стандартыг мөрдөж ажиллахаас гадна дараах зүйлийг анхаарах:
 - Инженерийн нарийвчилсан тооцоо судалгааг хийхдээ гарц төлөвлөж буй орчныг урьдчилан судалж, зүйлийн амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөний холбоос (коридор) эзэмшил нутаг, байршлыг тодорхойлон, гарцын тохирох ангиллыг оновчтой төлөвлөж, экосистем, ландшафтын нэгдмэл байдлыг алдагдуулахгүй байх үндэслэлээр тогтоох;

- Тухайн орчны нөхцөл байдлыг тодорхойлсны дагуу байгалийн төрхөд зохицсон хийц бүтээц бүхий гарцыг төлөвлөх;
 - Авто зам барих төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэхдээ тухайн зүйлийн амьтан судлаач болон авто замын төлөвлөлтийн инженерийн бүрэлдэхүүнтэй багийг оролцуулах;
 - Авто замын зурвас газар дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага нүүдлийн амьтдыг хамгаалах зорилгоор хяналт тавьж нутгийн иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулна;
 - Засвар, арчлалт хийхэд хүндрэлтэй газарт гарц байгуулсан тохиолдолд камер байршуулж, аюулгүй ашиглалтын нөхцөлийг хянах, мониторинг хийх замаар хангах;
 - Гарц, гарамд урсгал засварыг тогтмол, ээлжит засварыг 5 жил тутам, их засварыг 15 жил тутам, зэрлэг амьтад чөлөөтэй нэвтрэх боломжоор хязгаарлагдсан нөхцөлд тухай бүр хийх;
 - Гарцын орчим хяналтын камерыг байршуулж, зэрлэг амьтдын ашиглалтын байдалд (зүйлийн бүрдэл, тоо, давтамж, нас, хүйсийн бүтэц, ашиглаж буй хугацаа зэрэг) мониторинг, дүгнэлтийг мэргэжлийн судлаачидтай хамтран хийж, засвар, арчлалт, үзлэг хийх хугацааг тогтоох;
 - Гарцыг замын зурвас газар, аюултай, аюулгүйн бүсийн зай хэмжээтэй уялдуулж, газрын гадаргуу, газар нутаг, хот төлөвлөлт, замын чигийг харгалзан, амьтан судлаачдын судалгааг үндэслэн зэрлэг амьтад нүүдэллэдэг хэсэгт байгуулна;
 - Авто зам болон төмөр замын зурвас газрын дагуух нутгийн захиргааны байгууллага нь нүүдлийн тууртан амьтдыг хамгаалж, хөдөлгөөнт хэсэг болох авто зам, төмөр замаар нүүдэллэх үед хяналтыг сайжруулж ажиллах, нутгийн иргэдэд аливаа амьтдыг хайрлан хамгаалах талаар мэдлэг мэдээллийг хүргэх;
 - Цахилгаан дамжуулах агаарын шугамын стандартыг шувуудад аюулгүй болгох техникийн шаардлагыг хангах (D хавсралт).
23. Аливаа дэд бүтцийн төслийг барьж байгуулахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгддэггүй, угсралтын явцад эсхүл бүтээн байгуулалт дуусах үед, зарим тохиолдолд үнэлгээ хийлгэхгүйгээр бүтээн байгуулалтууд хийгдэж байгааг олон судалгаанаас харж болохоор байна. Иймд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт дэд бүтэц гэсэн ангиллыг нэмж тусган аливаа дэд бүтцийн төсөл баригдаж эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж хэвших;
24. Авто замын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуулийн нэр томьёо хэсэгтэй “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018, “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6515:2015 стандартуудын нэр томьёог зөрүүтэй томьёолсон байгаа зөрчлийг арилгах;
25. Байгаль орчны яам, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаас эрчим хүчний, авто болон төмөр замын салбарын оролцогч байгууллагуудад шугаман дэд бүтцийг барьж байгуулахад зэрлэг амьтан ээлтэй байх талаарх соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах хийх зэрэг болно.

НАЙМ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

7.1. Бодлогын баримт бичиг

1. “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол 2020 он,
2. “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол 2020 он,
3. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” баримт бичиг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол 2010 он,
4. “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын их хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичиг.

7.2. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он,
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль 2012 он,
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012 он,
4. Амьтны тухай хууль 2012 он,
5. Эрчим хүчний тухай хууль 2001 он
6. Авто замын тухай хууль 2017 он,
7. Төмөр замын тээврийн тухай хууль 2007 он,
8. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он,
9. Зөрчлийн тухай хууль 2017 он,
10. Эрүүгийн хууль 2015 он,
11. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 он,
12. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журам” Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоол 2013 он,
13. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол,
14. “Эрчим хүчний салбарт эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм” Түнлш, эрчим хүчний сайдын 2006 оны 104 дугаар тушаал,
15. “Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм” Түлш, эрчим хүчний сайдын 2006 оны 104 дүгээр тушаал,
16. “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаал 2010 он,
17. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт 2016 он,

7.3. Стандарт, норм норматив

1. “0.4 кВ-оос 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага” MNS 6518:2021 стандарт 2021 он,
2. “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц” MNS 6515:2015 стандарт 2015 он,
3. “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага” MNS 6735:2018 стандарт 2018 он,
4. “Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын техникийн шаардлага” Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаал 2011 он,

7.4. Судалгааны тайлан

1. Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК-ийн шувуу хамгаалах ажилтай холбоотой хийж гүйцэтгэсэн ажлын тайлан судалгаа 2023 он,
2. “Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төслүүдийн байгаль орчны нөлөөлийн нарийвчилсан үнэлгээний тайлан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх” төслийн гүйцэтгэлийн тайлан Байгаль-Экологи ХХК 2022 он,
3. Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ) –ны захиалгаар хийгдсэн 220 кВ-ын Чойр-Сайншанд чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОННБУ) тайлан 2021 он,
4. “Зам, тээврийн салбараас байгаль орчин, амьтан тэдгээрийн амьдрах орчин, нүүдлийн замд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн орчин, стандарт, ном дүрмийг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээний ажилд зөвлөмж, чиглэл өгөх үүрэг бүхий” ажлын хэсгийн зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл,
5. Азийн авто замын босоо тэнхлэг АН4 чиглэлийн авто замын трассын чиглэлд зэрлэг амьтдын тархац, шилжилт хөдөлгөөнийг судлах ажлын тайлан,
6. “Кад сүрвэй” ХХК-ийн 2020 онд боловсруулсан “Сайншанд-Баруун-Урт чиглэлийн төмөр зам дагуу төлөвлөж буй зэрлэг амьтны нүхэн гарцын барилгын ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл”,
7. “Кад сүрвэй” ХХК-ийн 2020 онд боловсруулсан “Ховд аймгийн Алтай сумын Баруун босоо тэнхлэгийн авто зам дээр баригдах ан амьтдын гүүрэн гарцын барилгын ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл,
8. “Эко трейд” ХХК-ийн 2004 онд боловсруулсан “Оюу толгой-Гашуунсухайтын дэд бүтцийн зурвасын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”,
9. “ЖЭМР” ХХК-ийн 2015 онд боловсруулсан “Цагаанхад уузвараас Гашуунсухайт боомт хүртэлх авто замын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”,
10. Болд А. Тулгат Р. 2005. Ногтруу *Syrrhaptes paradoxus* (Pallas, 1973). Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. 2:3-17.,
11. Гомбобаатар С. 2006. Монгол орны төв хэсгийн идлэг шонхор (*Falco cherrug milvipes* Jordan, 1871)-ын биологи, экологи, хамгаалал. Докторын (PhD) диссертаци. Улаанбаатар.,
12. Гомбобаатар С. 2013. Монгол орны идлэг шонхор (*Falco cherrug*). МУИС. Монголын шувуу судлалын нийгэмлэг. Улаанбаатар. 246.,
13. Гомбобаатар С., Одхүү Б., Өсөхжаргал Д., Батмөнх Д., Баянмөнх Д., Соронзонболд О. 2012. Өндөр хүчдэлийн дагуух махчин шувуудад тохиромжтой боломжит хувилбарыг тогтоох суурь судалгаа. Биологийн төрөл зүйлийн судалгааны ажлын тайлан,

14. Лхагвасүрэн В. 2000. Монгол орны цагаан зээрийн тархац, тоо толгойд нөлөөлж буй хүчин зүйл, хамгаалал. Биологийн ухааны докторын (PhD) зэрэг горилсон ганц сэдэвт бүтээл. Улаанбаатар 2000 он,
15. Лхагвасүрэн Б. 2021. Монгол орны цагаан зээр (*Procapra gutturosa* Pallas, 1777). Улаанбаатар. 190.,
16. Монгол орны байгаль орчин. 2017. Монгол орны хөхтөн амьтны популяцийн нөөц, байршлын хөдлөлзүйн байдал. III боть. Монгол орны биологийн олон янз байдал. Улаанбаатар. 100-139.,
17. Нямбаяр Б., Батчулуун Д., Төрбат Д. 2016. Өвөрхангай аймагт говийн ногтруу *Syrrhaptes paradoxus* цахилгаан шугамны утас мөргөж олноор үхсэн тохиолдол. Тоодог. 2. Хууд. 34-40.,
18. Сосорбарам Ж. 1966. Цагаан зээрийн тоо толгойн байдал нь түүний ач холбогдлын хэмжигдэхүүн мөн. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. №1. 39-42.,
19. Хрусталева С.И., Х.Бадам. 1978. Мечение степных антилоп в Монголии. Труды Института общей и экспериментальной биологии. №13. 95-100.,
20. "Oyu tolgoi Roads and Wildlife Mitigation Report" by Western Transportation Institute College of Engineering Montana State University (2013),
21. Research article "Challenges in the conservation of wide-ranging nomadic" by Dejid Nandintsetseg in Journal of Applied Ecology (2019),
22. Andrew Dixon, Roller Maming, Amarkhuu Gunga, Gankhuyag Purev-ochir and Nyambayar Batbayar. 2013. The problem of raptor electrocution in Asia: case studies from Mongolia and China. Bird Conservation International. 23: 520-529.,
23. Andrew Dixon, Md Lutfor Rahman, Batbayar Galtbalt, Amarkhuu Gunga, Batkhuu Sugarsaikhan, Nyambayar Batbayar. 2017. Avian electrocution rates associated with density of active small mammal holes and power-pole mitigation: Implications for the conservation of Threatened raptors in Mongolia. Journal for Nature Conservation. Volume 36: 14-19.,
24. Andrew Dixon, MD Lutfor Rahman, Batbayar Galtbalt, Batbayar Bold, Batmunkh Davaasuren, Nyambayar Batbayar, Batkhuu Sugarsaikhan. 2019. Mitigation techniques to reduce avian electrocution rates. Wildlife Society Bulletin. Vol. 43: 476-483.,
25. Andrew Dixon, Nyambayar Batbayar, Batbayar Bold, Batmunkh Davaasuren, Tuvshinjargal Erdenechimeg, Batbayar Galtbalt, Purevsuren Tsolmonjav, Sarangerel Ichinkhorloo, Amarkhuu Gunga, Gankhuyag Purevochir, Md Lutfor Rahman. 2020. Variation in electrocution rate and demographic composition of Saker falcons electrocuted at power lines in Mongolia. Journal of Raptor Research. 54(2): 136-146.,
26. Avian power line interaction committee (APLIC). 1996. Suggested practices for raptor protection on power lines: The state of the art in 1996. Edison Electric Institute, Washington, D.C.,
27. Batbayar, N., Sukhbaatar, T. and Davaasuren, B. 2020. A report on bird collisions with medium and high-voltage power lines in Mongolia submitted to Oyu Tolgoi LLC. Wildlife Science and Conservation Center of Mongolia. Unpublished report.,
28. Benson, P.C. 1981. Large Raptor Electrocution and Power Pole Utilization: A Study in Six Western States. Ph.D. diss., Brigham Young Univ., Provo, Utah. 98pp.,
29. Bevanger K. 1999. Estimating bird mortality caused by collision and electrocution with power lines: a review of methodology. Pp. 29-56 in G.F.E. Janss and M.Ferrer, eds. Birds and power lines. Collision, electrocution and breeding. Madrid: Quercus.,
30. Buuveibaatar, B., T.S.Strinberg, P.Kaczensky, J.Payne, B.Chmeddorj, G.Naranbaatar, S.Amarsaikhan, S.Dashnyam, Ts.Munkhzul, T.Purevsuren, D.A.Hosack, and

- T.K.Fuller. 2016. Mongolian Gobi supports the world's largest populations of khulan *Equus hemionus* and goitered gazelles *Gazella subgutturosa*. *Oryx*. 44(02): 285-292.,
31. Ferrer, M., de la Riva, M. and Castroviejo, J. 1991. Electrocutation of raptors on power lines in Southwestern Spain. *J. Field Ornithol.* 62: 181–190.,
 32. Harness, R., Gombobaatar S., Yosef, R. 2008. Mongolian distribution power lines and raptor electrocutions. *J. IEEE*: 52:1-6.,
 33. Hunting, K. 2002. A roadmap for PIER research on avian collosions with power lines in California. Technical report P500-02-071F. California Enegy Comission, Public Interest Energy Research (PIER) Programm, Sacramento.,
 34. Ito T.Y., N.Muira, B.Lhagvasuren, D.Enkhnilig, B.Buuveibaatar, B.Chimeddorj, T.Seiki, A.Tsunekawa and Z.Jiang. 2005. Preliminary evidence of barrier effect of railroad on migration of Mongolian Gazelles. *Proceedings of the Institute of Biology of the Mongolian Academy of Sciensec.* 25: 60-64.,
 35. Janss G.F.E and Ferrer M. 1999. Mitigation of raptor electrocution on steel power poles. *Wildlife Society Bulletion.* 27(2):263-273.,
 36. Kaczensky, P., B.Keutn, B.Lhagvasuren, S.Pietch, W.Yang and C.Walzer. 2011. Connectivity of the Asiatic wild ass population in the Mongolian Gobi. *Biological Conservation.* 144: 920-929.,
 37. Kruger R. and Rooyen C. 2000. Evaluating the Risk existing Powerlines pose to large Raptors by utilizing Risk Assessment Methodology: the Molopo Case Study. *Raptors at Risk.* WWGBR/Hancock House. 757-764.,
 38. Lkhagvasuren B., B.Chimeddorj and D.Sanjmyatav. 2011. Barriers to migration: Case study in Mongolia. *Analysing the Effects of Infrastructure on Migratory Terrestrial Mammals in Mongolia.* WWF Mongolia Programme Office. Ulaanbaatar 2011.,
 39. Olson K.A. 2012. *Wildlife Crossing Options Along Existing and Pianned Mongolian Railway Corridors.* Mongolia Discussion Pepers. East Asia and Pacific Sustainable Development Department Washington, D.C. World Bank.,
 40. Rooyen C. 2000. Raptor mortality on Powerlines in South Africa. *Raptors at Risk.* WWGBR/Hancock House. 739-740.,
 41. Schaler G.B. & Lhagvasuren B. 1999. Death amd Life on the Steppes. *WildlifeCoservation.* November/December. 12,

